



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**“МОНГОЛ УЛС ДАХЬ ЯЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙН
ТУХАЙ ХОЛИМОГ АРГЫГ АШИГЛАХ”
СУДАЛГААНЫ АЖЛЫН НЭМЭЛТ**

2022

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

Судалгааны захиалагч:

Хүний эрхийн үндэсний комисс

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааны Зөвлөх:

Р.Оюунбадам

Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Судалгааны багийн гишүүд:

Х.Буянбат

ХЗҮХ-ийн ХЗСТ-ийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн секторын Эрдэм шинжилгээний
ажилтан

О.Энххүслэн

ХЗҮХ-ийн ХЗСТ-ийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн секторын Эрдэм шинжилгээний
ажилтан

Судалгааны ажлын агуулга

УДИРТГАЛ	2
СУДАЛГАА ХИЙХ ШАЛТГААН НӨХЦӨЛ	2
СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ.....	3
СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	3
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	4
СУДАЛГААНЫ АЖЛЫН ШИНЭЛЭГ ТАЛ, АЧ ХОЛБОГДОЛ	4
НЭГ. ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БОЛОН ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ДЭГЛЭМИЙН СУДАЛГАА	5
1. Монгол Улс дахь хорих байгууллагын дэглэм, хоригдлын хөдөлмөр эрхлэлт, түүнд хамаарах эрх зүйн зохицуулалт	5
2. Хоригдлын хөдөлмөр эрхлэлт, зохион байгуулалт болон хорих байгууллагын дэглэмийн харьцуулсан судалгаа	10
3. Практик судалгаанд хийсэн дүн шинжилгээ	24
4. Явцын дүгнэлт, дүн шинжилгээ	30
ХОЁР. ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, САЛБАР ДУНДЫН БОДЛОГЫН УЯЛДАА ХОЛБОО	33
1. Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөрийн талаар төрөөс баримталж буй бодлого, салбар дундын бодлогын уялдаа холбоо	33
2. Гадаад орнуудын харьцуулсан судалгаа	40
3. Явцын дүгнэлт, дүн шинжилгээ	45
ГУРАВ. БҮХ НАСААР ХОРИХ ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА	48
1. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын ял эдэлж буй нөхцөл байдал, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийн байдал	48
2. Эрх зүйн зохицуулалт	49
3. Харьцуулсан судалгаа	54
ДӨРӨВ. СУРГАЛТ-ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГАД ХҮМҮҮЖИЖ БАЙГАА НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮМҮҮСИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА	58
1. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдал	58
2. Эрх зүйн зохицуулалт	60
ТАВ. ДҮГНЭЛТ	63
ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ	64

УДИРТГАЛ

СУДАЛГАА ХИЙХ ШАЛТГААН НӨХЦӨЛ

Хүний Эрхийн Үндэсний Комисс нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ILO)-ын санхүүжилтээр “Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал” судалгааг захиалан гүйцэтгүүлж байна. Энэхүү судалгааны хүрээнд Хүний Эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар эрх зүйн зохицуулалт, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, зохион байгуулалтын талаар нарийвчлан авч үзсэн юм. Тус судалгааны ажлаар нийтдээ 7 хорих ангид хяналт шалгалт, хийж гүйцэтгэсэн боловч нээлттэй, хаалттай хорих ангид ял эдэлж буй хоригдлуудаас гадна бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлууд болон сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөрийн асуудал орхигдсон байна. Түүнчлэн хорих ялын дэглэмээс хамаараад хөдөлмөр зохион байгуулалтыг хэрхэн зохицуулсан талаарх эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх, хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлого, салбар хоорондын бодлогын уялдаа холбоог судлах шаардлага гарсан.

Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн нь дээрх судалгаанд нэмэлтээр хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн орчин, төрөөс баримталж буй бодлого, бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа өсвөр насны хүмүүсийн нөхцөл байдал, хөдөлмөр эрхлэх боломж бололцоо, түүнтэй холбоотой эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж санал, зөвлөмж гаргахаар болсон билээ.

Монгол Улсад 2020 оны 12 дугаар сарын байдлаар нийт 2757 хоригдол хөдөлмөрөөр хангагдсан, 2021 оны 12 дугаар сарын байдлаар нийт 2045 хоригдол хөдөлмөрөөр хангагдсан, 2022 оны 12 дугаар сарын байдлаар 2896 хоригдол хөдөлмөрөөр хангагдсан¹ байна. Энэ нь 2020 онд бүртгэгдсэн нийт 3996 хоригдлын 68.9%, 2021 онд бүртгэгдсэн 2959 хоригдлын 69.1%, 2022 онд бүртгэгдсэн 4053 хоригдлын 71.4% юм.

2017 оны 6 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/”-д зааснаар хорих байгууллага нь нээлттэй, хаалттай хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, цагдан хорих төв, байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн хорих эмнэлэг /цаашид "хорих анги" гэх/, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвөөс бүрдэхээр зохицуулсан. Мөн дэглэм, зэрэглэлийг нээлттэй хорих ангийн энгийн болон тусгай зэрэглэл, хаалттай хорих ангийн энгийн болон тусгай зэрэглэл, тусгай нэгж байхаар тогтоожээ. Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал нь дээрх дэглэм, зэрэглэлээс хэрхэн хамаардаг нь тодорхойгүй байна.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын хувьд 2015 оны Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 8.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад байгаа насанд хүрээгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлэх эрх зүйн үндэслэл байхгүй. Гэвч бодит нөхцөл байдалд тухайн зохицуулалтын хэрэгжилт ямар байгаа, олон улсын гэрээнд хэрхэн зохицуулдаг болохыг судлах нь зүйтэй.

¹ 2020, 2021, 2022 оны холбогдох сарын хоригдлын хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, нэрийн дансны мэдээлэл

Түүнчлэн хаалттай хорих ангийн тусгай нэгж буюу бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлуудын хөдөлмөр эрхлэлтийн талаар тодруулах шаардлагатай байна. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын 200 дугаар зүйлийн 200.3 дахь хэсэгт зааснаар “Хоригдлыг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж болно.” гэж заажээ.

Үүнээс гадна хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар Монгол Улсад төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааг тодорхойлох, сайжруулах талаар зөвлөмж өгөх шаардлагатай байна.

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан, түүний дотор эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаарх асуудлыг судалсан бүтээл цөөн байдаг. Тухайлбал, А.Лхагваа “Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй”, УБ. 2004, М.Алтан-Очир “Хорих ял эдлүүлэх дэглэм”, УБ. 2020, С.Жанцан, “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургааль/”, УБ. 2014, Р.Оюунбадам, Д.Бадам “Хорих ял эдлүүлэх дэглэмийн эрх зүйн зохицуулалт”, УБ. 2005, Н.Лхагваа, С.Жанцан, “Монгол Улсын эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй. Ерөнхий ба тусгай ангийн сурах бичиг” зэрэг ном, сурах бичгүүдийн тодорхой хэсэг болж бичигдсэн бөгөөд дагнасан судалгааны ажлын тухайд хамгийн том нь 2016 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийсэн “Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн байдал:Практик судалгаа” юм.

Гэхдээ эдгээр судалгааны ажил, бүтээлүүдэд хоригдлын хөдөлмөр эрхлэлт болон дэглэм, зэрэглэлийн хоорондын хамаарал, хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа болон бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлуудын хөдөлмөр эрхлэлтийн талаар нарийвчилж судлаагүй байна.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Уг судалгааны зорилго нь Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлт болон хорих ангийн дэглэм, зэрэглэлийн холбоо хамаарал, хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримталж буй бодлого, салбар дундын зохицуулалт, бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол болон сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа өсвөр насны хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр дүгнэлт, зөвлөмж гаргахад чиглэнэ.

Судалгааны ажлын зорилгыг хангах үүднээс дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хорих ялын дэглэмээс хамаарч хөдөлмөр зохион байгуулалтыг хэрхэн зохицуулсан талаарх эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргах;
- Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримтлах бодлого, салбар дундын бодлогод дүн шинжилгээ хийх. Энэ ажлын хүрээнд хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр төрийн байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичиг, тэдгээрийн хэрэгжилт, онцлог, гадаад орны сайн туршлагын талаар судлах;
- Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол, түүний хөдөлмөр эрхлэлтийн байдлыг баримтжуулах, эдгээртэй холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулах;

- Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа өсвөр насны хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг баримтжуулах, эдгээртэй холбогдсон эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулах;

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Тус судалгааны хувьд эрх зүйн болон бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх аргаас гадна ганцаарчилсан болон бүлгээр ярилцлага хийх, хоригдлуудаас санал асуулга авах зэргээр ярилцлагын болон анкетын асуулгын аргыг ашигласан юм.

Эрх зүйн болон бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх аргын тухайд хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар нийт 14 хууль, журам, холбогдох бусад бодлогын баримт бичгийг судалсан.

Фокус ярилцлагын хувьд судалгааны хэмжээнд томилолтоор ажилласан хорих ангиуд болох ШШГЕГ-ын газрын харьяа Багануур дүүрэг дэх 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Хэнтий аймаг дахь 419 дүгээр нээлттэй хорих анги, ШШГЕГ-ын харьяа Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, 405 дугаар хаалттай хорих /Тусгай нэгж/ ангийн хөдөлмөр эрхэлж буй хоригдлууд, хорих ангийн алба хаагч, удирдлагаас тус тус фокус ярилцлагын аргаар судалгааг авсан.

Харин анкетын асуулгын тухайд ШШГЕГ-ын газрын харьяа Багануур дүүрэг дэх 427 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Хэнтий аймаг дахь 419 дүгээр нээлттэй хорих анги, ШШГЕГ-ын харьяа Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, 405 дугаар хаалттай хорих ангид хөдөлмөр эрхэлж буй нийт 247 хоригдлуудаас 46 асуулттай асуулгын аргаар судалгаа авсан болно. Улмаар эдгээр асуулгын үр дүнг SPSS програм ашиглан дүн шинжилгээ хийсэн болно.

СУДАЛГААНЫ АЖЛЫН ШИНЭЛЭГ ТАЛ, АЧ ХОЛБОГДОЛ

Энэхүү сэдвийн талаар өмнө нь тусгайлан судлаж байгаагүй бөгөөд судлах хэрэгцээ шаардлага тулгарч байсан юм.

Мөн ийнхүү судлахдаа баримт бичиг болон практикийн дүн шинжилгээг хослуулах замаар хийсэн бөгөөд гадаад улсуудын эрх зүйн зохицуулалтуудыг судлан сайн жишгийг тодорхойлохыг зорьсон юм.

Энэхүү судалгааны тухайд дараах ач холбогдол бүхий үр дүнд хүрсэн юм.

- Монгол Улсын хорих ял эдэлж буй хоригдлын хөдөлмөр эрхлэлт нь тухайн хорих ангийн дэглэм, зэрэглэлээс хэрхэн хамаардаг нь тодорхой болсон ба асуудлыг нээн илрүүлж, сайн жишгийг тодорхойлсон;
- Төрөөс баримталж буй хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодлого, салбар дундын зохицуулалтыг судлаж, сайн жишгийг тодорхойлсон;
- Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжигч насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг тодруулж, дүн шинжилгээ хийсэн;
- Бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг судалж, дүн шинжилгээ хийсэн болно.

НЭГ. ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БОЛОН ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ДЭГЛЭМИЙН СУДАЛГАА

1. Монгол Улс дахь хорих байгууллагын дэглэм, хоригдлын хөдөлмөр эрхлэлт, түүнд хамаарах эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын хорих байгууллага нь 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 263, 264 дүгээр зүйлд заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяанд байдаг ба нээлттэй, хаалттай хорих ангийн дэглэм, журмын дагуу хорих ял эдлүүлдэг. Өөрөөр хэлбэл Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг² болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар удирдлагыг хэрэгжүүлдэг гэсэн үг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 197 дугаар зүйлийн 197.1-т заасны дагуу хорих анги шинээр байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох, өөрчлөх асуудлыг Засгийн газар шийдвэрлэдэг. Үүний дагуу 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 204 дүгээр тогтоол, 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 304 дүгээр тогтоол, 2020 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн Засгийн газрын 82 дугаар тогтоол тус тус батлагдан гарсан бөгөөд хорих байгууллагыг дараах бүтэцтэй байхаар зохицуулжээ.

№	Хорих байгууллага	Байршил	Хорих ангийн дэглэм
1.	401 дүгээр анги-Нэгдсэн эмнэлэг	Улаанбаатар, Хан-Уул дүүрэг	Хаалттай
2.	405 дугаар анги	Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг	Хаалттай (Тусгай нэгж)
3.	Эмэгтэйчүүдийн 407 дугаар анги	Улаанбаатар, Баянзүрх дүүрэг	Нээлттэй, хаалттай
4.	409 дүгээр анги	Улаанбаатар, Баянзүрх дүүрэг	Хаалттай
5.	Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага	Улаанбаатар, Баянзүрх дүүрэг	-
6.	413 дугаар анги	Сэлэнгэ аймаг, Мандал сум	Нээлттэй, хаалттай
7.	415 дугаар анги	Төв аймаг, Баян сум	Хаалттай
8.	417 дугаар анги	Төв аймаг, Мөнгөнморьт сум	Нээлттэй
9.	419 дүгээр анги	Хэнтий аймаг, Өндөрхаан сум	Нээлттэй
10.	421 дүгээр анги	Улаанбаатар, Баянзүрх дүүрэг	Нээлттэй
11.	423 дугаар анги	Өвөрхангай, Хархорин сум	Нээлттэй, хаалттай
12.	425 дугаар анги	Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум	Нээлттэй
13.	427 дугаар анги	Төв аймгийн Баяндэлгэр сум, нийслэлийн Багануур дүүрэг	Хаалттай
14.	429 дүгээр анги- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг	Хаалттай
15.	433 дугаар анги	Сэлэнгэ аймаг, Мандал сум	Хаалттай
16.	435 дугаар анги	Дархан-Уул аймаг, Дархан сум	Хаалттай

² Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт”

17.	437 дугаар анги	Орхон аймаг, Баян-Өндөр сум	Нээлттэй
18.	439 дугаар анги	Булган аймаг, Орхон сум	Хаалттай
19.	441 дүгээр анги	Улаанбаатар, Баянзүрх дүүрэг	Нээлттэй
20.	445 дугаар анги	Дархан-Уул аймаг, Дархан сум	Нээлттэй
21.	457 дугаар анги	Ховд аймаг, Жаргалант сум	Нээлттэй, хаалттай
22.	Цагдан хорих 461 дүгээр анги	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг	Хаалттай
23.	Архангай аймаг дахь Цагдан хорих байр	Архангай аймаг, Эрдэнэбулган сум	Нээлттэй
24.	Баян-Өлгий аймаг дахь Цагдан хорих байр	Баян-Өлгий аймаг, Өлгий сум	Нээлттэй
25.	Баянхонгор аймаг дахь Цагдан хорих байр	Баянхонгор аймаг, Баянхонгор сум	Нээлттэй
26.	Булган аймаг дахь Цагдан хорих байр	Булган аймаг, Булган сум	Нээлттэй
27.	Говь-Алтай аймаг дахь Цагдан хорих байр	Говь-Алтай аймаг, Алтай сум	Нээлттэй
28.	Дорнод аймаг дахь Цагдан хорих байр	Дорнод аймаг, Хэрлэн сум	Нээлттэй
29.	Дорноговь аймаг дахь Цагдан хорих байр	Дорноговь аймаг, Сайншанд сум	Нээлттэй
30.	Дундговь аймаг дахь Цагдан хорих байр	Дундговь аймаг, Сайнцагаан сум	Нээлттэй
31.	Завхан аймаг дахь Цагдан хорих байр	Завхан аймаг, Улиастай сум	Нээлттэй
32.	Өвөрхангай аймаг дахь Цагдан хорих байр	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум	Нээлттэй
33.	Өмнөговь аймаг дахь Цагдан хорих байр	Өмнөговь аймаг, Даланзадгад сум	Нээлттэй
34.	Сүхбаатар аймаг дахь Цагдан хорих байр	Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум	Нээлттэй
35.	Сэлэнгэ аймаг дахь Цагдан хорих байр	Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум	Нээлттэй
36.	Төв аймаг дахь Цагдан хорих байр	Төв аймаг, Зуунмод сум	Нээлттэй
37.	Увс аймаг дахь Цагдан хорих байр	Увс аймаг, Улаангом сум	Нээлттэй
38.	Хөтөл дэх Цагдан хорих байр	Сэлэнгэ аймаг, Сайхан сум	Нээлттэй
39.	Тосонцэнгэл дэх Цагдан хорих байр	Завхан аймаг, Тосонцэнгэл сум	Нээлттэй

Монгол Улсын хорих байгууллагад 2020 оны байдлаар нийт 4489 хоригдол байсан³ ба энэ нь 100,000 хүн ам тутамд 133 хоригдол ногдож байна гэсэн үг.

Хорих ангийн дэглэмийн талаарх эрх зүйн зохицуулалт

³ “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2020”, (УБ, 2021), 102 дахь тал

2017 оны 6 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/”-ийн 198, 199 дүгээр зүйлд хорих ангийн дэглэмийн талаар дараах байдлаар хуульчилсан байна.

Хорих ангийн дэглэм	Хорих ангийн зэрэглэл	Хамаарагдах ялтнууд
Нээлттэй	Энгийн	Анх удаа гэмт хэрэг үйлдэж 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн хоригдол
	Тусгай	2 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл хаалттай хорих ангиас болон нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэлээс хуульд заасан журмын дагуу нээлттэй хорих ангид үргэлжлүүлэн ял эдлүүлэхээр шилжүүлсэн, урьд өмнө гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан хоригдол
Хаалттай	Энгийн	Санаатай гэмт хэрэг анх удаа үйлдэж 4-6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хөнгөн гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгүүлсэн хоригдол
	Тусгай	6 жил, түүнээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн, эсхүл урьд өмнө хүнд гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ял шийтгүүлж байсан хоригдол
	Тусгай нэгж	Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол

Тухайн хууль хэрэгжиж эхлэхээс өмнө 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” хэрэгжиж байсан бөгөөд уг хуульд хорих ангийн дэглэмийг дараах байдлаар зохицуулж байжээ.

Хорих ангийн дэглэм	Хамаарагдах ялтнууд
Жирийн	Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэнээс болон онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэй ялтан;
Чанга	Хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл урьд нь хорих ял эдэлж байсан, анх удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтан
Онцгой	Хоёр ба түүнээс дээш удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй ялтан
Гяндан	Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд Монгол Улсын Ерөнхийлөгчид хандаж уучлал хүсэх эрхтэй. Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд

Хорих ангийн дэглэм нь хамгийн анх 1931 онд батлагдсан “Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг сайжруулах ажлын тухай хууль”-д “хөдөөгийн ажил үйлдвэрлэлийн колони” гэж томъёологдсон нь одоогоор бол жирийн дэглэмтэй хорих анги байжээ⁴. Улмаар 1966 онд БНМАУ-ын “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль” батлагдахад Монгол Улсын ял эдлүүлэх байгууллагын төрөл, дэглэмийг шинэчлэн тогтоож жирийн, чанга, онцгой гэсэн дэглэмийн төрөлтэй байхаар тодорхойлжээ. Цаашлаад 1981 оны БНМАУ-ын “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль”, 1993 оны “Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх

⁴ А.Лхагваа, “Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй”, (УБ, 2004), 261 дэх тал.

тухай хууль”, 1996 оны “Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль”, 2002 оны “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-д энэхүү дэглэмийн төрлүүд нь өөрчлөгдсөөр ирсэн байна.

Хорих ангийн дэглэмээс хамаарсан хөдөлмөрийн талаарх эрх зүйн зохицуулалт

2017 оны 6 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/”-ийн 198, 199, 214 дүгээр зүйлд хорих ангийн дэглэмээс хамаарсан хөдөлмөрийн тухай хуульчилсан байна.

Хорих ангийн дэглэм	Хорих ангийн зэрэглэл	Хөдөлмөрлөх байршил	Хөдөлмөрлөх нөхцөл
Нээлттэй	Энгийн	Хоригдлыг хорих байгууллага өөрийн болон өөрийн хувь нийлүүлсэн, хамтарсан хуулийн этгээдэд, эсхүл бусад хуулийн этгээдтэй гэрээ байгуулан зохих хяналттайгаар болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аж ахуйн ажил, хаалттай хорих анги, цагдан хорих байр, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, хорих эмнэлгийн аж ахуйн үйлчилгээ зэрэгт хөдөлмөрлүүлж болно.	Тухайн хөдөлмөрт хамаарах хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэхээс гадна ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
	Тусгай	Хоригдлыг хорих байгууллага өөрийн болон өөрийн хувь нийлүүлсэн, хамтарсан хуулийн этгээдэд, эсхүл бусад хуулийн этгээдтэй гэрээ байгуулан зохих хяналттайгаар болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аж ахуйн ажил, хаалттай хорих анги, цагдан хорих байр, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, хорих эмнэлгийн аж ахуйн үйлчилгээ зэрэгт хөдөлмөрлүүлж болно.	Тухайн хөдөлмөрт хамаарах хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэхээс гадна хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
Хаалттай	Энгийн	Хоригдлыг зөвхөн хорих байгууллагын үйлдвэрлэлд хөдөлмөрлүүлнэ.	Тухайн хөдөлмөрт хамаарах хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэхээс гадна хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас өөрөөр тогтоож болно.
	Тусгай	Хоригдлыг зөвхөн хорих байгууллагын үйлдвэрлэлд хөдөлмөрлүүлнэ.	Тухайн хөдөлмөрт хамаарах хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэхээс гадна хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль

			тогтоомжид зааснаас өөрөөр тогтоож болно.
	Тусгай нэгж	Хоригдлыг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж болно.	Тухайн хөдөлмөрт хамаарах хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэхээс гадна хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас өөрөөр тогтоож болно.

Тухайн хууль хэрэгжиж эхлэхээс өмнө 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-д хорих ангийн дэглэмээс хамаарч хөдөлмөрийг дараах байдлаар зохион байгуулдаг байжээ.

Хорих ангийн дэглэм	Хамаарагдах ялтнууд	Хөдөлмөрлөх байршил	Хөдөлмөрлөх нөхцөл
Жирийн	Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, түүнчлэн онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэнээс болон онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсоноос бусад эмэгтэй ялтан;	Ялтныг хорих байгууллага өөрийн болон өөрийнхөө хувь нийлүүлсэн, хамтарсан аж ахуйн нэгжид, эсхүл бусад аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан зохих хяналттайгаар болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аж ахуй, гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, баривчлах ял эдлүүлэх болон сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих байрны аж ахуйн үйлчилгээнд ажиллуулж болно.	Тухайн хөдөлмөрт хамаарах хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэхээс гадна ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
Чанга	Хүнд гэмт хэрэг үйлдсэн, эсхүл урьд нь хорих ял эдэлж байсан, анх удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эрэгтэй ялтан, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтан	Ялтныг хорих байгууллага зөвхөн өөрийн үйлдвэрлэл дээр, харуул хамгаалалттай нөхцөлд хөдөлмөрлүүлнэ.	Тухайн хөдөлмөрт хамаарах хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэхээс гадна хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас өөрөөр тогтоож болно.
Онцгой	Хоёр ба түүнээс дээш удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эрэгтэй ялтан	Ялтныг хорих байгууллага зөвхөн өөрийн үйлдвэрлэл дээр, харуул	Тухайн хөдөлмөрт хамаарах хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны

		хамгаалалттай нөхцөлд хөдөлмөрлүүлнэ.	журамд нийцүүлэхээс гадна хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас өөрөөр тогтоож болно.
Гяндан	Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээд Монгол Улсын Ерөнхийлөгчид хандаж уучлал хүсэх эрхтэй. Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд	Ялтныг зөвхөн гяндангийн байранд хөдөлмөрлүүлж болно.	Тухайн хөдөлмөрт хамаарах хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэхээс гадна хоригдлын ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас өөрөөр тогтоож болно.

Хорих байгууллага дахь хоригдлын хөдөлмөр зохион байгуулалт нь ял эдлүүлэх дэглэмийн онцлогт тохирсон өөрийн өвөрмөц хэлбэртэй⁵.

2. Хоригдлын хөдөлмөр эрхлэлт, зохион байгуулалт болон хорих байгууллагын дэглэмийн харьцуулсан судалгаа

Хоригдлын хөдөлмөр болон хорих ангийн дэглэмийн уялдаа холбоог нарийвчлан судлахын тулд дэлхийн хэмжээнд бусад улсуудын хорих, засан хүмүүжүүлэх газруудад тухайн харилцааг хэрхэн тодорхойлдгийг судлах нь зүйтэй. Дэлхийн эрх зүйн системийг ангилан тодорхойлсон тодорхойлолтууд маш олон байдаг. Үүнээс Англи-Америкийн эрх зүйн систем, Эх газрын эрх зүйн систем, Скандинавын хосолсон эрх зүйн систем, Постсоциалист орнуудын холимог эрх зүйн систем, Япон, Филиппины хосолсон эрх зүйн системүүд гэж ангилсан ангиллыг тухайн судалгаанд ашиглах болно⁶. Ингэхдээ тухайн тогтолцоо бүрээс 1 улсыг сонгон авлаа.

2.1. Англи-Америкийн эрх зүйн системийн улс орнууд

АНУ-ын хорих байгууллагын дэглэм ба хөдөлмөр

АНУ-ын хорих байгууллага нь Хууль зүйн яамны харьяанд байдаг бөгөөд үндсэндээ Холбооны хорих товчоо, мужийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд удирдлагыг нь хэрэгжүүлдэг байна. АНУ-ын хорих байгууллагад 2019 оны байдлаар нийт 2,068,800⁷ хоригдол байсан. Энэ нь 100,000 хүн ам тутамд 629 хоригдол ногдож буй үзүүлэлт юм. Түүнчлэн нийт 4455 хорих байгууллага байдаг бөгөөд үүнээс 3163 нь орон нутгийн хорих анги, 1190 нь мужийн хорих анги, 102 нь холбооны хорих анги байна⁸.

А. Хорих байгууллагын дэглэм, зэрэглэл

⁵ А.Лхагваа, “Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй”, (УБ, 2004), 220 дахь тал.

⁶ Д.Баярсайхан, “Эрх зүйн онол”, (УБ, 2020), 5 дахь тал.

⁷ АНУ-ын Хууль зүйн статистикийн товчооноос мэдээлснээр 2019.06.30-ны байдлаар орон нутгийн шоронд 734,500, мужийн шоронд 1,159,900, холбооны шоронд 174,400 хоригдол байна. Үүнээс гадна Индиан бүсийн шоронд 84 (2018 оны дундуур 2870) хоригдол байгаа.

⁸ World prison brief: United States, <https://www.prisonstudies.org/country/united-states-america>

Холбооны хорих ангийн товчоо (BOP) нь 1930 оны 5-р сарын 14-ний өдрийн (ch.274, 46 Stat. 325) хуулиар үүсгэн байгуулагдсан бөгөөд Ерөнхийлөгч Херберт Гувер гарын үсэг зурсан.

Холбооны хорих ангийн товчоо (BOP)-ны зорилго нь гэмт хэрэгтнүүдийг аюулгүй, хүмүүнлэг, хэмнэлттэй, зохих хамгаалалттай, гэмт хэрэгтнүүдэд туслах ажил болон өөрийгөө сайжруулах бусад боломжоор хангаж хуулийг дээдэлдэг иргэн болоход туслах хорих анги, олон нийтэд түшиглэсэн хяналттай орчинд хорих замаар нийгмийг хамгаалахад оршино⁹.

Холбооны хорих ангийн товчоо (BOP) нь дараах байгууллагуудаас бүрддэг байна.

1. Холбооны улсын хорих анги
2. Удирдах газрууд
3. Дахин нийгэмшүүлэх төвүүд
4. Сургалтын төвүүд
5. Гэрээт хорих газар

Үүнээс холбооны улсын хорих ангиудийг тухайн судалгааны хүрээнд тусгайлан авч үзсэн болно.

Холбооны улсын хорих анги

АНУ-ын муж даяар байрладаг хорих ангиудад ажилчдын дийлэнх нь ажилладаг. Хоригдлуудыг зохих журмаар хорихын тулд тэдгээрийн аюулгүй байдлыг үндэслэн таван өөр түвшинд хорьдог. Энэхүү аюулгүй байдлын түвшин нь эргүүл, цамхаг, хамгаалалтын хэрэгсэл, илрүүлэх төхөөрөмж, ажилтан болон хоригдлуудын харьцаа, байрлах газар зэрэгт үндэслэдэг. Энэхүү байдлаар нь хамгийн бага, бага, дунд, өндөр, захиргааны гэх зэрэглэлд хуваадаг. Мөн аюулгүй байдлын өөр зэрэглэлтэй хорих ангиудыг нэг дор байрлуулж хорих ангийн цогцолборыг бий болгож болдог байна.

1. Аюулгүй байдлын зэрэглэл хамгийн бага хорих анги

Аюулгүй байдлын зэрэглэл хамгийн бага хорих ангийг өөрөөр Холбооны хорих ангийн кэмпүүд гэдэг бөгөөд хамгаалалтын байгууллагууд нь дотуур байртай, ажилтнууд болон хоригдлуудын харьцаа харьцангуй бага, хашаа нь нам эсвэл бүүр огт хашаагүй байдаг. Эдгээр байгууллагууд нь ажил болон хөтөлбөрүүдийг гүйцэтгэхэд чиглэсэн байдаг. Үүнд Алдерсон FPC, Брайан FPC, Дулут FPC, Монтгомери FPC, Morgantown FCI, Пенсакола FPC, Yankton FPC хорих ангиуд хамаарагддаг байна.

Олон тооны хорих байгууллагууд үндсэн байгууламжийн хажууд энэ төрлийн зэрэглэлтэй хорих ангитай байдаг. Ихэнхдээ дагуул хорих анги (SCPs) гэж нэрлэдэг эдгээр баазууд нь үндсэн байгууллага болон гадуур ажиллах хөтөлбөрүүдэд хоригдлуудыг хамруулдаг.

2. Аюулгүй байдлын зэрэглэл бага хорих анги

Аюулгүй байдлын зэрэглэл бага хорих анги (FCIs) нь давхар хашаатай, ихэвчлэн дотуур байр эсвэл кабинетийн зохион байгуулалттай бөгөөд ажил хөдөлмөр, тусгай

⁹ Organization, mission and functions manual: federal bureau of prisons, <https://www.justice.gov/doj/organization-mission-and-functions-manual-federal-bureau-prisons>

хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Аюулгүй байдлын зэрэглэл хамгийн бага хорих ангитай харьцуулахад эдгээр байгууллагуудын ажилтнууд болон хоригдлуудын харьцаа өндөр байдаг.

3. Аюулгүй байдлын зэрэглэл дунд хорих анги

Аюулгүй байдлын зэрэглэл дунд хорих ангиуд (мөн дунд зэргийн хамгаалалттай хоригдлуудыг байрлуулах зориулалттай USP) нь хорих ангийн хашааг маш сайн бэхжүүлсэн (ихэвчлэн цахилгаан илрүүлэх систем бүхий давхар хашаатай), ихэнхдээ камертай орон сууцтай байдаг бөгөөд олон төрлийн ажил хөдөлмөр, эмчилгээний хөтөлбөрүүдийг явуулдаг. Ажилтнууд болон хоригдлуудын харьцаа илүү өндөр байдаг ба бага аюулгүй байдлын зэрэглэлтэй хорих ангитай харьцуулахад дотоод хяналт нь илүү байдаг.

4. Аюулгүй байдлын зэрэглэл өндөр хорих анги

Өндөр аюулгүй байдлын зэрэглэлтэй хорих анги буюу АНУ-ын засан хүмүүжүүлэх газар (USP) нь өндөр хамгаалалт бүхий хашаатай (хана эсвэл өндөр хашаатай), олон болон нэг хүний камертай өрөөтэй, ажилтан болон хоригдлуудын харьцаа хамгийн өндөр, хоригдлуудын хөдөлгөөнийг нарийн хянадагаараа ялгаатай.

5. Цогцолбор бүхий хорих анги

Холбооны Засан хүмүүжүүлэх Цогцолборуудад (FCCs) зорилго, аюулгүй байдлын зэрэглэлээрээ ялгаа бүхий хорих ангиуд өөр хоорондоо ойр зайтай байрлана. Холбооны Засан хүмүүжүүлэх Цогцолборууд нь үйлчилгээгээ хуваалцах замаар үр ашгийг дээшлүүлж, ажилтнуудад аюулгүй байдлын олон түвшний байгууллагуудад туршлага хуримтлуулах боломжийг олгож, ойр орчмын нэмэлт нөөцтэй болсноор яаралтай тусламжийн бэлэн байдлыг сайжруулдаг.

6. Захиргааны хорих анги

Захиргааны хорих анги нь шүүхийн өмнөх шатан дахь гэмт хэрэгтнүүдийг саатуулах зэрэг тусгай үүрэг бүхий байгууллагууд юм. Мөн эрүүл мэндийн ноцтой буюу архаг өвчтэй хоригдлуудыг эмчлэх эсвэл онц аюултай, хүчирхийлэлд өртсөн, оргох хандлагатай хоригдлуудыг саатуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Захиргааны хорих анги нь Нийслэлийн Засан хүмүүжүүлэх төвүүд (MCC), Нийслэлийн Цагдан хорих төвүүд (MDCs), Холбооны Цагдан хорих төвүүд (FDCs), Холбооны Эрүүл Мэндийн Төвүүд (FMCs), Холбооны Дамжин өнгөрүүлэх Төв (FTC), Холбооны Хоригдлуудын Эрүүл Мэндийн Төв (MCFP), болон Захиргааны аюулгүй байдлын дээд зэрэглэл хорих анги (ADX) гэх байгууллагаас бүрддэг. Захиргааны аюулгүй байдлын дээд зэрэглэл бүхий хорих ангиас бусад захиргааны байгууламжууд нь аюулгүй байдлын бүх зэрэглэлийн хоригдлуудыг хорих боломжтой¹⁰.

Энэхүү аюулгүй байдлын зэрэглэлээр ангилагдсан хорих ангиудад дараах тооны хоригдлууд ял эдэлж байна¹¹.

¹⁰ About Our Facilities, https://www.bop.gov/about/facilities/federal_prisons.jsp

¹¹ Prison Security Levels | Inmate Classification Levels, <https://federalcriminaldefenseattorney.com/prison-life/prison-security-levels/#minimum-security-prisons>

Хорих ангийн аюулгүй байдлын зэрэглэл	Хамаарагдах хоригдлууд	Хоригдлын тоо
Аюулгүй байдлын хамгийн бага зэрэглэлтэй хорих анги	Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд, албадан гаргах гадаадын иргэд, төрийн албан хаагчдыг заналхийлсэн, оргон зайлсан, хүчирхийлэл үйлдсэн түүхтэй хоригдлуудаас бусад хоригдлууд	23 329
Аюулгүй байдлын Бага зэрэглэлтэй хорих анги	20 жилээс бага хорих ялтай хоригдлууд хамаарах бөгөөд бэлгийн хүчирхийлэл үйлдсэн хоригдлууд үүнд хамаарч болно.	56 328
Аюулгүй байдлын Дунд зэрэглэлтэй хорих анги	30 жилээс бага 20 жилээс их ялтай хоригдлууд	52 963
Аюулгүй байдлын Өндөр зэрэглэлтэй хорих анги	30 жилээс дээш ял авсан аюултай болон ноцтой байдлаар хүчирхийлэл үйлдсэн бүх төрлийн хоригдлууд тухайн хорих ангид байдаг.	19 849
Захиргааны хорих анги	Терроризмын хэргээр ял шийтгүүлсэн хоригдлууд болон ноцтой хүчирхийлэл үйлдэгчдийг ихэвчлэн байлгадаг. (USP FLORENCE ADMAX)	335

Үүнээс гадна “Prison” болон “Jail”-ийн хоорондын ялгааг авч үзэх нь зүйтэй. АНУ-ын Хууль зүйн статистикийн товчоо үүнийг тайлбарлахдаа “Jail” нь гэмт хэрэгтэн шүүх хуралд орохоор хүлээж буй, шүүхийн өмнөх шатанд байгаа тохиолдолд болон хөнгөн гэмт хэрэг үйлдэж 1 жилээс бага хорих ял авсан хоригдлуудыг хамааруулдаг. Харин “Prison” нь 1 жилээс дээш хорих ялаар шийтгүүлсэн хоригдлуудыг урт хугацаагаар хорих зориулалттай байгууллага юм¹².”

Б. Хорих байгууллага дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлт, зохион байгуулалт

АНУ-д хорих анги дахь хөдөлмөрийг ангилахдаа хорих байгууллагын зэрэглэлээс хамааруулдаггүй. Харин Хувийн ашгийн төлөөх хорих ангиуд, Хорих ангийн үйлдвэрлэлийг сайжруулах хөтөлбөр (PIECP), Мужийн хорих ангийн хөдөлмөр (PIECP-ээс гадуур), Холбооны хорих ангийн хөдөлмөр (PIECP-ээс гадуур) гэх хэлбэрээр хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг зохион байгуулдаг байна.

Ашгийн төлөөх хувийн хорих ангиуд

CoreCivic (хуучин CCA) компани, GEO групп зэрэг холбооны болон муж улсын байгууллагад хамгийн багадаа 126,000 хоригдол (2015 оны байдлаар) байдаг бөгөөд тэдний ихэнх нь мужаан, компьютерийн хэрэглээ, барилга, барилгын худалдаа, цахилгааны худалдаа, цэцэрлэгжүүлэлт, тохижилт, өрлөг, уран зураг, сантехникийн зэрэг салбарт ашгийн төлөө ажилладаг компаниуд байна. Цалин нь өдөрт 0.16 доллараас бага байж болох ч Теннесси муж дахь CoreCivic хорих ангид өндөр ур чадвар шаардсан ажилд нэг

¹² Breaking Down the Different Types of Prisons in America, <https://www.rasmussen.edu/degrees/justice-studies/blog/different-types-of-prisons/>

цагт 0.50 доллар олох боломжтой. Зарим ашгийн төлөөх хорих ангиуд Цагаачлалын алба болон Гаалийн алба (ICE)-нд хоригдлуудыг авдаг.

Хорих ангийн үйлдвэрлэлийг сайжруулах гэрчилгээний хөтөлбөр (PIECP)

PIECP нь хувийн хэвшлийн компаниудад хоригдлуудын ажлын байр бий болгох, хоригдлуудтай харьцах хамгийн наад захын стандартыг бий болгох, хорих ангид үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний худалдааг олон улсад худалдаалах боломжийг олгодог холбооны засгийн газрын хөтөлбөр юм. Ерөнхийдөө 5000 орчим хоригдол PIECP төсөл дээр ажилладаг.

Мужийн хорих ангийн хөдөлмөр (PIECP-ээс гадуур)

Нийтдээ 1,370,000 хоригдолтой муж улсын хорих ангиуд нь гадны компаниудын ажлын байранд хоригдлуудын тодорхой хувийг ажиллуулдаг. Олон хоригдлууд дотооддоо хоол хийх, цэвэрлэх, угаалга хийх зэрэг аж ахуйн ажил эрхэлдэг. Гэсэн хэдий ч олон мянган хоригдлууд бараа бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, мал аж ахуй эрхэлдэг компани эсвэл гадны компаниудын дуудлагын төвийн үйлчилгээ үзүүлдэг.

Холбооны хорих ангийн хөдөлмөр (PIECP-ээс гадуур)

2017 оны байдлаар Холбооны хорих ангийн үйлдвэрүүд ("UNICOR" худалдааны нэрээр ажилладаг) UNICOR хорих ангийн үйлдвэрт 16,891 хоригдол ажиллаж байгаа гэж мэдээлсэн боловч ойролцоогоор 18,000 хоригдол хөтөлбөрт хамрагдсан гэж мэдэгджээ. PIECP-ийн бус хоригдлууд 83 үйлдвэрт цагт ердөө 0.23-1.15 долларын цалин авдаг. UNICOR-ын хоригдлууд хувцас, шагнал, цагаан хэрэглэл, оффисын тавилгаас эхлээд түгээлт, 3D загварчлал, дуудлагын төвийн үйлчилгээ хүртэл олон төрлийн ажил үйлчилгээ эрхэлдэг¹³.

2.2. Эх газрын эрх зүйн системийн улс орнууд

ХБНГУ-ын хорих байгууллагын дэглэм ба хөдөлмөр

ХБНГУ-ын хорих байгууллага нь Хууль зүйн яамны харьяанд байдаг бөгөөд үндсэндээ 16 муж улсын хорих ангийн захиргаанаас удирдлагыг хэрэгжүүлдэг байна. ХБНГУ-ын хорих байгууллагад нийт 56,069 хоригдол хоригдож байна. Энэ нь 100,000 хүн ам тутамд 67 хоригдол ногдож буй үзүүлэлт юм. Түүнчлэн ХБНГУ-д нийт 179 хорих байгууллага байдаг¹⁴. Муж улсуудын хувьд дараах байдлаар хорих байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна¹⁵.

Муж улс	Хорих байгууллагын тоо
Баден-Вюртемберг	27
Бавари	38
Берлин	8
Бранденбург	6

¹³ Prison labor in the united states: an investor perspective, <https://missioninvestors.org/sites/default/files/resources/Prison%20Labor%20in%20the%20United%20States%20-%20An%20Investor%20Perspective.pdf>

¹⁴ World prison brief: Germany, <https://www.prisonstudies.org/country/germany>

¹⁵ Verzeichnis der Vollzugsanstalten in der Bundesrepublik Deutschland, https://justiz.de/onlinedienste/vollstreckungsplaene/vollzugsanstalten_deutschland.pdf

Бремен	8
Хамбург	5
Хэссен	17
Мекленбург-Баруун Померан	7
Доод Саксони	19
Хойд Райн-Вестфален	43
Райнланд-Пфальц	10
Саарланд	3
Саксон	11
Саксон-Анхальт	12
Шлезвиг-Холштейн	7
Тюринген	5

А. Хорих байгууллагын дэглэм, зэрэглэл

ХБНГУ-ын 1976 оны 3 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан “Хорих ялыг гүйцэтгэх, эрх чөлөөг хязгаарлахаас урьдчилан сэргийлэх, шинэчлэлийн арга хэмжээний тухай хууль¹⁶”-д хорих байгууллагын дэглэмийг ерөнхийд нь зохицуулсан байна.

Тус хуулийн 3 дугаар зүйл нь “Хорих байгууллагын дэглэм” гэх нэртэй байх ба дараах агуулгатай байна.

- Хорих ангиудад амьдрах хугацааг амьдралын ерөнхий нөхцөлтэй аль болох ойртуулах ёстой;

- Хорих ялын аливаа сөрөг үр дагаврын эсрэг үйл ажиллагааг явуулах;

- Хорих байгууллага нь хоригдолд өөрийгөө эрх чөлөөт амьдралдаа эргэн оруулахад нь туслахаар төлөвлөгдсөн байна.

Монгол Улстай харьцуулахад ХБНГУ-ын дэглэмтэй холбоотой зохицуулалт нь хоригдлын эрх чөлөөг хамгаалах, нийгэмшүүлэх зарчмын шинжтэй заалт байна. Харин Монгол Улсад зохицуулсантай адил хорих байгууллагын дэглэмийг байгууллагын төрөл гэх агуулгаар хуульчилсан байна.

“Хорих ялыг гүйцэтгэх, эрх чөлөөг хязгаарлахаас урьдчилан сэргийлэх, шинэчлэлийн арга хэмжээний тухай хууль”-ийн 10 дугаар зүйлд зааснаар нээлттэй хорих байгууллага, хаалттай хорих байгууллага байхаар дэглэмийг тодорхойлсон.

Нээлттэй хорих байгууллага	Хаалттай хорих байгууллага
Хоригдол тусгай шаардлагыг хангасан тохиолдолд түүний зөвшөөрлөөр нээлттэй хорих байгууллага, нэгжид шилжүүлнэ. Ялангуяа нээлттэй хорих байгууллагад гэмт хэрэг үйлдэхгүй, оргохгүй гэх баталгаатай хоригдлыг шилжүүлдэг.	Бусад тохиолдолд хоригдлуудыг шаардлагатай бол хаалттай хорих байгууллагад шилжүүлнэ.

¹⁶ Prison Act of 16 March 1976 (Federal Law Gazette Part I p. 581, 2088), as last amended by Article 1 of the Act of 19 June 2019 (Federal Law Gazette I p. 840)

Нээлттэй хорих байгууллага нь хаалттай хорих байгууллагаас ялгаатай нь оргон зайлахаас сэргийлэх арга хэмжээг бага авдаг. Энэ нь хоригдлоос өөрийгөө сахилга бат, нийгмийн ур чадвар, өөрийгөө хянах тогтолцоонд сайн дураараа нэгдэхийг шаарддаг бөгөөд "чөлөөт амьдралын дүрмийг хэрэгжүүлэх" (дахин нийгэмшүүлэх) сүүлчийн бөгөөд хамгийн чухал алхам юм. Ерөнхийдөө хоригдол өглөө хорих байрнаас гараад ажлын байрандаа очно гэсэн үг. Ажлаа дуусгаад тэр даруй хорих байгууллагад буцаж ирээд, амардаг. Тус байгууллагад хоригдол амралт, спорт, эмчилгээний арга хэмжээнд оролцох боломжтой. Гэсэн хэдий ч нээлттэй хорих ангид хоригдож буй хоригдол тогтоосон дүрмийг чанд дагаж мөрдөх ёстой. Согтууруулах ундааны хэрэглээ, эсвэл тухайн байрлалд очих хугацаа хэтрүүлэх зэрэг нь хоригдлыг хаалттай хорих анги руу шилжүүлэх үндэслэл болдог.

2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ХБНГУ-ын нийт 44000 хоригдлын 6000 хоригдол буюу 14 хувь нь нээлттэй хорих байгууллагад хорих ял эдэлж байна¹⁷.

Хаалттай хорих байгууллагад гэмт хэрэг үйлдсэн болон оргон зайлах, гэмт хэрэг давтан үйлдэх эрсдэлтэй хүмүүсийг гадаад ертөнцөөс бие махбодийн хувьд тусгаарлан хорьдог.

Гарахад тохиромжтой гэж үзсэн хоригдлуудаас бусад хоригдлуудын гадаад ертөнцтэй холбогдох харилцааг хязгаарлаж зөвхөн хяналттайгаар ойр дотны хүмүүстэй нь уулзуулж, захидлаар харилцуулдаг. Хоригдлын камерууд цоожтой байдаг бөгөөд зөвхөн тодорхой цагт нээгддэг.

Б. Хорих байгууллага дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлт, зохион байгуулалт

ХБНГУ-ын 1976 онд батлагдсан "Хорих ялыг гүйцэтгэх, эрх чөлөөг хязгаарлахаас урьдчилан сэргийлэх, шинэчлэлийн арга хэмжээний тухай хууль"¹⁸-д зааснаар хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг зохион байгуулж байна. Үүнийг тус хуульд тусгахдаа хөдөлмөрлөх үүрэг болгон дараах байдлаар тусгасан байна.

Хоригдол нь өөрт оногдсон ажил, бие бялдрын чадавхи, биеийн байдлаас шалтгаалан хийж чадах ажил болон бусад мэргэжлийнхээ дагуу гүйцэтгэх ажлыг хийх үүрэгтэй. Жилд гурван сар хүртэлх хугацаагаар эсвэл зөвшөөрвөл түүнээс удаан хугацаагаар тухайн байгууллагад туслах ажил хийх үүрэгтэй байж болно. Хөдөлмөр эрхэлж байгаа эхийг хамгаалах зорилгоор хөдөлмөр эрхлэхийг хориглосон хууль тогтоомжийн заалт байгаа тул 65-аас дээш насны хоригдлууд болон жирэмсэн эх, нярай хүүхэдтэй хөхүүл эхчүүд хөдөлмөр эрхэлдэггүй. Ажил хийлгэхийн тулд хоригдлоос зөвшөөрөл авах шаардлагатай.

Үүнээс гадна тус хуульд хоригдлын ажил, амралтын байр, хөдөлмөр эрхлэх мэргэжлийн сургалтад хамрагдах, ажлын хөлс, чөлөө олгох гэх мэт асуудлуудыг тусгайлан зохицуулсан байна. Мөн ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалтад хоригдлуудыг дэглэмээс хамааруулан ялгаатай нөхцөл байдалд ажиллуулдаггүй байна.

¹⁷ Federal Statistical Office Germany, penal system - demographic and criminological characteristics of the prisoners on 31.03. - Subject series 10 row 4.1 - 2021,

¹⁸ Prison Act of 16 March 1976 (Federal Law Gazette Part I p. 581, 2088), as last amended by Article 1 of the Act of 19 June 2019 (Federal Law Gazette I p. 840)

Холбооны муж улсуудын хорих ангиуд нь дараах 8 чиглэлээр хоригдлыг ажиллуулдаг байна. Үүнд:

1. Аж ахуйн ажил
2. Хувийн компанид ажиллах
3. Бизнес эрхэлдэг компанид ажиллах
4. Бие даасан хөдөлмөрийн харилцаанд ажиллах
5. Хувиараа хөдөлмөр эрхлэх
6. Хөдөлмөрт суурилсан эмчилгээ
7. Сургалт
8. Боловсролын болон бусад үйл ажиллагаа¹⁹ хамаарна.

Үүнээс гадна тухайн муж улсын хорих байгууллагууд нь тус тусдаа хөдөлмөрийг төрөлжүүлэн хийлгэдэг байна. Тухайлбал, Хэссен мужид хоригдлуудыг мэргэшлийнх нь дагуу дараах хувийн аж ахуйн нэгж, туслах компаниудад ажиллуулдаг.

- Металын үйлдвэр
- Хэвлэл мэдээллийн цех, хэвлэлийн бэлтгэл
- Гар урлалын ном хавтаслах үйлдвэр
- Үйлдвэрийн ном хавтаслах компани²⁰

Мөн Доод Саксони буюу Niedersachsen мужид дараах төрлийн ажилд хоригдлуудыг хамруулдаг байна.

- Институтын өөрийн мужааны болон металл боловсруулах цехэд,
- Шийдвэр гүйцэтгэх хэлтэст;
- Захиргааны байранд;
- Гадаа байгууламж, ногоон байгууламжид,
- Хог хаягдал зайлуулах;
- Барилгын засвар үйлчилгээ;
- Гал тогоонд;
- Угаалгын газар;
- Хоригдлын хувийн эд зүйлсийг хадгалдаг хувцасны өрөөнд тус тус ажилладаг байна²¹.

2.3. Скандинавын хосолсон эрх зүйн системийн улс орнууд

Норвеги улсын хорих байгууллагын дэглэм ба хоригдлын хөдөлмөр

Норвеги улсын хорих байгууллага нь Хууль зүй, олон нийтийн аюулгүй байдлын яамны харьяанд байдаг бөгөөд үндсэндээ Засан хүмүүжүүлэх алба удирдлагыг нь

¹⁹ Schriften zum Strafvollzug, Jugendstrafrecht und zur Kriminologie, Johannes Hillebrand, "Organisation und Ausgestaltung der Gefangenearbeit in Deutschland", p. 182, https://rsf.uni-greifswald.de/storages/uni-greifswald/fakultaet/rsf/lehrstuehle/ls-harrendorf/Bd34_9783936999587.pdf

²⁰ JUSTIZVOLLZUGSANSTALT DARMSTADT Arbeit der Gefangenen, <https://justizvollzug.hessen.de/justizvollzug/jva-darmstadt/ausgestaltung-des-vollzuges/arbeit-der-gefangenen>

²¹ Arbeit für Gefangene, https://www.justizvollzugsanstalt-hannover.niedersachsen.de/startseite/arbeit Produktion/arbeit_fur_gefangene/arbeit-fuer-gefangene-82259.html

хэрэгжүүлдэг байна. Норвегийн Хант улсын хорих байгууллагад нийт 3032 хоригдол хоригдож байна. Энэ нь 100,000 хүн ам тутамд 56 хоригдол ногдож буй үзүүлэлт юм. Түүнчлэн Норвегийн Хант улс нь 2021 оны байдлаар нийт 33 хорих байгууллагатай байна²².

Норвегийн Хант улсын 2002 оны 3 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан “Ял гүйцэтгэх тухай хууль”-иар хорих байгууллагын талаар зохицуулдаг байна. Тус хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Норвегийн Засан хүмүүжүүлэх алба нь Норвегийн Засан хүмүүжүүлэх албаны захиргаа, бүс нутгийн болон орон нутгийн түвшинд зохион байгуулагддаг. 2020 оны байдлаар Норвегийн Засан хүмүүжүүлэх албаны харьяанд бүс нутгийн байгууллагууд болон Норвегийн Засан хүмүүжүүлэх албаны сургууль байгуулагдсан байна. Бүс нутгийн байгууллага нь дотроо хорих байгууллага, түр саатуулах газар, тэнсэн харгалзах алба, шүүхийн хяналт бүхий хар тамхины хөтөлбөрийн газар гэх байгууллагуудаас бүрдэж байна²³.

Норвеги улс нийтдээ 33 нэгж бүхий 58 хорих ангитай ба 3600 гаруй камерын багтаамжтай. Эдгээрийн бараг 70% нь өндөр хамгаалалттай хорих анги байдаг²⁴.

А. Хорих байгууллагын дэглэм, зэрэглэл

Норвеги улсын “Ял гүйцэтгэх тухай хууль”-д зааснаар хорих байгууллагын дэглэм, зэрэглэл гэж байдаггүй бөгөөд үүнийг хорих байгууллагын төрөл гэх байдлаар томъёолсон байна. Хорих байгууллагын төрлийг дараах байдлаар хуульчилжээ.

- Өндөр хамгаалалттай хорих ангиуд (хаалттай хорих ангиуд);
- Аюулгүй байдлын түвшин доогуур хорих ангиуд (нээлттэй хорих ангиуд);
- Нийгэмшүүлэх төв;
- Тусгай нөхцөлөөр хорих ангиас гадуур байлгах;
- Тэнсэх журмаар хорих;

Өндөр хамгаалалттай хорих ангиуд (хаалттай хорих ангиуд)-ын хувьд онцгой хорих хэрэгцээтэй хоригдлууд, тэр дундаа цагдан хоригдсон хоригдлууд, бусад төрлийн хорих ангиас шилжин ирсэн хоригдлууд хамаардаг.

Аюулгүй байдлын түвшин доогуур хорих ангиуд (нээлттэй хорих ангиуд)-д хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн хоригдлуудыг хуваарилдаг. Аюултай гэж тодорхойлогдсон эсхүл ялтан ялыг биелүүлэхээс зайлсхийсэн гэж үзэх үндэслэл байвал тухайн хорих ангид шилжүүлэхгүй. Зарим онцгой тохиолдолд ялтан 2 жилээс дээш хорих ял эдлэх байсан ч тухайн хоригдлыг тус хорих байгууллагад хуваарилж болдог.

Хорих ял хугацаа 1 жилээс доош тохиолдолд Нийгэмшүүлэх төвд ял эдлүүлдэг байна.

²² World prison brief: Norway, <https://www.prisonstudies.org/country/norway>

²³ The Norwegian correctional service, 2020 ANNUAL REPORT, p.6

²⁴ Organisation of Norwegian correctional service, <https://www.kriminalomsorgen.no/informasjon-paa-engelsk.536003.en.html>

Норвегийн Засан хүмүүжүүлэх алба нь дээрх төрлүүдийг өргөжүүлэн нийт 10 төрлөөр үйл ажиллагаагаа явуулж байна²⁵. Хорих байгууллагын эдгээр төрлүүд нь ял эдлүүлэх зохион байгуулалт, журам зэргээр хоорондоо ялгаатай.

№	Хорих байгууллагын төрөл	Зохион байгуулалт
1.	Өндөр хамгаалалттай хорих анги	Хорих ангийн эргэн тойронд хана эсвэл өндөр хашаа байх бөгөөд бүх хаалга нь үндсэндээ цоожтой байдаг. Хоригдлууд ажил, сургууль, чөлөөт цагаа өнгөрөөх арга хэмжээнд оролцохгүй байх үед хорих ангийн ажилтнуудын хяналтан дор хорих өрөөнд цоожлогддог.
2.	Аюулгүй байдлын түвшин доогуур хорих анги	Өндөр хамгаалалттай хорих ангиас хязгаарлатын арга хэмжээ багатай боловч ихэвчлэн хорих ангийн эргэн тойронд хашаатай байдаг ба хоригдлуудыг тухайн газраас гарахыг хориглодог. Өрөөнүүд нь шөнөдөө цоожлогддог бөгөөд бусад үед нээлттэй байж хоригдлууд үйл ажиллагаанд чөлөөтэй хамрагдаж нийгэмшдэг.
3.	Шилжилтийн нийгэмшүүлэх төв	Хорих анги хэдий ч бусад хорих байгууллагыг бодвол хязгаарлалт багатай байдаг
4.	Онцгой өндөр хамгаалалттай хорих анги	Өндөр хамгаалалттай хорих ангиас илүү хязгаарлалт бүхий хорих байгууллага юм. Үүнд ихэвчлэн оргох магадлалтай болон ноцтой гэмт хэрэг үйлдсэн хүмүүс хамаардаг.
5.	Цагдан хорих байгууллага	Энгийн тодорхой хугацаа бүхий хорих байгууллагад ял эдлэх нь үр дүнгүй болсон хоригдлуудыг цагдан хорих замаар хорьж тусгаарлах байгууллага.
6.	Тусгай байгууллага	Зарим хоригдлуудад эмчилгээ, нийгэмшүүлэх ажил, хөдөлмөрийн сургалт эсвэл хорих ангид хангах боломжгүй бусад зүйл хэрэгтэй байж болох учраас тус байгууллага үүнийг хангадаг.
7.	Эмэгтэйчүүдийн хорих анги	Эмэгтэйчүүд аль болох хорих ангид байх цагаа эмэгтэйчүүдийн хорих ангид эсвэл эмэгтэйчүүдэд зориулсан хорих ангид өнгөрүүлэх ёстой.
8.	Цагаачлалын хорих анги (Kongsvinger)	Гадаадын цагаач хоригдлыг хүлээн авдаг хорих анги юм.
9.	Хүүхдийн хорих анги	15-18 насны хүнийг хорих зориулалттай хорих анги юм.
10.	Цахимаар хянах газар	Шагайнд нь хяналтын хэрэгсэл суулгаж хянах газар юм.

Б. Хорих байгууллага дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлт, зохион байгуулалт

Норвеги улсын “Ял гүйцэтгэх тухай хууль”-д хоригдлын хөдөлмөрийн талаар тусгайлан заагаагүй.

Хөдөлмөрийн үйл ажиллагаа нь хүмүүжүүлэх байгууллагуудын үйл ажиллагааны хамгийн том хэсэг бөгөөд Норвегийн хорих ангийн хоригдлуудын өдөр тутмын үйл ажиллагаа юм.

Ажлын хувьд мод, металл, нэхмэл эдлэл, керамик, гар урлалын төрөл бүрийн үйлдвэрлэлийн цехүүдээс бүрддэг. Мөн угаалга, цэвэрлэгээ, гадна болон дотоод засвар

²⁵ Type fengsel og soningsformer, <https://www.kriminalomsorgen.no/type-fengsel-og-sikkerhetsnivaa.516316.no.html>

үйлчилгээ зэрэг гал тогооны болон ашиглалт/үйлчилгээний ажил хамаарна. Тус цехүүдэд мэргэжлийн ур чадвар, практик боловсрол эзэмшсэн хүмүүсийг ажиллуулдаг.

Үүнээс гадна хоригдлууд зарим тохиолдолд суллагдсанахаа дараа хорих ангийн гадна ажиллах боломжтой байдаг.

Эдгээр ажлын санал нь хоригдлыг сургах, бусадтай харилцах боломжийг бүрдүүлэхээс гадна ажлын хэвийн нөхцөлтэй байх ёстой²⁶.

Норвеги улсад хоригдлууд заавал ажиллах үүрэггүй байдаг. Гэхдээ бүх хоригдлуудыг ажиллахыг зөвшөөрсөн байдаг. Хоригдлуудыг ямар нэг байдлаар шийтгэл хэлбэрээр ажиллуулж болохгүй. Ажиллахын тулд хоригдлууд хорих байгууллагын захиргаанд хүсэлт гарган ажил эрхэлдэг байна. Хорих ангийн захиргаа үүний дагуу хөдөлмөрийг зохион байгуулдаг ба өөрийн ажиллах сонирхолтой байгаа газар руу нь шилжүүлдэг. Хоригдлууд ямар нэг байдлаар хөдөлмөрийн гэрээ байгуулдаггүй ба хорих ангиас гадуур ажиллаж болдог. Ажлын өдөр ихэвчлэн өглөө 8:00 цагт эхэлж, 15:00 цагт дуусдаг. Үдийн завсарлагатай байх бөгөөд өдөрт найман цагаас илүүгүй ажиллана. Хоригдлууд долоо хоногт хоёр өдөр амардаг. Хоригдлууд ажиллахдаа хөдөлмөрийн хөлс авдаг ба энэхүү хөдөлмөрийн хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоогддог (65 NOK (цагт 7 евро)). Хорих ангид эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартыг дагаж мөрддөг²⁷.

Дээрхээс дүгнэвэл Норвеги улс дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлт нь хорих байгууллагын дэглэм, зэрэглэл, төрлөөс хамаардаггүй байна.

2.4. Постсоциалист орнуудын холимог эрх зүйн системийн улс орнууд

Бүгд Найрамдах Эстони Улсын хорих байгууллагын дэглэм ба хөдөлмөр

Бүгд Найрамдах Эстони улсын хорих байгууллага нь Дотоод хэргийн яамны харьяанд байдаг бөгөөд үндсэндээ Хорих ангийн хэлтэс удирдлагыг хэрэгжүүлдэг байна. Бүгд Найрамдах Эстони улсын хорих байгууллагад нийт 2112 хоригдол хоригдож байна. Энэ нь 100,000 хүн ам тутамд 159 хоригдол ногдож буй үзүүлэлт юм. Түүнчлэн Бүгд Найрамдах Эстони улс нь 2021 оны байдлаар нийт 3 хорих байгууллагатай байна²⁸.

Бүгд Найрамдах Эстони улсын хорих байгууллага нь Хууль зүйн яамны хорих байгууллагын удирдлагын газар, Таллин хорих анги, Тарту хорих анги, Виругийн хорих анги, Хорих байгууллагын зөвлөл гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Хууль зүйн яамны хорих байгууллагын удирдлагын газар нь Эстонийн хорих албаны төв байгууллага бөгөөд хорих ангиудын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хөгжүүлэх үүргийг хүлээдэг. Тус байгууллага нь Шийдвэр гүйцэтгэх хэлтэс, Нийгэмшүүлэх хэлтэс, Хууль эрх зүй, хөгжлийн хэлтэс, Дотоод хяналтын хэлтэс гэсэн хэсгүүдээс бүрддэг.

²⁶ Arbeids- og aktivitetstilbud, <https://www.kriminalomsorgen.no/arbeids-og-aktivitetstilbud.527951.no.html>

²⁷ Norway prison, <https://www.prison-insider.com/countryprofile/prisons-norway2019?s=vie-quotidienne#vie-quotidienne>

²⁸ World prison brief: Estonia, <https://www.prisonstudies.org/country/estonia>

Хорих байгууллагын зөвлөл нь хоригдлуудын үндсэн эрхийг эдлүүлэх зорилготой хорих байгууллагыг хаалттай бус нээлттэй байлгах үүднээс зохион байгуулагдсан иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллаж ил тод байдлыг хангадаг байгууллага юм.

Хорих анги буюу хорих ангийн тухайд дараах байдлаар зохион байгуулагдсан байна²⁹.

№	Хорих ангийн нэр	Хорих ангийн төрөл	Хоригдлын төрөл	Хоригдлын тоо
1.	Таллин хорих анги	шүүх хурал болтол цагдан хоригдож буй хоригдлуудын хаалттай хорих байгууламжууд; хорих ангиудад хоригдож буй хоригдлуудын хаалттай хорих анги; нээлттэй хорих анги	цагдан хоригдож буй эрэгтэй, эмэгтэй хүмүүс; насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс	нээлттэй хорих ангийн 102, бусад төрлийн хоригдлууд 1190
2.	Тарту хорих анги	хорих ангиудад хоригдож буй хоригдлуудын хаалттай хорих анги; нээлттэй хорих анги	цагдан хоригдож буй эрэгтэй, эмэгтэй хүмүүс; насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс	нээлттэй хорих ангийн 60, бусад төрлийн хоригдлууд 933
3.	Виругийн хорих анги	хорих ангиудад хоригдож буй хоригдлуудын хаалттай хорих анги; нээлттэй хорих анги	цагдан хоригдож буй эрэгтэй, эмэгтэй хүмүүс; насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс	нээлттэй хорих ангийн 75, бусад төрлийн хоригдлууд 974

А. Хорих байгууллагын дэглэм, зэрэглэл

Бүгд Найрамдах Эстони улсын 2000 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр хүчин төгөлдөр болсон “Хорих ял эдлүүлэх тухай” хуулиар хорих байгууллагын дэглэм, зэрэглэлийг зохицуулсан байна. Тус хууль нь ерөнхийдөө хорих ял эдлүүлэх, цагдан хорих, баривчлах зохион байгуулалт, хорих ангийн үйлчилгээ болон алба хаагчийн тодорхойлолт, нөхцөлийг тусгасан.

Тус хуулийн 6 дугаар зүйлд хорих байгууллагыг нээлттэй, хаалттай байдлаар зохион байгуулахыг тусгасан бол 7,8,9,10 дугаар зүйлүүдэд түүнийг тодорхойлжээ³⁰.

Хорих байгууллагын дэглэм	Тодорхойлолт	Ерөнхий нөхцөл байдал
Хаалттай хорих анги	Хаалттай хорих анги гэдэг нь хоригдлуудыг байнга хянах боломжийг олгодог харуул хамгаалалттай хана эсвэл бусад хаалт бүхий хорих анги юм.	Хоригдлууд хаалттай хорих ангийн нутаг дэвсгэрт хорих байгууллагын дотоод дүрэм, журамд заасан байршил, цагт шилжин явахыг зөвшөөрнө. Үүнээс бусад үед цоожтой өрөөнд тусгаарлана.
Нээлттэй хорих анги	Нээлттэй хорих анги гэдэг нь тодорхой харагдах тэмдэг	Хоригдлууд сэрэх цагаас эхлэн гэрэл унтартал нээлттэй хорих ангийн нутаг

²⁹ Justitsministeerium, institution, <https://www.vangla.ee/en/intitutions>

³⁰ Imprisonment Act (Passed 14.06.2000, RT I 2000, 58, 376, Entry into force 01.12.2000), <https://www.riigiteataja.ee/en/eli/504112013005/consolide>

	бүхий газар нутагтай хорих анги юм.	дэвсгэрт чөлөөтэй зорчихыг зөвшөөрдөг. Хорих ангийн зөвшөөрлөөр ялтныг сурч боловсрох, ажил хийх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхтэй нь холбогдуулан хорих ангийн нутаг дэвсгэрээс гадуур гарахыг зөвшөөрдөг. Шаардлагатай бол гэрэл унтарсны дараа хоригдлыг цоожтой өрөөнд хорьж болдог.
--	-------------------------------------	--

Б. Хорих байгууллага дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлт, зохион байгуулалт

Бүгд Найрамдах Эстони улсын 2000 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр хүчин төгөлдөр болсон “Хорих ял эдлүүлэх тухай” хуулиар хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар хуульчлан зохицуулжээ.

Хоригдлууд нь хуульд өөрөөр заагаагүй бол ажиллах ёстой. Жаран гурваас дээш насны хоригдлууд, ерөнхий болон мэргэжлийн боловсрол эзэмшиж байгаа, мэргэжлийн сургалтад хамрагдаж буй хоригдлууд, эрүүл мэндийн шалтгаанаар ажиллах боломжгүй хоригдлууд, 3-аас доош насны хүүхэд өсгөж буй хоригдлуудыг ажиллуулж болохгүй. Ажлын зохион байгуулалтын хэлбэр, агуулга нь хорих ангиас гадуурх ажлын зохион байгуулалттай аль болох нийцсэн байх ёстой.

Хорих ангийн алба нь хоригдлын бие бялдар, оюун санааны чадвар, бусад ур чадварыг харгалзан ялтны ажилтай байх боломжоор хангана. Хэрэв хоригдлыг ажлын байраар хангах боломжгүй бол хорих ангийн засвар үйлчилгээнд оролцохыг шаардана. Мөн үүнээс гадна хорих анги нь тус бүс дотроо эсвэл байгууллагын гадна үйлдвэр барьж эсвэл хорих ангиас гадуур ажиллуулж болно.

Хоригдлын ажиллах нөхцөл нь хөдөлмөр, хамгаалалтай холбоотой хуульд зааснаар зохицуулагдана. Хоригдлуудыг зөвшөөрсөн тохиолдолд илүү цагаар болон бүх нийтээр амрах баярын өдрүүдээр ажиллуулах боломжтой. Хоригдлыг шинээр гэмт хэрэг үйлдэхгүй гэж үзэх хангалттай үндэслэл байгаа тохиолдолд хуульд заасан шаардлагыг хангасан бол түүний зөвшөөрлөөр хорих ангиас гадуур хяналт, ажиглалт дор ажиллахыг зөвшөөрнө. Хөдөлмөр эрхэлж буй хоригдлууд цалин хөлс авна. Хорих ангийн засвар үйлчилгээнд оролцох шаардлагатай хоригдлуудад мөн цалин хөлс олгоно. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10 хувиас багагүй байна.

Бүгд Найрамдах Эстони улсын эрх зүйн зохицуулалтад хоригдлыг хорих байгууллагын дэглэм, зэрэглэлээс хамааруулан ажиллуулах зохицуулалт байхгүй болох нь тогтоогдож байна.

2.5. Япон, Филиппины хосолсон эрх зүйн системийн улс орнууд

Япон улсын хорих байгууллагын дэглэм ба хөдөлмөр

Япон улсын хорих байгууллага нь Дотоод хэргийн яамны харьяанд байдаг бөгөөд үндсэндээ Засан хүмүүжүүлэх удирдлагыг хэрэгжүүлдэг байна. Япон улсын хорих байгууллагад нийт 45714 хоригдол хоригдож байна. Энэ нь 100,000 хүн ам тутамд 36 хоригдол ногдох үзүүлэлт юм. Түүнчлэн Япон улс нь 2018 оны байдлаар нийт 184 хорих

байгууллагатай байна. Үүнд насанд хүрэгчдийн 62 хорих анги, 8 салбар хорих анги, 6 хүүхдийн хорих анги, 8 цагдан хорих байр, 100 салбар хорих анги хамаарч байна³¹.

Эдгээр хорих байгууллагууд нь Саппорогийн тойргийн хорих анги, Сэндайн тойргийн хорих анги, Токиогийн тойргийн хорих анги, Нагояагийн тойргийн хорих анги, Осакагийн тойргийн хорих анги, Хирошимагийн тойргийн хорих анги, Такамацугийн тойргийн хорих анги, Фукуокагийн тойргийн хорих анги гэх байдлаар тойргуудад хуваагдаж зохион байгуулагддаг байна.

А. Хорих байгууллагын дэглэм, зэрэглэл

Япон улсын 2005 оны 5 дугаар сарын 25-нд батлагдсан “Цагдан хорих байр болон хорих ангийн хоригдолтой хэрхэн харьцах тухай хууль”-д зааснаар нээлттэй хорих байгууллага байж болохоор зохицуулжээ. Үүнд зөвхөн тухайн хорих ангид шилжих шаардлагыг хангасан хоригдлуудыг шилжүүлдэг байна. Харин хорих ангийн төрлийн хувьд хорих анги, хүүхдийн хорих, цагдаагийн хорих байр гэсэн төрөлтэй байна³².

Мөн үүнээс гадна Япон улсын 1907 оны “Ялын тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлд зааснаар хорих ял нь хөдөлмөр эрхлүүлж хорих ял болон хөдөлмөр эрхлүүлэхгүйгээр хорих ял гэсэн хоёр төрөлд хуваагддаг.

Хөдөлмөр эрхлүүлж хорих ял нь бүх насаар эсвэл тодорхой хугацаатай байж болдог. Хэрвээ тодорхой хугацаатай тохиолдолд 1 сараас доошгүй 20 жилээс дээшгүй хугацаатай байна.

Хөдөлмөр эрхлүүлэхгүйгээр хорих ял нь мөн адил бүх насаар эсвэл тодорхой хугацаатай байж болдог. Хэрвээ тодорхой хугацаатай тохиолдолд 1 сараас доошгүй 20 жилээс дээшгүй хугацаатай байна³³.

Б. Хорих байгууллага дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлт, зохион байгуулалт

Хорих ангийн хөдөлмөр нь ял эдэлж буй ялтнуудын сэтгэл санаа, бие бялдрын эрүүл мэндийг сахин хамгаалах, хөдөлмөрлөх хүслийг нь төлөвшүүлэх, хичээнгүй амьдрах боломжийг олгохын зэрэгцээ нийгэмд үүрэг хариуцлагаа ухамсарлах боломжийг олгодог. Мөн цаашид тэдэнд мэргэжлийн мэдлэг, ур чадвар олгох замаар нийгэмд эргэн орохыг дэмжих зорилготой. Хорих ангийн хөдөлмөрийн нэг хэлбэр болох ял эдэлж буй хоригдлуудад тусгай зөвшөөрөл, мэргэшил, мэргэжлийн мэдлэг, арга техник эзэмшүүлэхийн тулд хорих байгууллагууд мэргэжлийн сургалт явуулах явдал юм. Мөн ял эдэлж буй хоригдлуудыг хорих ангийн гаднах ажил хийх, эсвэл хорих байгууллагын гаднах аж ахуйн нэгжид шилжин очиж оффис дээр ажиллахыг зөвшөөрсөн нийгэмшлийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Мөн үүнээс гадна ял эдэлж буй хоригдлуудыг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх, нийгэмд саадгүй нэвтрэхийг дэмжих зорилгоор “Хорих ангиас гадна ажиллах, өдрийн чөлөө, хоногийн чөлөө олгох” тогтолцоог бий болгож байна. Нийгэмд эргэн ороход саадгүй гэж үзвэл нээлттэй хорих ангид ял эдэлж байгаа болон тэнсэн суллагдах нь тогтоогдсон

³¹ World prison brief: Japan, <https://www.prisonstudies.org/country/japan>

³² Penal Institutions (Prisons / Juvenile Prisons / Detention Houses), https://www.moj.go.jp/EN/kyousei1/kyousei_kyousei03.html

³³ PENAL CODE (Act No.45 of 1907), <https://www.cas.go.jp/jp/seisaku/hourei/data/PC.pdf>

ялтнууд хорих ангийн ажилтнуудын хяналтгүйгээр хорих байгууллагын гадна байрлах аж ахуйн нэгжид ажиллаж болно³⁴.

Японы хорих байгууллага дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлт нь үндсэндээ дараах 4 төрөлд хуваагддаг байна³⁵.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөдөлмөрийн үйлчилгээ үзүүлэх • Тавилга, хэвлэх, хувцас урлах, металл, арьс ширний ажил, газар тариалан гэх мэт.
Мэргэжлийн сургалт	Ял эдэлж буй хоригдлуудад шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, сайжруулахад нь туслах зорилгоор төлөвлөсөн, зохион байгуулсан сургалт • Суллагдсаны дараа ажиллахад хувь нэмэр болох мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшинэ • Автомашины техникч, асран хамгаалагч, тээврийн хэрэгслийн төрлийн барилгын машины оператор зэрэг сургалтанд хамрагдаж, хожим хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг болох мэргэжлийн үнэмлэх авах боломжтой.
Аж ахуйн ажил	Хорих ангиудад хоол хийх, угаалга хийх зэрэг ахуйн ажил болон барилга байгууламжийг засварлах зэрэг засвар үйлчилгээ хийх • Хоол хийх, угаалга хийх, үс засах, засвар үйлчилгээ хийх гэх мэт.
Нийгэмд тустай ажил	Хорих ангийн хоригдлуудыг нийгэмд хувь нэмрээ оруулах мэдрэмжийг мэдэрч болохуйцаар тэднийг засч залруулах, нөхөн сэргээх, нийгэмд саадгүй дахин оруулахад хувь нэмэр оруулах ажил • Сургуулийн зам дээрх цасыг цэвэрлэх, ургамлыг хамгаалах зорилгоор хогийн ургамлыг түүх гэх мэт.

3. Практик судалгаанд хийсэн дүн шинжилгээ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны баг нь тухайн судалгааны явцад 4 хорих ангиар явж анкетын судалгааг хийсэн. 2022 оны 10 дугаар сарын 06-аас 07-ны өдрүүдэд ШШГЕГ-ын харьяа Багануур дүүрэг дэх 427 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн, Хэнтий аймаг 419 дүгээр нээлттэй хорих ангийн хоригдлуудаас, 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр ШШГЕГ-ын харьяа Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын өсвөр насны хоригдлуудаас, 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр 405 дугаар хаалттай хорих ангийн хоригдлуудаас тус тус анкетын асуулгыг авсан. Нийтдээ нээлттэй, хаалттай дэглэмийн энгийн болон тусгай зэрэглэл бүхий 2 хорих анги, 1 тусгай байгууллага, 1 тусгай нэгжид ял эдэлж буй 247 хоригдол анкетын асуулгад хамрагдсан. Үүнийг тус бүрээр нь авч үзвэл дараах байдалтай байна.

³⁴ Penal Institutions (Prisons / Juvenile Prisons / Detention Houses), https://www.moj.go.jp/EN/kyousei1/kyousei_kyousei03.html

³⁵ CORRECTION BUREAU, MINISTRY OF JUSTICE OF JAPAN, Penal institution in Japan, <https://www.moj.go.jp/content/001314589.pdf>

Хорих ял эдэлж буй дэглэм, зэрэглэл

		Нээлттэй хорих ангийн энгийн зэрэглэл	Нээлттэй хорих ангийн тусгай зэрэглэл	Хаалттай хорих ангийн энгийн зэрэглэл	Хаалттай хорих ангийн тусгай зэрэглэл	Бүгд	Нийт хоригд- луудын дунд ээлэх хувийн жин
Хорих ял эдэлж буй анги?	Хэнтий аймаг дахь 419-р хорих анги	12	71	0	0	83	(34%)
	Багануур дүүрэг дэх 427-р хорих анги	7	42	31	57	137	(47%)
	Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага/бус ад хорих ангиудаас ирж аж ахуйн ажил хийж буй/	7	0	0	0	7	(15%)
	Бүх насаар хорих 405-р хорих анги/бусад хорих ангиудаас ирж аж ахуйн ажил хийж буй/	20	0	0	0	20	(37%)
	Бүгд	46	113	31	57	247	(39%)

Хоригдлуудын насны байдал

		18-25 нас	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш нас
Хорих ял эдэлж буй анги?	Хэнтий аймаг дахь 419-р хорих анги	12	28	19	13	5
	Багануур дүүрэг дэх 427-р хорих анги	20	53	30	22	10

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад /бусад хорих ангиудаас ирж аж ахуйн ажил хийж буй/	3	0	2	0	2
Бүх насаар хорих 405-р хорих анги/бусад хорих ангиудаас ирж аж ахуйн ажил хийж буй/	10	7	2	1	0
Бүгд	45	88	53	36	17

Хорих ял эдэлсэн хугацаа

		3 хүртэлх жил эдэлсэн	3-6 жил эдэлсэн	7-9 жил эдэлсэн	10-12 жил эдэлсэн	13-аас дээш жил эдэлсэн	Нийт
Хорих ял эдэлж буй анги?	Хэнтий аймаг дахь 419- р хорих анги	58	13	3	1	0	75
	Багануур дүүрэг дэх 427-р хорих анги	68	37	6	16	1	129
	Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага/бусад хорих ангиудаас ирж аж ахуйн ажил хийж буй/	7	0	0	0	0	7
	Бүх насаар хорих 405-р хорих анги/бусад хорих ангиудаас ирж аж ахуйн ажил хийж буй/	17	3	0	0	0	20
Нийт		150	53	9	17	1	231

ШШГЕГ-ын харъяа Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын өсвөр насны хоригдлууд нь хуульд зааснаар хөдөлмөрлөх боломжгүй. 405 дугаар хаалттай хорих ангийн хоригдлуудын хувьд хуульд зааснаар зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлөх боломжтой. Судалгааны явцад ШШГЕГ-ын харъяа сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага

болон 405 дугаар хаалттай хорих ангийн хоригдлууд хөдөлмөр эрхлэхгүй байгаа нь тогтоогдсон. Харин тухайн хорих ангиудад бусад хорих ангиудаас нээлттэй дэглэмд ял эдэлж буй хоригдлууд аж ахуйн ажил эрхэлдэг ба нийт 27 хоригдол үүнд хамаарч байна. Мөн хорих ангиас гадуур гэрээгээр ажилладаг нээлттэй дэглэмийн хорих ангийн хоригдлууд энэхүү судалгаанд хамрагдаагүй болно.

Судалгааны тус бүлэгт хорих ангийн дэглэм болон хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар судалж байгаа билээ. Тиймээс практик судалгааны хувьд дээрх анкетын асуулгад хариулт өгсөн нийт 4 зэрэглэлийн 247 хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тодорхойлсон болно. Энэ хүрээнд хоригдлын ял эдэлж буй дэглэм болон ял эдэлсэн хугацаа нь хоригдлын эрхэлж буй ажлын төрөл, ажилладаг газар, ажилладаг өдөр, цаг, ажлын нөхцөл, цалин болон бусад зүйлүүдэд хэрхэн нөлөөлдөгийг дүгнэн гаргасан юм.

Ингэхдээ SPSS программыг ашиглаж тухайн асуулгын үр дүнд хамаарлын шинжилгээ (Correlation analysis) хийсэн. Хамаарлын шинжилгээ нь хос хувьсагчдын хамаарал, бүлэг хувьсагчдын хамаарлыг гаргахад ашиглагддаг. Өөрөөр хэлбэл хоёр хувьсагчийн хооронд статистикийн хувьд ач холбогдол бүхий шугаман хамаарал байгаа эсэх, хамаарлын хүч ямар эсэх, хоорондоо шууд эсвэл урвуу хамааралтай эсэхийг тодорхойлдог. Хамаарлын төрөл болон хамаарлын хүчийг дараах томъёоллоор дүгнэв.

Хамаарлын төрөл:

$H_0: \rho = 0$ буюу эх олонлогийн корреляцийн коэффициент 0-тэй тэнцүү, хувьсагчдын хооронд хамаарал байхгүй

$H_a: \rho > 0$ буюу эх олонлогийн корреляцийн коэффициент 0-ээс их, хувьсагчдын хооронд шууд хамаарал оршин байна.

$H_a: \rho < 0$ буюу эх олонлогийн корреляцийн коэффициент 0-ээс бага, хувьсагчдын хооронд урвуу хамаарал оршин байна.

Хамаарлын хүч:

$0.1 < |r| < 0.3$... бага / сул хамааралтай

$0.3 < |r| < 0.5$... дунд / дунд зэрэг хамааралтай

$0.5 < |r|$ их / хүчтэй хамааралтай

А. Хорих ангийн дэглэмээс хамаарсан хөдөлмөрийн зохион байгуулалт

		Хорих ял эдэлж буй дэглэм, зэрэглэл?	Дүн шинжилгээний тайлбар
Та хаана ажилладаг вэ?	Pearson (r)	.029	Энэхүү асуултад 194 хоригдол хариулсан ба хорих ангийн дэглэм болон ажилладаг газар нь хоорондоо шууд хамааралтай бөгөөд хамаарал нь сул байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.343	
	N	194	
Та 7 хоногийн хэдэн өдөр ажилладаг вэ?	Pearson (r)	-.344**	Энэхүү асуултад 194 хоригдол хариулсан ба хорих ангийн дэглэм болон хоригдлын
	Sig. (1-tailed)	.000	
	N	194	

			ажилладаг өдөр нь хоорондоо хамааралгүй байхаар хариулжээ.
Та өдөрт хэдэн цаг ажилладаг вэ?	Pearson (r)	-.218**	Энэхүү асуултад 189 хоригдол хариулсан ба хорих ангийн дэглэм болон хоригдлын ажиллах цаг нь хоорондоо урвуу сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.001	
	N	189	
Таныг ажил хийхэд аливаа эрсдэл, аюултай байдал үүсдэг үү?	Pearson (r)	.152*	Энэхүү асуултад 211 хоригдол хариулсан ба хорих ангийн дэглэм болон эрсдэлтэй байдал үүсэх нөхцөл байдал нь хоорондоо шууд сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.014	
	N	211	
Ажил хийх явцдаа та ямар нэг байдлаар шийтгүүлж байсан уу?	Pearson (r)	-.053	Энэхүү асуултад 199 хоригдол хариулсан ба хорих ангийн дэглэм болон шийтгүүлж байсан эсэх нь хоорондоо урвуу сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.228	
	N	199	
Таныг ажил хийхэд аюулгүй ажиллагааны зааварчилгаа (ХАБ) танилцуулдаг уу?	Pearson (r)	.026	Энэхүү асуултад 204 хоригдол хариулсан ба хорих ангийн дэглэм болон ХАБ танилцуулдаг эсэх нь хоорондоо шууд сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.357	
	N	204	
Таны ажлын нөхцөл бусад энгийн хүмүүсийн ажлын нөхцөлөөс ямар байдаг вэ?	Pearson (r)	-.098	Энэхүү асуултад 219 хоригдол хариулсан ба хорих ангийн дэглэм болон ажлын нөхцөл нь хоорондоо урвуу сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.074	
	N	219	
Танд ажилласны үр дүнд цалин, хөлс өгдөг үү?	Pearson (r)	-.159*	Энэхүү асуултад 210 хоригдол хариулсан ба хорих ангийн дэглэм болон цалин хөлс өгдөг эсэх нь урвуу сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.010	
	N	210	
Танд цалин, хөлс олгохдоо ямар байдлаар өгдөг вэ?	Pearson (r)	-.471**	Энэхүү асуултад 134 хоригдол хариулсан ба Хорих ангийн дэглэм болон цалин хөлс өгөх байдал нь хоорондоо хамааралгүй байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.000	
	N	134	
Хорих ангийн зүгээс таныг ажил хийлгэхдээ бусад хоригдлуудаас ялгаж харьцдаг уу?	Pearson (r)	-.078	Энэхүү асуултад 215 хоригдол хариулсан ба хорих ангийн дэглэм болон ялгаж харьцах байдал нь хоорондоо урвуу сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.128	
	N	215	

Дээрхээс дүгнэвэл хоригдлын эрхэлж буй ажлын төрөл, ажилладаг газар, ажилладаг өдөр, цаг, ажлын нөхцөл, цалин болон бусад зүйлүүд нь хоригдлын хорих ял эдлэж буй дэглэмээс зарим тохиолдолд хамааралгүй, ихэнх тохиолдолд сул хамааралтай байгаа нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан хорих ял эдэлж буй хоригдлууд нь дээрх асуултуудад ямар дэглэм, зэрэглэлд хорих ял эдэлж байгаагаас үл хамааран (бага зэрэг) хариултуудыг өгсөн байна.

Б. Хорих ялын хугацаанаас хамаарсан хөдөлмөр зохион байгуулалт

		Та ялынхаа хэдий хугацааг эдэлсэн бэ?	Дүн шинжилгээний тайлбар
Та хаана ажилладаг вэ?	Pearson (r)	-.036	Энэхүү асуултад 184 хоригдол хариулсан ба хорих ангид ял эдэлсэн хугацаа болон ажилладаг газар нь хоорондоо урвуу сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.313	
	N	184	
Та 7 хоногийн хэдэн өдөр ажилладаг вэ?	Pearson (r)	-.045	Энэхүү асуултад 185 хоригдол хариулсан ба Хорих ангид ял эдэлсэн хугацаа болон ажилладаг өдөр нь урвуу сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.271	
	N	185	
Та өдөрт хэдэн цаг ажилладаг вэ?	Pearson (r)	-.013	Энэхүү асуултад 181 хоригдол хариулсан ба хорих ангид ял эдэлсэн хугацаа болон ажилладаг цаг нь урвуу сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.429	
	N	181	
Таныг ажил хийхэд аливаа эрсдэл, аюултай байдал үүсдэг үү?	Pearson (r)	-.057	Энэхүү асуултад 200 хоригдол хариулсан ба хорих ангид ял эдэлсэн хугацаа болон эрсдэлтэй байдал нь хоорондоо урвуу сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.210	
	N	200	
Ажил хийх явцдаа та ямар нэг байдлаар шийтгүүлж байсан уу?	Pearson (r)	.042	Энэхүү асуултад 189 хоригдол хариулсан ба Хорих ангид ял эдэлсэн хугацаа болон шийтгүүлэх байдал нь хоорондоо шууд сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.283	
	N	189	
Таныг ажил хийхэд аюулгүй ажиллагааны зааварчилгаа (ХАБ) танилцуулдаг уу?	Pearson (r)	-.053	Энэхүү асуултад 194 хоригдол хариулсан ба хорих ангид ял эдэлсэн хугацаа болон ХАБ танилцуулдаг эсэх нь урвуу сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.230	
	N	194	
Таны ажлын нөхцөл бусад энгийн хүмүүсийн ажлын нөхцөлөөс ямар байдаг вэ?	Pearson (r)	-.081	Энэхүү асуултад 207 хоригдол хариулсан ба хорих ангид ял эдэлсэн хугацаа болон ажлын нөхцөл нь хоорондоо урвуу сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.124	
	N	207	
Танд ажилласны үр дүнд цалин, хөлс өгдөг үү?	Pearson (r)	-.233**	Энэхүү асуултад 198 хоригдол хариулсан ба хорих ангид ял эдэлсэн хугацаа болон цалин хөлс өгдөг эсэх нь хоорондоо хамааралгүй байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.000	
	N	198	
Танд цалин, хөлс олгохдоо ямар байдлаар өгдөг вэ?	Pearson (r)	-.203*	Энэхүү асуултад 126 хоригдол хариулсан ба Хорих ангид ял эдэлсэн хугацаа болон цалин хөлс олгох байдал нь хоорондоо урвуу сул хамааралтай байхаар хариулжээ.
	Sig. (1-tailed)	.011	
	N	126	
Хорих ангийн зүгээс таныг ажил хийлгэхдээ бусад	Pearson (r)	-.033	Энэхүү асуултад 194 хоригдол хариулсан ба хорих ангид ял эдэлсэн хугацаа болон ялгаж
	Sig. (1-tailed)	.318	
	N	205	

хоригдлуудаас ялгаж харьцдаг уу?			харьцах байдал нь хоорондоо урвуу сул хамааралтай байхаар хариулжээ.
----------------------------------	--	--	--

Дээрхээс дүгнэвэл хоригдлын эрхэлж буй ажлын төрөл, ажилладаг газар, ажилладаг өдөр, цаг, ажлын нөхцөл, цалин болон бусад зүйлүүд нь хоригдлын хорих ял эдэлсэн хугацаанаас зарим тохиолдолд хамааралгүй, ихэнх тохиолдолд сул хамааралтай байгаа нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан хорих ял эдэлж буй хоригдлууд нь дээрх асуултуудад хэдий хугацаанд хорих ял эдэлснээс хамаарал багатайгаар хариултуудыг өгсөн байна.

Судалгааны явцад фокус ярилцлага авахад ШШГЕГ-ын харьяа Багануур дүүрэг дэх 427-р хорих ангийн, Хэнтий аймаг дахь 419 дүгээр хорих ангийн, ШШГЕГ-ын харьяа Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын, 405 дугаар хаалттай хорих ангийн удирдлагууд тус бүр хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг хоригдлын ял эдэлж буй дэглэм, хорих ял эдэлсэн хугацаатай хамаарал багатай гэх санааг дэмжин “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хязгаарлалтууд болох хаалттай дэглэмийн хоригдлууд хорих ангийн үйлдвэр, бүсэд ажиллах, бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлууд хорих өрөөнд ажиллах, нээлттэй дэглэмийн хоригдлууд гадуур ажиллаж болох нөхцөл байдлаас бусдаар хоригдлууд ижилхэн хөдөлмөр эрхлэлттэй” байдаг талаар дурдсан юм.

4. Явцын дүгнэлт, дүн шинжилгээ

Судалгааны тус бүлгээр хоригдлын ял эдэлж буй хорих ангийн дэглэм, зэрэглэл болон хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, гадаад улсуудын харьцуулсан судалгаа болон практикийн судалгааг хийлээ. Энэхүү судалгааны үр дүнг ерөнхий байдлаар тоймлон харуулбал дараах байдалтай байна.

	Судалгааны үр дүн
Монгол Улсын эрх зүйн зохицуулалт	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар хорих ангийн дэглэм, зэрэглэлээс хамаарч хоригдлын хөдөлмөр зохион байгуулалт ялгаатай. Нээлттэй хорих ангид ял эдэлж буй хоригдлыг хорих байгууллага өөрийн болон өөрийн хувь нийлүүлсэн, хамтарсан хуулийн этгээдэд, эсхүл бусад хуулийн этгээдтэй гэрээ байгуулан зохих хяналттайгаар болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аж ахуйн ажил, хаалттай хорих анги, цагдан хорих байр, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, хорих эмнэлгийн аж ахуйн үйлчилгээ зэрэгт хөдөлмөрлүүлж болно. Өөрөөр хэлбэл хорих ангиас гадуур хөдөлмөрлүүлж болдог. Харин хаалттай хорих ангийн энгийн болон тусгай зэрэглэлийн хоригдлыг зөвхөн хорих байгууллагын үйлдвэрт хөдөлмөрлүүлнэ. Хөдөлмөрийн нөхцөлийн хувьд нээлттэй хорих байгууллагаас ялгаатай нь Хөдөлмөрийн тухай хуульд зааснаас өөрөөр зохицуулж болдог байна. Харин хаалттай хорих ангийн тусгай нэгжийн хоригдлуудыг зөвхөн хорих ангийн байранд нь л хөдөлмөрлүүлэхээр хуульчилжээ. Өөрөөр хэлбэл хаалттай дэглэмийн энгийн болон тусгай зэрэглэлтэй адил хорих ангийн үйлдвэрлэлд ажиллуулж болохгүй.

Харьцуулсан судалгаа	Америкийн нэгдсэн Улс	Хорих байгууллагын дэглэм, зэрэглэлийг аюулгүй байдлын зэрэглэлд үндэслэн төрөлжүүлдэг байна. Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн тухайд ашгийн төлөөх хувийн хорих ангиуд, Хорих ангийн үйлдвэрлэлийг сайжруулах гэрчилгээний хөтөлбөр (PIECP), Мужийн хорих ангийн хөдөлмөр (PIECP-ээс гадуур), Холбооны хорих ангийн хөдөлмөр (PIECP-ээс гадуур) гэх байдлаар тухайн хорих байгууллага, хөтөлбөрт харьяалагдах байдлаар ажиллуулдаг байна. Өөрөөр хэлбэл хоригдлын хөдөлмөр эрхлэлт нь хорих ангийн аюулгүй байдлын зэрэглэлээс хамааралгүй.
	Холбооны бүгд найрамдах Герман Улс	Хорих байгууллагын хувьд нээлттэй хорих байгууллага болон хаалттай хорих байгууллага гэсэн ангилалтай байх хэдий ч хоригдлын хөдөлмөр нь зөвхөн тухайн хорих байгууллагад эрхэлж болох хөдөлмөрөөр хязгаарлагддаг байна. Өөрөөр хэлбэл хоригдлын хөдөлмөр эрхлэлт нь хорих ангийн дэглэм, зэрэглэлээс хамаардаггүй байна.
	Норвеги Улс	Хорих ангийн дэглэм, зэрэглэл гэж байдаггүй ба харин хорих ангийн төрлүүдийг чухалчилж авч үздэг. Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн хувьд дэглэм, зэрэглэлээс хамаардаггүй байна.
	Бүгд найрамдах Эстони Улс	Хорих ангийн дэглэм, зэрэглэлийг хаалттай, нээлттэй гэж хуваадаг. Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн хувьд ерөнхий зохицуулалт үйлчилдэг буюу дэглэм, зэрэглэлээс хамаардаггүй байна.
	Япон Улс	Хорих ангийн дэглэм, зэрэглэл гэж байдаггүй. Харин хорих ялын хувьд хөдөлмөр эрхлүүлж хорих болон хөдөлмөр эрхлүүлэхгүйгээр хорих гэсэн төрөлтэй байна. Хоригдлын хөдөлмөр эрхлэлт нь хорих ангийн дэглэм, зэрэглэлээс хамаардаггүй байна.
Практик судалгаа	Хорих ангийн дэглэмээс хамаарсан хоригдлын хөдөлмөрийн зохион байгуулалт	Хоригдлын эрхэлж буй ажлын төрөл, ажилладаг газар, ажилладаг өдөр, цаг, ажлын нөхцөл, цалин болон бусад зүйлүүд нь хоригдлын хорих ял эдлэж буй дэглэмээс зарим тохиолдолд хамааралгүй, ихэнх тохиолдолд сул хамааралтай байна. Өөрөөр хэлбэл хоригдлуудаас авсан анкетын асуулгын үр дүнгээс тухайн нөхцөл байдал харагдаж байна.
	Хоригдож буй хугацаанаас хамаарсан хоригдлын хөдөлмөрийн зохион байгуулалт	Хоригдлын эрхэлж буй ажлын төрөл, ажилладаг газар, ажилладаг өдөр, цаг, ажлын нөхцөл, цалин болон бусад зүйлүүд нь хоригдлын хорих ял эдэлсэн хугацаанаас зарим тохиолдолд хамааралгүй, ихэнх тохиолдолд сул хамааралтай байна. Өөрөөр хэлбэл хоригдлуудаас авсан анкетын асуулгын үр дүнгээс тухайн нөхцөл байдал харагдаж байна.

Монгол Улсын хувьд эрх зүйн зохицуулалтаар хоригдлын хөдөлмөрлөх байршил болон нөхцөлийг хорих ангийн дэглэм, зэрэглэлээс хамааруулан ялгаатай байхаар зохицуулжээ. Гэсэн хэдий ч практик судалгааг хийж үзэхэд хорих ангийн дэглэм болон хоригдлын хөдөлмөр зохион байгуулалт нь хоорондоо хамаарал багатай байгаа нь тогтоогдож байна. Мөн түүнчлэн хорих ял эдэлсэн хугацаанаас ч хоригдлын хөдөлмөр эрхлэлт хамаарал багатай болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл хорих ял эдэлж буй хоригдлуудаас эрхэлж буй ажлын төрөл, ажилладаг газар, ажилладаг өдөр, цаг, ажлын

нөхцөл, цалин болон бусад зүйлүүдийн талаар асуухад хорих ял эдэлж, буй дэглэм болон хорих ял эдэлсэн хугацаанаас хамаарал багатайгаар хариултуудыг өгсөн.

Харьцуулсан судалгааны үр дүнгээс авч үзвэл сонгосон улсуудын хувьд хоригдлын хөдөлмөр зохион байгуулалтыг хорих байгууллагын дэглэм, зэрэглэлээс хамааруулан зохион байгуулсан улс байхгүй байна. Өөрөөр хэлбэл хоригдлын хөдөлмөрийн талаар ерөнхий зохицуулалтууд үйлчилдэг байна. Хоригдлыг гадуур ажиллуулах тохиолдолд зарим улсад хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдэхгүй гэж үзэх нөхцөл байдлыг чухалчилдаг байна.

ХОЁР. ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, САЛБАР ДУНДЫН БОДЛОГЫН УЯЛДАА ХОЛБОО

1. Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөрийн талаар төрөөс баримталж буй бодлого, салбар дундын бодлогын уялдаа холбоо

Хоригдлын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр зохион байгуулалтын талаарх төрийн бодлого, салбар дундын бодлого нь Монгол Улсын урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт үндэслэгдсэн эсэхийг энэхүү бүлэгт судалсан болно.

1.1. Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөрийн талаар бодлогын баримт бичигт хийсэн дүн шинжилгээ

Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар хэрэгжиж буй томоохон төлөвлөлт буюу хөгжлийн бодлогын дараах баримт бичгүүд байна.

1. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр;
2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр буюу дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр;

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт хамаарах хэсэг

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр зохион байгуулалтын талаар хэрэгжүүлэх дараах үйл ажиллагаанууд хамаарч байна.

Зорилт 2.3.5	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ
Зорилт 2.6.2	Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, нээлттэй боловсролын зарчимд тулгуурласан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ
Зорилт 2.6.3	Хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ
Зорилт 2.6.6	Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэж, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг хөгжүүлнэ
Зорилт 2.6.7	Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдал нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин буурч, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн байна
Зорилт 5.5.4	Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ
Зорилт 7.3.2	Хорих байгууллагын тогтолцоог бүсчилсэн хэлбэрээр хөгжүүлнэ
Зорилт 7.3.4	Хорих ял эдлүүлэх орчин, нөхцөлийг хүний эрхийг хангасан түвшинд хүргэх замаар “Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага”-ын цогцолбор барилга, байгууламжийг ашиглалтад оруулна
Зорилт 7.3.5	Хорих анги, цагдан хорих, баривчлах байр, “Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага”-д хоригдож, хүмүүжиж байгаа суурь өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл, аюулгүй байдлыг бүрэн хангаж, хүний эрхийг дээдэлсэн орчин, нөхцөл бүрдүүлнэ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр буюу дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр

Тус хөгжлийн хөтөлбөрт дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

4.3.6	Ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах, ялтныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлнэ.
-------	---

1.2. Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаарх салбар дундын үйл ажиллагаа, хөтөлбөрүүд

Монгол Улсад хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаарх харилцааг дараах эрх зүйн эх сурвалж буюу хууль, дүрэм, журмаар зохицуулж байна.

№	Эрх зүйн актууд	Батлагдсан огноо	Баталсан субъект, тушаал
1.	Үндсэн хууль	1992.01.13	АИХурал
2.	Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/	2021.07.02	Улсын Их хурал
3.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль	2017.06.09	Улсын Их хурал
4.	Хоригдлын хөдөлмөрийн норм, цалин хөлсний үнэлгээг тогтоох журам	2018.07.04	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын А/131 тоот тушаал
5.	Хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс суутгал хийх журам	2018.07.30	Монгол Улсын хууль зүй, дотоод хэргийн сайдын А/150 тоот тушаал
6.	Ялтан гэрээгээр ажиллуулахад мөрдөх заавар	2015.05.06	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын А/100 тоот тушаал
7.	Хорих ангийн дотоод журам	2017.07.04	Монгол Улсын хууль зүй, дотоод хэргийн сайдын А/183 тоот тушаал
8.	Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэмийг батлах тухай	2017.07.04	Монгол Улсын Засгийн газрын 82, 204, 304 дүгээр тогтоол
9.	ШШГБ-ын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгдсэн журам	2015.10.02	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын А/207 тоот тушаал
10.	Хоригдол, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтанд шагналын хоног олгох, хоригдлыг ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг өөрчлөх болон хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай санал гаргах чиг үүрэг бүхий зөвлөлийн дүрэм	2017.08.30	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын А/165 дугаар тушаал

Эдгээрээс гадна Хууль зүй, дотоод хэргийн яам болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас хоригдлын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зохион байгуулалт, нийгэмшүүлэх үйл ажиллагааны талаар бусад салбарын байгууллага, яамдуудтай хамтран олон төрлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Эдгээрийг дэлгэрүүлэн авч үзвэл:

А. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А/167, А/233 хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Хоригдлыг суллахад бэлдэх хөтөлбөр”

Тухайн хөтөлбөрийн зорилго нь хорих ялын хугацаа дуусахаас өмнө хоригдлыг нийгэмд гарахад бэлтгэх, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, суралцах болон ажил хөдөлмөр эрхлэх дадал хэвшүүлэх, гэр бүлийн харилцаа, хөдөлмөрийн харилцаанд бэлтгэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын зүгээс үзүүлэх нийгмийн ажил, үйлчилгээний салбар дундын зохицуулалтыг хангахад оршино.

Тухайн хөтөлбөр нь Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаа, бүртгэлийн байгууллага, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, хэлтэс, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, бүх шатны Засаг дарга, төрийн бусад байгууллага, хуулийн этгээд, байгууллага, төрийн бус байгууллага, иргэн, хорих ялын хугацаа дуусаж суллагдах хоригдол нарын хооронд хэрэгждэг.

Тус хөтөлбөрт хоригдлын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр зохион байгуулалтын талаарх зохицуулалтыг тусгасан. Тухайлбал хоригдолд хөдөлмөрийн дадал олгох, сургалт зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гэх мэт чиглэлээр олон төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнийг тоймлон авч үзвэл:

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх нийтлэг арга хэмжээ	Нийгэмд амьдрах, хөдөлмөр эрхлэх ур чадварт үнэлгээ хийх
Хоригдлыг суллахад бэлтгэх арга хэмжээ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хэрэгжүүлэх арга хэмжээ: -Хоригдлын ур чадвар, хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн ур чадвар олгох, хөдөлмөрт бэлтгэх, ажлын байранд зуучлах арга хэмжээнд хамруулах; Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын хэрэгжүүлэх арга хэмжээ: -Хөдөлмөрийн дадал олгох, авьяас, хөдөлмөрийн идэвхийг дэмжих сургалтад хамруулах; -Хоригдлын өмнөх мэдлэг, ур чадварыг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх ажлыг холбогдох мэргэжлийн зөвлөлтэй хамтран зохион байгуулах;
Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ	Суллагдахын өмнө хоригдлын хөдөлмөр эрхлэх нөөц, сонирхол хэрэгцээг тодорхойлох, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээт мэдээлэл, үйлчилгээг үзүүлэх; Суллагдсаны дараа хэрэгцээт ур чадварыг олгох сургалт, бусад арга хэмжээнд хамруулах, ажлын байранд зуучлах, хөдөлмөрийн зах

	зээлийн мэдээ мэдээлэл, үйлчилгээг үзүүлэх, эргэх холбоог хадгалах;
--	---

Тус хөтөлбөр нь НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн баталсан тогтоолын 76/182-т заасан “Нийгэмшүүлэх болон нийгэмд эргэн нэгтгэх замаар давтан гэмт хэргийг бууруулах” арга хэмжээний хүрээнд батлагдсан юм.

Энэхүү арга хэмжээний хүрээнд НҮБ-аас дараах саналыг өгсөн байна.

- Гэмт хэрэгтнийг /зөрчил гаргагч/ нийгэмшүүлэх, нийгэмд эргэн нэгтгэх замаар давтан гэмт хэргийг бууруулах чиглэлээр нийтийг хамарсан стратеги, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх /хөгжүүлэх/-ийг гишүүн улс орнуудад санал болгож байна;

- Засан хүмүүжүүлэх байгууламж /хорих байгууллага/-д гэмт хэрэгтэнг нийгэмшүүлэх орчныг бий болгох, тэр дундаа хоригдогсдын хэрэгцээ шаардлага болон тулгарч буй эрсдэлд суурилан тэдэнд чиглэгдсэн үр дүнтэй хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мөн гэмт хэрэгтэнг мэргэжлийн сургалт, боловсролын сургалтад хамрагдах нөхцөл боломжоор хангах замаар нийгэмд эргэн нэгтгэхэд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг гишүүн орнуудад зөвлөж байна;

- Бүс нутгийн /ард иргэдийн/ идэвхтэй оролцоотойгоор нийгэмд эргэн нэгтгэх тогтолцоог бүрдүүлэх, мөн дээрх тогтолцоог бүрдүүлэх замаар хувь хүн бүрийн тэр дундаа хохирогчийн болон гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрхийг хамгаалах орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг гишүүн орнуудад зөвлөж байна;

- Гэмт хэрэгтнийг /хоригдол, хоригдогч/ нийгэмд эргэн нэгтгэх зорилгоор ажил олгогч байгууллага /ажил олгогчдын нэгдсэн холбоо/, халамжийн байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага, төр хувийн хэвшлийн түншлэл, түүний бүтцэд харяалагддаг байгууллага, орон нутгийн сайн дурын ажилчид зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо, олон талт хамтын ажиллагааг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэхийг гишүүн орнуудад зөвлөж байна;

Энэхүү хөтөлбөрт хоригдлууд бүгд хамрагддаггүй бөгөөд зөвхөн тодорхой шалгуурыг хангасан хоригдлууд хамрагддаг. Үүнд хорих ял эдлүүлэх үеийн сургалт, нийгэмшүүлэх ажлын хөтөлбөрт идэвх санаачлагатай хамрагдсан, сахилгын шийтгэл хүлээнээс хойш нэг жилийн хугацаа өнгөрсөн, өөрийн алдаа дутагдлаа ойлгож ухамсарлаж, нийгмийн ажилтан, алба хаагчаас эерэг үнэлгээ авсан, хорих ангийн захиргаанд хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан гэх шалгуурууд хамаарна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А/167, А/233 хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Хоригдлыг суллахад бэлдэх хөтөлбөр”-ын дутагдалтай тал нь тус хөтөлбөрт зөвхөн суллагдах гэж буй хоригдлуудад суллагдах гэж буйтай нь холбогдуулан арга хэмжээг авч байгаатай холбоотой. Гэвч тус дэвшилттэй арга, хэмжээнүүдэд бүх хоригдлуудыг хамааруулан хөдөлмөрийн дадал, зуршлыг олгох, нийгэмшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Б. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 9-ний өдрийн А/46 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн сургалт зохион байгуулах журам”

Тухайн журам нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвөөс хоригдолд мэргэжил олгох болон мэргэжлийн сургалтыг зохион байгуулахад оролцогч талуудын харилцааг зохицуулахад чиглэгддэг. Зорилгын хувьд хоригдолд мэргэжлийн боловсрол олгох, хорих ангийн үйлдвэрлэлд ажиллуулах, гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх боломжийг бий болгох, улмаар суллагдсаны дараа эзэмшсэн мэргэжлээрээ нийгэмд бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Мэргэжлийн боловсрол олгох сургалтыг нэг жил, мэргэжлийн сургалтыг нэг сарын хугацаанд тус тус зохион байгуулдаг. Сургалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас баталсан сургалтын төлөвлөгөө, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн дагуу төвийн захирлын баталсан “Мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалт зохион байгуулах удирдамж”, “Хичээлийн хуваарь”-ийн дагуу зохион байгуулна.

Мэргэжлийн боловсрол олгох сургалтыг Барилгын засал чимэглэлчин, бетон арматурчин, өрөг угсрагч, цахилгаанчин, мужаан, сантехникч, Гагнуурчин болон тогооч гэсэн 8 чиглэлээр зохион байгуулж байна.

Мэргэжлийн сургалтыг дээр дурдсан 8 чиглэлээс гадна Монгол дархан, Оёмол бүтээгдэхүүний оёдолчин, Кеттельчин, Сийлбэрчин, Арьсаар гар урлалын зүйл урлаач, Сүлжмэлийн үйлдвэрийн технологийн ажилтан /сүлжигч/ чиглэлээр зохион байгуулдаг.

Дээрх чиглэлүүдээр мэргэжлийн боловсрол олгох болон мэргэжлийн сургалтад хамрагдсан суралцагчийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/50 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээг баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/506, А/155 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх журам”-ын дагуу үнэлж, мэргэшлийн түвшинг тогтооно.

Сургалтад хамрагдсан суралцагчдын төгсөлтийн шалгалтыг төвийн захирлын тушаалаар томилогдсон үнэлгээний баг зохион байгуулж, “чадамжтай” үнэлгээ авсан суралцагчид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/505, А/267 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдөд мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээ олгох журам”-ын дагуу мэргэжлийн үнэмлэх эсвэл чадамжийн гэрчилгээ олгоно.

В. “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан хөгжлийн төслийн нэг болох Зүүн баян-Ханги чиглэлийн шинэ төмөр замын сүлжээг байгуулах төсөл

Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хэрэгжүүлж буй томоохон төслийн нэг Зүүнбаян-Ханги чиглэлийн 226 км төмөр зам барих ажлын нээлт Дорноговь аймгийн Мандах сумын дөрөвдүгээр багийн нутаг Сэрвэн баян хошуу багийн Халзан цав гэдэг газарт 3 дугаар сарын 11-нд болсон. Тус төмөр зам нь Таван толгой-Зүүнбаян чиглэлийн замаас урагш салбарлан тавигдах ба энэ замын эхлэл нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас зүүн тийш 303 км-т, Дорноговь аймгийн Мандах сумаас зүүн урагш 80 км-т, Зүүнбаянгаас баруун зүгт 112 км-т байрлах бөгөөд Хатанбулаг дахь Ханги хилийн боомт хүртэл хамгийн бага буюу 226 км-ийн алсад байрших юм.

Өөрөөр хэлбэл Зүүнбаянгаас урагш төмөр зам тавихад 260 орчим км зайтай бол энэхүү шинэ цэгээс илүү дөт замыг туулах аж. Тиймээс Зүүнбаян-Ханги чиглэлийн хамгийн том өртөө энд сүндэрлэн босно.

Энэ замыг барихад Засгийн газраас нэг ч төгрөг гаргахгүй бөгөөд “Монголиан транс лайн”, “Монголиан трасс ложистик” компанийн нэгдэл төмөр замыг өөрийн хөрөнгөөр барьж 20 жил ашиглаад төрд буцааж өгөхөөр концессоор гэрээлжээ. Энэ талаар “Монголиан транс лайн” ХХК концессийн гэрээгээр зураг төсөл боловсруулах, ашиглах, шилжүүлэх гэсэн нөхцөлөөр эл бүтээн байгуулалтад оролцож байгаа ба одоогийн байдлаар 200 гаруй км газарт 32 аж ахуй нэгж ажиллаж байгаа. Хамгийн бага нь дөрвөн км, хамгийн их нь 10 км зам барихаар гэрээлжээ³⁶.

Үүний дагуу “Монголиан транс лайн” ХХК-тай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих ангиуд гэрээ байгуулж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 217.1 дэх хэсэгт заасныг үндэслэн нээлттэй дэглэмд ял эдэлж буй хоригдлуудаас гэрээгээр ажиллуулж байна. Ингэхдээ тухайн хорих байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албанаас зөвшөөрлийг авч, хяналт тавьж буй прокурорт танилцуулан харуул хамгаалалт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж гарч болзошгүй орголт, гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлж зохион байгуулж байна. Судалгааны явцад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 419-р нээлттэй хорих анги, 427-р нээлттэй, хаалттай хорих ангиас тус байгууллагатай гэрээ байгуулан тодорхой тооны хоригдлуудыг ажиллуулж байна.

Г. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон түүний харьяа байгууллагын хэрэгжүүлсэн хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар салбар дундын үйл ажиллагаа, хөтөлбөрүүд

Огноо	Хөтөлбөр, үйл ажиллагаанууд	Дэлгэрэнгүй мэдээлэл
2018.02.01	Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний улсын төсөвт, төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын бүтээгдэхүүн танилцуулах үзэсгэлэн	ШШГЕГ-ын харьяа 5 төрийн өмчит үйлдвэрийн газар, үйлдвэрлэл эрхэлдэг 5 хорих анги оролцох бөгөөд өөрсдийн үйлдвэрлэсэн гутал, хувцас, гар урлалын бүтээгдэхүүн, барилгын материал зэрэг бүтээгдэхүүнийг нийтэд танилцуулж, бэлэн бүтээгдэхүүний борлуулалт хийж, захиалга хүлээн авах үйл ажиллагаа
2019.06.12	Баянзүрх дүүргийн хүмүүжигчдийн сайн дурын нийгмийн даатгал	Баянзүрх дүүргийн ШШГЕГ-ын 421 дүгээр нээлттэй хорих ангийн хоригдлуудаас 80 гаруй хоригдол нь сайн дурын нийгмийн даатгалд хамрагдсан.
2019.06.18	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтэс, СХД-ийн прокурорын газар, мөн	Санамж бичгийн хүрээнд хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн /тэнсэх, албадлагын арга хэмжээ, эрх хасах, торгууль, нийтэд тустай ажил хийлгэх ял/ иргэдийн зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх, тэдний хэрэгцээ, ур чадварт үндэслэн, зохих ажлын байранд

³⁶ “Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт эхэллээ”, <https://montsame.mn/mn/read/292070>, Сүүлд үзсэн: 2022.10.27

	тус дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллахаар байгуулсан санамж бичиг	зуучлах, мэргэшүүлэх сургалтад үнэ төлбөргүй хамруулах, амьдралын түвшинг дээшлүүлэх тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж, хамтран ажиллах юм.
2019.07.10	“Эх орон-эрчүүдээр дутна” аян	Нийт таван сарын турш зохион байгуулсан тус аян нь хүмүүжигчдийг нийгэмшүүлэх, мэргэжил боловсрол эзэмшүүлэх, суллагдсаны дараа ажил, хөдөлмөр эрхлэн амьдрах итгэл, эрмэлзлэлийг нь нэмэгдүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой юм.
2019.08.29	Хүмүүжигчдэд олгох мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ	МСҮТ нь 2019 оны 8 дугаар сарын байдлаар нийт 522 хоригдолд мэргэжлийн сургалт зохион байгуулж, 149 суралцагчид мэргэжлийн үнэмлэх, 205 суралцагчид чадамжийн гэрчилгээ тус тус олгож, 168 суралцагчийг үйлдвэрлэлийн дадлагад шилжүүлээд байна.
2022.01.27	“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1170 хоригдлыг хамруулсан цахим сургалт	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг хэрэгжүүлэх ажилд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бие бүрэлдэхүүн нэгдэж, ял шийтгэлийн бодлогыг мод тариалах үйл ажиллагаатай уялдуулан, дотоод нөөц бололцоондоо тулгуурлан 100 сая мод тарих ажлын хүрээнд 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, бригадын генерал Д.Дамдинцэрэн, ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн захирал А.Буянбаатартай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Энэ хүрээнд 2022 оны 01 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд “Ойжуулалт, Агро-Ойжуулалт, “Таримлын агротехнологи”, “Усалгаа”, “Бордоо”, “Ургамал хамгаалал”, “Арчилгаа” сэдвийн хүрээнд 14 цагийн цахим сургалтыг зохион байгуулж, нийт 1170 хоригдлыг хамруулжээ.
2022.04.22	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ШШГБ-аас зарласан “100 сая мод” хөтөлбөр	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хамтран ажиллах санамж бичиг үзэглэлээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “100 сая мод” хөтөлбөрийг байгууллага болон орон нутагт үр ашигтайгаар, үе шаттай зохион байгуулах ажлыг эхлүүлээд байна. Хорих анги, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, түүний харьяа салбар нэгжүүд нь хоригдол, ялтнуудыг ажлын байраар хангах, сургалтад хамруулах, мод үржүүлгийн чиглэлээр боловсрол эзэмшүүлэх зорилгоор тус хөтөлбөрийг баталсан. “100 сая мод” хөтөлбөрийн хүрээнд гацуур, хайлаас, мөнгөлөг улиас, таримал хуш, нарс, шинэс, бут бургас буйлс, гүйлс, тэс, сухай, үхрийн нүд, чацаргана, бөөрөлзгөнө, ранетка, алим зэргийг сонгон үрсэлгээг бэлтгэх ажлыг зохион байгуулж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “100 сая мод” хөтөлбөрийн хүрээнд салбар, нэгжүүдийн төлөвлөгөөг боловсруулан баталсан. Түүнчлэн өмнө нь мод үржүүлэг болон бэлтгэлийн чиглэлээр ажиллаж байсан Төв аймаг Мөнгөнтөрүт сум дахь 417 дугаар нээлттэй хорих анги, Хархорин дахь 423 дугаар нээлттэй хорих анги, Сэлэнгэ аймаг Мандал сум дахь 413 дугаар нээлттэй хаалттай

		хорих ангиудын мод үржүүлгийг сэргээх ажил явагдаж байна. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа салбар, нэгжүүд орон нутгийн засаг, захиргааны нэгжүүдтэй мод үржүүлэхээр хамтран ажиллах талаар гэрээ, хэлэлцээр хийх ажлыг эхлүүлээд байна.
2022.06.21	Хууль сурталчлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нээлттэй хаалганы өдөрлөг	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, дүүргийн прокурорын газар болон цагдаагийн газартай хамтран хууль сурталчлах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нээлттэй хаалганы өдөрлөгийг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс болон ажил олгогч эздийн нэгдсэн холбооноос ажилгүй иргэд болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн, хорих ялаас хугацааны өмнө суллагдаж, хяналт тогтоосон иргэдийг ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулж, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас иргэдэд хууль, эрх зүйн талаар зөвлөгөө өгч ажиллажээ.
2022.06.29	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай “мод тарьж, арчлах ажил гүйцэтгэх чиглэлээр хамтран ажиллах гэрээ”	Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага “100 сая мод тарих хөтөлбөр”-ийг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд Орхон аймаг дахь ШШГГ-437 дугаар нээлттэй хорих ангиас үйлдвэрлэлийг өргөжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, хоригдолд хөдөлмөрийн чиг баримжаа олгох, хоригдлын нийгэм болон аж ахуй нэгж, иргэнд учруулсан гэм хорын төлбөрийг барагдуулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай “Мод тарьж, арчлах ажил гүйцэтгэх чиглэлээр хамтран ажиллах гэрээ” байгуулсан.

Эх сурвалж: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын цахим хуудас
<https://cd.gov.mn/ccl/0/1>

2.Гадаад орнуудын харьцуулсан судалгаа

Судалгааны өмнөх хэсэгт Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой салбар дундын бодлого, арга хэмжээг авч үзсэн билээ. Энэхүү хэсэгт гадаадын зарим улс, орнуудад хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар ямар бодлого, арга хэмжээг тогтоож, хэрэгжүүлдэг болохыг судалсан болно.

АНУ-ын хоригдлын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой салбар дундын бодлого, арга хэмжээ

Холбооны хорих ангийн товчоо (BOP) буюу АНУ-ын хорих байгууллагуудын төв байгууллагаас хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар дараах бодлогыг хэрэгжүүлдэг байна³⁷.

Дугаар	Нэр	Батлагдсан огноо
5250.02	Нийтийн ажил, нийгэмд үйлчлэх үйлчилгээний төслүүдийн талаар	10-02-2000

³⁷ BOP Policies, <https://www.bop.gov/PublicInfo/execute/policysearch>

5521.06	Хоригдол, тэдний ажлын байр, амьдардаг газрын нэгжлэгийн талаар	06-04-2015
5251.06	Хоригдлын хөдөлмөрийн хөлсний үзүүлэлтийн талаар	10-01-2008
8281.02	Хоригдлын хөдөлмөрийн үзүүлэлтийн талаар	07-31-2003
8120.03	Хоригдлуудад зориулсан ажлын хөтөлбөрийн талаар	02-23-2017

A. Нийтийн ажил, нийгэмд үйлчлэх үйлчилгээний төслүүдийн талаар бодлого

U.S.C.-ийн 18 дугаар тушаалын § 4125(a)-ын дагуу холбооны бусад агентлагт эсвэл бусад холбооны агентлагийн ажлын талбайд гүйцэтгэсэн байгууллагын үйл ажиллагааг тухайн бодлогын баримт бичгээр дараах байдлаар зохицуулсан байна.

“Ерөнхий прокурор АНУ-ын хоригдлуудыг зам барих, засварлах, нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэх, арчилж тордох, ойжуулах, далан суваг барих, барилга байгууламж барих эсвэл Конгрессоос олгосон хөрөнгөөр бүхэлд нь буюу ихэнх хэсгийг санхүүжүүлдэг бусад нийтийн ажлыг хийх зэрэгт харилцан тохиролцсон нөхцөл, үнэ ханшийн дагуу ажиллуулах бөгөөд үйлчилгээг хэд хэдэн хэлтсийн дарга нарт даалгаж болно.”

Эдгээр ажлуудыг ерөнхий байдлаар нийтийн ажил болон нийгэмд үйлчлэх үйлчилгээний ажил гэж хоёр хуваадаг.

Нийтийн ажил	Нийгэмд үйлчлэх үйлчилгээний ажил
Тогтмол цалинтай ажил	Цалингүй ажил болон сайн дурын хөтөлбөр
Тухайн газарт эсвэл гадуур ажиллах ажил	Тухайн газарт эсвэл гадуур ажиллах ажил
Холбооны агентлагийн ажил	Орон нутгийн болон ашгийн бус байгууллага
Үндэсний хэлэлцээр	Үндэсний хэлэлцээр хамаарахгүй
Бүс нутгийн хэлэлцээр	Бүс нутгийн хэлэлцээр шаардлагагүй
Бүс нутгийн захирагчид хүсэлт гаргах	Бүс нутгийн захирагчид хүсэлт гаргах
Удаан хугацааны болон богино хугацааны ажил	Богино хугацааны ажил

Б. Хоригдол, тэдний ажлын байр, амьдардаг газрын нэгжлэгийн талаар бодлого

Холбооны хорих ангиудын товчоо (BOP) нь байгууллагуудынхаа аюулгүй байдал, эмх цэгцтэй үйл ажиллагааг сайжруулахын тулд хоригдлууд болон хоригдлуудын орон сууц, ажлын байранд нэгжлэг хийж хууль бус барааг илрүүлж, нэвтрүүлэх, зөөвөрлөхөөс сэргийлдэг.

В. Хоригдлын хөдөлмөрийн хөлсний үзүүлэлтийн талаар бодлого

Хоригдлуудын ажлын үр дүн болон цалин хөлсний талаар тухайн бодлогыг тодорхойлжээ. Холбооны хорих ангиудын товчоо (BOP) нь хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар энэхүү чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

- Хоригдлуудын сул зогсолтыг бууруулж, суллагдсаны дараа ажилд ороход туслах ашигтай ажлын ур чадвар, ажлын дадал зуршил, туршлагыг сайжруулах эсвэл хөгжүүлэх боломжийг олгох арга хэмжээ;

- Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хангах ажил, арга хэмжээ;

- Бие махбодийн болон оюун санааны хувьд хөдөлмөрийн чадвартай, ял эдэлж буй хоригдлууд хөдөлмөрийн хөтөлбөрт хамрагдах ёстой. Харуулын дарга эсвэл томилогдсон албан тушаалтнуудын зөвшөөрлөөр эмчилгээний хөтөлбөр, боловсрол, мэргэжлийн сургалтыг ажлын хөтөлбөрт тооцож болно.

Хорих ангийн захирагч хоригдлын ажлын гүйцэтгэл эсвэл тодорхой засан хүмүүжүүлэх хөтөлбөрүүдэд үр бүтээлтэй оролцсон эсэхийг нь үнэлж цалин олгож болно.

Г. Хоригдлын хөдөлмөрийн үзүүлэлтийн талаар бодлого

Холбооны хорих ангиудын хөдөлмөрийн үзүүлэлтийг тодорхойлох бодлого бөгөөд ерөнхийдөө Холбооны хорих ангийн аж үйлдвэрийн (FPI) ажлын хөтөлбөрийн хэмжилт, стандартыг бий болгох зорилготой юм. Үйлдвэрлэлийн стандарт нь үйлдвэрлэлийн менежментийн дараах хүчин зүйлсээс хамаардаг.

- Хүчин чадлын төлөвлөлт;
- Хөдөлмөртэй холбоотой стандарт зардал;
- Ажиллах хуваарь;
- Үйлдвэрийн ачаалал;
- Дамжлагын стандарт;
- Ажлыг тэнцвэржүүлэгч;
- Үйлдвэрлэлийг сайжруулах арга хэмжээнүүд;

Д. Хоригдлуудад зориулсан ажлын хөтөлбөрийн талаарх бодлого

Холбооны байгууллагад хоригдож байгаа бүх хоригдлуудыг ажлын байраар хангах нь Холбооны хорих ангиудын товчоо (BOP)-ны үүрэг юм. Энэхүү ажил нь хоригдлуудад хорих ангиас чөлөөлөгдөхөд хэрэг болох мэдлэг, ур чадвар, ажлын дадал хэвшлийг эзэмших боломжийг олгох зорилготой юм. Тус бодлогын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгажээ.

- Хоригдол бүр суллагдсанахаа дараа ашиглах мэдлэг, ур чадвар, ажлын дадал зуршилтай болох;
- Хорих ангийн үйлдвэрлэлд ажиллаж буй хоригдлуудад хүрсэн түвшин эсвэл орон нутгийн дундаж цалингийн дагуу нөхөн олговор олгох;
- Хорих ангийн үйлдвэрлэлийн удирдлага нь хорих ангийн ажил эрхлэлтийн түвшинг тодорхойлон, аж үйлдвэрийн ахлах ажилтан эсвэл хамгийн өндөр албан тушаалтан тус бүртэй харилцан ойлголцлын санамж бичиг (жишээ нь, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө) боловсруулах;
- Хоригдлуудын албан тушаалыг цалин хөлсний тэгш байдал, хэмнэлт, ажиллах хүчний нөөцийн зарчимд үндэслэн зохих ёсоор ангилах;
- Элсэлтийн болон чиг баримжаа олгох хичээл бүрийн үеэр үйлдвэрийн ажлын боломжуудын танилцуулгыг хийх гэх мэт.

ХБНГУ-ын хоригдлын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой салбар дундын бодлого, арга хэмжээ

ХБНГУ-д хоригдлыг хөдөлмөрлүүлэхдээ хувийн хэвшил болон төрийн байгууллагад ажиллаж байгаагаас үл хамааран ижил нөхцөл байдлаар ажиллуулдаг байна.

John Hillebrand “ХБНГУ-ын хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн загвар, зохион байгуулалт” бүтээлдээ энэ тухай дараах байдлаар тодорхойлсон байна.

Төрийн байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагуудын хувьд үйлдвэрлэлийн болон гар урлалын үйлчилгээг үзүүлдэг байгууллагууд хорих байгууллагад байрлаж ажилладаг байна. Эдгээр нь зөвхөн халамжийн байгууллага эсвэл бусад байгууллагын хэрэгцээг хангахаас гадна чөлөөт зах зээлд бараа, материалыг нийлүүлдэг байна. Хоригдлуудыг ийнхүү ажиллуулах асуудлыг төрийн түвшинд зохицуулдаг. Эдгээр хоригдлуудыг ажиллуулах нөхцөл байдал нь бусад ижил төрлийн үйлдвэрлэлийн нөхцөл байдалтай ижил байх ёстой.

Хорих байгууллагын үйлдвэрт ажиллуулах тохиолдолд төрийн өөрийн өмчийн түүхий эд, техник хэрэгсэл хэрэглэгддэг тул эдийн засгийн эрсдэл үүсч болдог. Харин хувийн байгууллагад хоригдлуудыг ажиллуулах нь тэднийг сургах, нийгэмшүүлэх асуудалд хүндрэл учруулдаг³⁸.

Түүнчлэн хорих байгууллагаас суллагдаж буй хоригдлын талаар Холбооны бүгд найрамдах Герман улс нь бодлого хэрэгжүүлдэг. Гэхдээ тус бодлого нь байгууллагуудын хоорондын уялдаагүй байдлаас хамаараад хэрэгжихгүй байна гэж дүгнэжээ³⁹.

Норвеги улсын хоригдлын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой салбар дундын бодлого, арга хэмжээ

“Норвегийн Засан хүмүүжүүлэх албаны үйл ажиллагааны стратеги 2021-2026” гэх баримт бичигт хорих байгууллагуудад хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлсон байна.

Энэхүү бодлогын баримт бичигт дурдагдсанаар Норвегийн Засан хүмүүжүүлэх албаны стратегийн байдалд нөлөөлж буй хүчин зүйлүүд дотроос хөдөлмөрийн зах зээл өөрчлөгдөж буй нь гол хүчин зүйлүүдийн нэг болж байна⁴⁰.

Түүнчлэн тус стратегид салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн байна⁴¹.

Ерөнхий зорилтын хүрээнд	-Зорилтот салбар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх
Дэд зорилтын хүрээнд	-Салбар хоорондын уялдаатай бөгөөд үнэ цэнэтэй, ахиц дэвшлийг хангах үүднээс ажиллуулах -Төрийн бус (ТББ) болон хэрэглэгчийн байгууллагуудын үйлдвэрлэлийн үйлчилгээг хөнгөвчлөх

³⁸ Schriften zum Strafvollzug, Jugendstrafrecht und zur Kriminologie, Johannes Hillebrand, “Organisation und Ausgestaltung der Gefangenearbeit in Deutschland”, p. 33, https://rsf.uni-greifswald.de/storages/uni-greifswald/fakultaet/rsf/lehrstuehle/ls-harrendorf/Bd34_9783936999587.pdf

³⁹ Schriften zum Strafvollzug, Jugendstrafrecht und zur Kriminologie, Johannes Hillebrand, “Organisation und Ausgestaltung der Gefangenearbeit in Deutschland”, p. 102, https://rsf.uni-greifswald.de/storages/uni-greifswald/fakultaet/rsf/lehrstuehle/ls-harrendorf/Bd34_9783936999587.pdf

⁴⁰ Operational strategy for the Norwegian Correctional Service 2021 - 2026, p.15, https://www.kriminalomsorgen.no/getfile.php/4888894.823.ijuubwissujnwu/KDI_strategibrosjyre_TRYKK_FINAL2_Engelsk.pdf

⁴¹ Operational strategy for the Norwegian Correctional Service 2021 - 2026, p.23, https://www.kriminalomsorgen.no/getfile.php/4888894.823.ijuubwissujnwu/KDI_strategibrosjyre_TRYKK_FINAL2_Engelsk.pdf

	-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч байгууллагууд болон халамжийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааг өргөтгөх
--	--

Үүний дагуу Норвегийн засан хүмүүжүүлэх алба нь Норвегийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын газартай хамтран тодорхой үйл ажиллагааг зохион байгуулдаг. Үүний нэг нь "Дахин нийгэмшүүлэх арга хэмжээг зохицуулах" туршилтын хөтөлбөр юм.

Норвегийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын газар нь аль болох олон хүмүүсийг идэвхтэйгээр ажиллуулах, сайн төлөвлөлт бүхий хөдөлмөрийн зах зээлийг бий болгох, зөв үр ашигтай, хэрэглэгчдэд хүрэх зөв үйлчилгээг бий болгох, цогц хөдөлмөр, нийгмийн хамгааллын механизмыг бий болгох зорилготой.

Тус хөтөлбөр нь 2009, 2010 оноос хэрэгжиж байгаа бөгөөд нийт 6 хорих ангийг хамарч байна. Гол зорилго нь Норвегийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын газар болон Засан хүмүүжүүлэх албаны хоорондын уялдаа холбоог сайжруулах юм. Ингэхдээ:

- Хоригдлын ажил болон мэргэжлийн сургалтыг суллагдсаны дараа ажиллахаар тооцоолон ижил байдлаар зохион байгуулах;
- Өмнө нь ажил эрхэлдэггүй байсан хүмүүсийг ажлын дадал, ур чадварт сургах;
- Өмнө нь ажил эрхэлдэг байсан хүмүүсийн ажлыг аль болох хэвээр үлдээхээр зохицуулах⁴² зэргээр үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Бүгд найрамдах Эстони улсын хоригдлын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой салбар дундын бодлого, арга хэмжээ

Бүгд найрамдах Эстони улсын хувьд хоригдлын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бодлогыг харьцангуй бие даасан байдлаар хэрэгжүүлж байна. Тус улсын хорих байгууллагаас хэрэгжүүлсэн томоохон хоёр төсөл, хөтөлбөрийг доор дурдсанаар авч үзье.

Хоригдол нь хорих байгууллагаас суллагдсаны дараа буцаж хэвийн ажилдаа ороход хүндрэлтэй байдаг. Тухайлбал доромжлуулах, мэргэжлийн чадвараа алдсан байх зэрэг олон шалтгаан нөлөөлнө. Эстони улсын Айда-Вирумаа хотод зохион байгуулагдсан төслийн хүрээнд хоригдлуудыг мэргэжлийн сургалтад хамруулахаар болсон. Тус төсөл нь Европын нийгмийн сангийн дэмжлэгтэйгээр явагдсан бөгөөд хоригдлууд оёдол, гутал хийх, гагнуур, будах, мод боловсруулах чиглэлээр суралцан төгссөн.

Мөн Эстонийн хорих ангийн үйлдвэрүүд (AS Eesti Vanglatööstus) тодорхой хөтөлбөрийг авч хэрэгжүүлдэг бөгөөд үүний дагуу хоригдлуудыг бусад аж ахуй нэгжид ажиллуулахыг зөвшөөрдөг. Үүний дагуу хувийн аж ахуй нэгжүүд нь хоригдлуудад цалин өгч хорих ангиас үйлдвэр лүү зөөн ажиллуулж эхэлсэн. Энэхүү санаачилга нь хоригдлууд, орон нутгийн бизнес эрхлэгчид болон бүс нутгийн хэмжээнд бодит үр дүнд хүргэсэн⁴³.

Япон улсын хоригдлын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой салбар дундын бодлого, арга хэмжээ

⁴² Social Welfare and Labour Services in Norwegian Prisons, https://www.academia.edu/30329809/Social_Welfare_and_Labour_Services_in_Norwegian_Prisons

⁴³ European social fund, Helping prisoners get back into employment, <https://ec.europa.eu/esf/main.jsp?catId=46&langId=en&projectId=441>

Япон улсын хувьд хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг үндсэн 4 төрөлд хуваан авч үзвдэг.

1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл
2. Нийгмийн үйлчилгээний ажил
3. Мэргэжил сургалт
4. Аж ахуйн ажил

Үүнээс нийгмийн үйлчилгээний ажил нь хоригдлууд нийгэмд тустай ажил хийх, бусад салбарын байгууллагуудын үйл ажиллагааг гүйцэтгэх боломжийг олгодог. Энэхүү ажлыг хийснээр хоригдол өөрийгөө нийгмийн нэг хэсэг гэж хүлээн зөвшөөрдөг учраас тэднийг нийгэмшүүлэх гол аргын нэг юм⁴⁴. Хоригдлуудад мэргэжлийн сургалт орох болон тэднийг бусад байгууллагад ажиллуулах нь ялын нэг хэсэг учраас Япон улсын хувьд бодлогоор бус ялыг гүйцэтгэж буй нэг хэлбэр болон хэрэгжиж байна.

3. Явцын дүгнэлт, дүн шинжилгээ

Судалгааны тус бүлэгт хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаарх Монгол Улсын бодлогын баримт бичиг болон салбар дундын бодлого, арга хэмжээг судалснаас гадна гадаад улсуудын хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар судалгааг мөн хийсэн юм. Энэхүү судалгааны үр дүнг дараах байдлаар тоймлон үзүүлье.

		Судалгааны үр дүн
Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөрийн талаарх бодлого, арга хэмжээ	Монгол Улсын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах, хоригдлыг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлэх гол чиглэлийн дагуу үйл ажиллагааг явуулж байна.
	Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөрийн талаарх салбар дундын бодлого, арга хэмжээ	Хоригдлыг суллахад бэлдэх хөтөлбөрөөр хоригдлыг суллагдахад хөдөлмөрлөх дадалд сургах, мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төвийн сургалтаар хоригдож байх хугацаанд хөдөлмөрийн дадалд бэлтгэхээр үйл ажиллагааг явуулж байна. Мөн бүтээн байгуулалтын ажилд хоригдлуудыг гэрээгээр хувийн компанид ажиллуулж байна. Түүнчлэн хоригдлыг хөдөлмөрлүүлэх, хөдөлмөр дадалд сургах чиглэлээр ажлуудыг тусгайлан зохион байгуулж байна. Тухайлбал “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нээлттэй өдөрлөг гэх мэт. Өөрөөр хэлбэл салбар хоорондын хамтын ажиллагаа тодорхой хүрээнд, тодорхой түвшинд хэрэгжих эрх зүйн үндэс тавигдсан, хэрэгжилтийг эхлүүлсэн нь харагдаж байна. Гэхдээ нэгдсэн бодлого, хөтөлбөр хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар байхгүй байна.
Харьцуулсан судалгаа	Америкийн нэгдсэн Улс	Нийтийн ажил, нийгэмд үйлчлэх үйлчилгээний төслүүдийн талаар, Хоригдол, тэдний ажлын байр, амьдардаг газрын нэгжлэгийн талаар,

⁴⁴ Ministry of justice, Prison Work, https://www.moj.go.jp/EN/kyousei1/kyousei_kyousei10.html

		Хоригдлын хөдөлмөрийн хөлсний үзүүлэлтийн талаар, Хоригдлын хөдөлмөрийн үзүүлэлтийн талаар, Хоригдлуудад зориулсан ажлын хөтөлбөрийн талаар бодлогуудыг авч хэрэгжүүлж байна. Үүнээс Нийтийн ажил, нийгэмд үйлчлэх үйлчилгээний төслүүдийн талаар бодлого нь салбар дундын нийгмийн бүтээн байгуулалтыг хоригдлын хөдөлмөрийн үндсэн дээр бий болгох зорилготой чухал, цогц хөтөлбөр байна.
	Холбооны бүгд найрамдах Герман Улс	Нийтийн бүтээн байгуулалт, нийтийн үйлчилгээний чиглэлээр хоригдлуудыг ажиллуулах нь хувийн байгууллад хоригдлуудыг ажиллуулахтай ижил нөхцөл байдалтай байна. Мөн үүнээс гадна хоригдлыг суллахад бэлдэх хөтөлбөрийг тусгайлан авч үздэг байна.
	Норвеги Улс	Хоригдлын хөдөлмөрийн талаар салбар дундын бодлого, арга хэмжээг бодлогын баримт бичигт тусгасан байна. Тухайлбал Норвегийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын газартай хамтран хоригдлуудыг хоригдож байх хугацаанд болон суллагдахад хөдөлмөрийн дадал олгохоор сургалт зохион байгуулах, хоригдлуудын ажлын байрыг хэвээр хадгалах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.
	Бүгд найрамдах Эстони Улс	Хоригдлуудыг хөдөлмөрийн дадалд сургах чиглэлээр мэргэжлийн сургалтыг зохион байгуулдаг. Түүнчлэн хувийн байгууллагад ажиллуулах чиглэлээр хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлдэг байна.
	Япон Улс	Хоригдлуудад мэргэжлийн сургалт орох болон тэднийг бусад байгууллагад, нийтийн үйлчилгээ, үйлдвэрлэлд ажиллуулах нь ялын нэг хэсэг учраас Япон улсын хувьд бодлогоор бус ялыг гүйцэтгэж буй хэлбэрээр тус үйл ажиллагаа явагддаг байна.

Монгол Улсын хувьд хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар бодлогын баримт бичигт тусган, ХЗДХЯ болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тухайн чиглэлээр холбогдох журам, дүрмийг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гэхдээ хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ нь уялдаа холбоогүй, нэг удаагийн шинжтэй арга хэмжээнүүд байгааг дурдах нь зүйтэй.

Харьцуулсан судалгааны тухайд Америкийн нэгдсэн улс хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар хэд хэдэн том бодлого хэрэгжүүлж байгаа нь тодорхойлогдсон. Тухайлбал Нийтийн ажил, нийгэмд үйлчлэх үйлчилгээний төслүүдийн талаарх бодлого нь нийтийн бүтээн байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлж буй сайн жишиг болохуйц бодлого байна. Тиймээс Монгол Улс хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар бодлого, арга хэмжээг цогц байдлаар төрийн бодлого болгон хэрэгжүүлэхдээ тухайн улсаас туршлага судалж болох юм. Өөрөөр хэлбэл нийтийн бүтээн байгуулалтын чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Зам тээвэр, хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Хүнс, хөдөө аж

ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамтран салбар дундын зохицуулалтаар дээрх шиг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж болох юм. Ингэхдээ хоригдлуудыг зам барих, засварлах, нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэх, арчилж тордох, ойжуулах, далан суваг барих, барилга байгууламж барих зэрэг нийтийн үйлчилгээний чиглэлээр ажиллуулах сайн жишиг гадаад улс, орнуудад байна.

Мөн бусад улсын тухайд хоригдлын ажлын байрыг хэвээр хадгалах, мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа явуулах, хувийн байгууллагад ажиллуулах хөтөлбөр хэрэгжүүлэх гэх мэтчилэн сайн жишиг болохуйц арга хэмжээ цөөнгүй байна. Эдгээрийг Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хамтран тусгайлсан хөтөлбөр батлан хэрэгжүүлж болох юм.

ГУРАВ. БҮХ НАСААР ХОРИХ ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА

1. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлын ял эдэлж буй нөхцөл байдал, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийн байдал

Монгол Улс 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж батлахдаа цаазаар авах ялыг халж, оронд эь бүх насаар хорих ялыг хамгийн хүнд ял болгон хуульчилсан. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхлэснээс хойш шүүхээс бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн хоригдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 405 дугаар хаалттай хорих ангийн Тусгай нэгжид ял эдлүүлж байна. ХЗҮХ-ийн төслийн багийнхан ШШГЕГ-ын харьяа хорих 405 дугаар хорих ангид очиж ажиллаа. Тус хорих ангийн 2021 оны жилийн эцсээр хийсэн тоон судалгаанаас харвал 2018 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн хоригдлыг хүлээж авч ял эдлүүлж эхэлснээс 2022 оны 10 дугаар сарын 18-ны байдлаар нийт 21 хоригдол ял эдэлхээр иржээ. Үүний 7 хоригдлын ялд өөрчлөлт орсноор одоогийн байдлаар 14 хоригдол тусгай нэгжид ял эдлэж байна.

Судалгааны баг тус хорих ангид 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр ажиллан хоригдлын ял эдэлж буй нөхцөл байдалтай танилцаж, хоригдлуудаас анкетын судалгаа, ганцаарчилсан ярилцлага, алба хаагчидтай ганцаарчилсан ярилцлагыг тус тус хийсэн болно.

Анкетын судалгаанд тусгай нэгжид хоригдож буй нийт 33 хоригдол хамрагдсан. Үүнээс бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн хоригдол 11, хугацаатай хорих ялаар шийтгүүлсэн ч сахилгын зөрчил үйлдэж зэрэглэл хүндэрч тус нэгжид ирсэн 22 хоригдол байна.

Анкетын судалгааны үр дүнд тухайн хоригдлууд нь тус хорих ангид хоригдож байх хугацаандаа огт ажил хийж байгаагүй болох нь тогтоогдлоо. Харин зэрэглэл хүндэрч ирсэн хоригдлууд бүгд өмнө нь өөр хорих ангид ажил хийж байсан хэмээн хариулсан бол бүх насаар хорих ялаар шийтгүүлсэн хоригдлууд хоригдож байх хугацаандаа огт хөдөлмөр эрхэлж байгаагүй хэмээн хариулжээ.

Бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлуудаас 3 хоригдол ажил эрхлэх хүсэлтэй байгаагаа анкетийн асуулгад илэрхийлсэн байна. Мөн тус хорих ангид зэрэглэл хүндэрч ирсэн хоригдлуудаас 5 хоригдол ажил хийх хүсэлтэй байгаагаа анкетад бичсэн байна. Тэдгээрээс тухайлбал нэг хоригдол оёдол хийж чаддаг тул өрөөндөө монгол болон буриад гутал хийх хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Бүх насаар хорих ял эдэлж буй хоригдолтой хийсэн ярилцлагын хэсгээс хэсэгчлэн танилцуулбал.:

Ярилцлага

Бүх насаар хорих ялтай хоригдлыг хорих өрөөнд хөдөлмөр эрхлүүлнэ гэж хуульдаа байгаа ч одоогоор хөдөлмөр хийлгэсэн зүйлгүй байна. Ажил хөдөлмөр эрхэлвэл цаг хугацаа хурдан өнгөрч, ойр зуурын юманд зориулчих цалин орлоготой ч болох давуу талтай болно гэж бодож байна. Хэзээ нэг цагт ажил хийнэ байх гэж боддог. Оёдлын цех ч юм уу, өөр тийм цехэд бүх насаараа хоригдож байгаа биднийг ажиллуулвал үр дүнтэй байх.

Тус хорих ангийн алба хаагчидтай хийсэн ярилцлагын явцад шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш өдийг хүртэл тусгай нэгжид хоригдож буй хоригдлууд ямар нэгэн хөдөлмөр эрхлээгүй гэдэг мэдээлэл өгч байсан . Харин тус хуулиас өмнө тус анги нь гяндан байсан ба тухайн үед хэвлэлийн үйлдвэр, жаазны үйлдвэр ажиллаж байсан бөгөөд хоригдлуудыг уг үйлдвэрүүдэд ажиллуулж байжээ.

Хорих ангийн алба хаагчид тусгай нэгжид хоригдож буй хоригдлуудын аюулгүй байдлыг хангасан, нөхцөл байдалд нь тохирсон ажлын талаар идэвхтэй судалж байгаа бөгөөд өдгөө хоригдож буй хоригдлуудад хөдөлмөрлөх дадал бий болгох үүднээс цаасан урлалын хичээлийг хэд хэдэн удаа зохион байгуулсан гэдгээ ярилцлагын үеэр дурдсан юм. Судалгааны баг тусгай нэгжид нэвтрэн нөхцөл байдалтай танилцах явцад хоригдлуудын цаасаар урласан “монгол гэр” тэргүүтэй бүтээлүүдийг үзэсгэлэнгийн зориулалтаар шилэн хоргонд дэлгэн харуулсан байсан ба мөн хоригдлуудын өрөө бүрийн гадна эсрэг талын хананд байрлуулсан хоригдлуудын хувийн хэрэглэлүүдээс аяганы таг, шүдний сойз, оо тэргүүтэй ариун цэврийн хэрэгслүүдийг хийх зориулалттай энгийн хийц бүхий сав зэргийг цаасаар хийсэн байсан. Эдгээр нь хоригдлуудын хийсэн хөдөлмөрийн үр дүн гэхээсээ илүүтэй дээр дурдсан сургалтын явцад хийсэн эд зүйлүүд байлаа.

Дүгнэвэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 405 дугаар хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлууд хөдөлмөр огт эрхлэхгүй байгаад анхаарах шаардлагатай. Ялангуяа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хоригдлуудыг ажил хөдөлмөр эрхлэх боломжоор хангах нь тэдний засрал хүмүүжилд төдийгүй хохирол барагдуулалтад эерэг нөлөө үзүүлэх юм.

Хорих ангийн зүгээс хоригдлуудад хөдөлмөрлөх дадал бий болгох сургалтыг идэвхтэй зохион байгуулж, цаашид тус нэгжид ял эдэлж буй хоригдлыг боломжит ажил хөдөлмөр эрхлүүлэхээр судалж байгаа нь сайшаалтай байна.

2. Эрх зүйн зохицуулалт

Монгол Улс 2012 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд нэгдэн орсонтой холбоотойгоор конвенцын удиртгал хэсэг болон 1 дүгээр зүйлд “Энэхүү протоколд нэгдэн орсон аливаа улсын хууль тогтоомжийн хүрээнд хэнийг ч цаазалж үл болно. Оролцогч улсууд өөрийн орны хууль тогтоомжийн хүрээнд цаазаар авах ялыг халахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.” хэмээн заасан үүргийг биелүүлэхтэй холбоотойгоор шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульдаа цаазаар авах ялыг халж, бүх насаар хорих ялыг шинээр хуульчилсан.

Бүх насаар хорих ялын тухай Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлд тодорхойлж, зохицуулсан байдаг. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүнийг хорин таван жилийн хугацаанд хаалттай хорих байгууллагад тусгаарлан хорих ба уг хугацаа дууссаны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэхээр зохицуулсан байдаг. Мөн 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн хүнд бүх насаар хорих ял оногдуулдаггүй.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдсэн хүнд хорих ял ногдуулах үндсэн ялын хугацаа 20 жил хүртэл гэж заасан нь 20 жилээс цааш хугацаа байхгүй болохыг хуульчилж өгсөн. Тэгвэл Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 1.6-д бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн хорих таван жил (25 жил) хоригдосны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэнэ гэж заасан нь бүх насаар хорих ял бол онцгой төрлийн ял байхыг харуулж байгаа юм. Дэлхийн бусад улс, оронд бүх насаар хорих ял бол цаазаар авах ял бол цаазаар авах ялтай дүйцэхүйц хүнд ял гэж үздэг. Нэг талаар цаазаар авах ялд эрсдэл эндүүрэл эрсдэл эндүүрэл гарахаас урьдчилан сэргийлсэн нөгөө талаар хүний амьд явах эрхийг хангасан энэрэнгүй заалт юм.

Бүх насаар хорих ялыг Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр Хүнийг алах, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн Хүчиндэх, 12.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн Бэлгийн мөлжлөг, 13.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн Хүн худалдаалах, 19.1 дүгээр зүйлд заасан Эх орноосоо урвах, 19.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах, 19.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах, 19.5 дугаар зүйлд заасан Зэвсэгт үймээн дэгдээх, 19.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн Хорлон сүйтгэх, 20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, 29.1 дүгээр зүйлд заасан Түрэмгийлэл, эсхүл дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх, 29.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн Дайны үед хориглосон арга, хэрэгсэл хэрэглэх, 29.5 дугаар зүйлд заасан Төрлөөр устгах, 29.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн Олон улсын хамгаалалтад байдаг хүнд халдах, 29.8 дугаар зүйлд заасан Террорист үйлдэл хийх гэмт хэргүүдэд оногдуулахаар хуульчилсан. Ийнхүү Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 15 гэмт хэрэгт бүх насаар хорих ял оногдуулахаар зааснаас дөрөв нь Эрүүгийн хуулийн 19 дүгээр бүлгийн буюу Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 5 нь 29 дүгээр бүлгийн буюу Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг байна.

2.1 Хорих ял эдлүүлэх дэглэмд холбогдох асуудал

Хорих ял эдэлж байгаа хоригдлын ял эдлүүлэх хорих ангийн дэглэм, зэрэглэлийг хоригдлын үйлдсэн гэмт хэргийн шинж, хоригдлын хувийн байдал, засрал хүмүүжлийн байдлыг харгалзан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу өөрчлөх боломжтой тухай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-т заасан. Гэвч өөрчлөх эрх бүхий субъектыг заахдаа тус хуульд хийдэл бүхий заалтаар зохицуулсан байна.

206.2.Хорих ангийн дэглэмийг өөрчлөх асуудлыг энэ хуулийн 224.2-т заасан зөвлөл саналаа прокурорт гаргаж, прокурор үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт үйлдэн шүүхэд хүргүүлэн шийдвэрлүүлэх бөгөөд хорих ангийн зэрэглэлийг өөрчлөх асуудлыг энэ хуулийн 224.2-т заасан зөвлөлийн саналыг үндэслэн прокурор шийдвэрлэнэ.

Дээрх заалт нь хорих ангийн дэглэмийг өөрчлөх эрх бүхий субъект нь прокурор, шүүх аль аль нь байж болох мэтээр ойлгомжгүй агуулгатай байна. Харин мөн зүйлийн 206.8 дахь хэсэгт тус асуудлыг прокурор шийдвэрлэхээр заажээ.

А. Дэглэм хүндрүүлэхтэй холбоотой асуудал

Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 5-дахь хэсэгт “Энэ хуульд заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүнийг хаалттай хорих байгууллагад тусгаарлаж бүх насаар хорих ял эдлүүлнэ.” гэж заасан, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 199 дүгээр зүйлийн 199.1-т “...Тусгай зэрэглэл нь бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ганцаарчлан ял эдлүүлэх тусгай нэгжтэй байна.” гэж мөн тус зүйлийн 199.3-т “Хаалттай хорих ангийн тусгай нэгжид бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ял эдлүүлнэ.” гэж тус тус заасан нь хаалттай хорих ангийн тусгай нэгжид бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлоос бусад хоригдлыг ял эдлүүлэхгүй гэсэн агуулгатай зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, бүх насаар хорих ялыг гагцхүү хаалттай хорих ангийн тусгай нэгжид эдлүүлнэ, хаалттай хорих ангийн тусгай нэгжид гагцхүү бүх насаар хорих ялтай хоригдлыг ял эдлүүлнэ гэсэн үг. Энэ нь бүх насаар хорих ялыг хэрэгжүүлж буй манай улсын онцлог зохицуулалт юм.

Гэтэл тус хуулийн 206.8-д зааснаар хоригдол 1 жилийн хугацаанд хоёр, түүнээс дээш удаа сахилгын зөрчил гаргасан, эсхүл сахилгын ноцтой зөрчил гаргасан тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн тусгай зэрэглэлээс тусгай нэгжид зэрэглэл хүндрүүлэн шилжүүлэх боломжтой байна. Мөн тийнхүү зэрэглэл хүндрүүлэх асуудлыг прокурор шийдвэрлэх эрхтэй байна. Энэ нь гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг Эрүүгийн хуулиар тодорхойлогдох ёстой хэмээх Эрүүгийн хуулийн Хууль ёсны зарчимд нийцэхгүй байх бөгөөд мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зүйл заалт хоорондын нийцэлгүй байдал буюу хийдлийг бий болгож, хүний эрх зөрчигдөх эрсдлийг бий бодитой бий болгож байна.

Судалгааны баг очиж ажилласан 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар 405 дугаар хаалттай хорих ангийн Тусгай нэгжид нийт 33 хоригдол хоригдож буйгаас хугацаатай хорих ялаар шийтгүүлсэн ч сахилгын зөрчил үйлдэж зэрэглэл хүндэрч тус нэгжид ирсэн 22 хоригдол байсан болно. Тэдгээр хоригдлын хоригдож буй нөхцөл байдал, орчин нь бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлуудтай ижил байв. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр хамгийн хүнд ялыг хүлээгээгүй атал ийнхүү хамгийн хүнд ялыг эдлүүлэх ёстой тусгай нэгжид хоригдож буй нь хүний эрхийн зөрчил мөн. Гэвч энэхүү нөхцөл байдлыг бий болгож буй нь дээр дурдсанчлан хуулийн хийдэл болохоос гүйцэтгэх чиг үүрэг бүхий байгууллагын буруу биш болохыг санах нь зүйтэй.

Б. Дэглэм хөнгөрүүлэхтэй холбоотой асуудал

Дээр дурдсанчлан Эрүүгийн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудаар бүх насаар хорих ялыг гагцхүү хаалттай хорих ангийн тусгай нэгжид эдлүүлэхээр зохицуулсан.

Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 6-д зааснаар бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн хорин таван жил хоригдсоны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг

шийдвэрлэх бөгөөд уг журмаар ялтныг суллаагүй бол хоёр жил тутам энэ талаар дахин хэлэлцэх ёстой байна.

Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 206 дугаар зүйлийн 206.5 дахь хэсэгт бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил ял эдэлсэн, сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болох тухай заажээ. Энэ нь эрх зүйн хэм хэмжээ хоорондын зөрчил бий болгож хийдэл үүсгэж байна. Улмаар материаллаг хууль болон процессын хуулийн зөрчлийг бий болгож байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгасан тусгай нэгж гэх нөхцөл нь хаалттай хорих ангийн тусгай нэгж гэх зэрэглэл нь зөрүүтэй ойлголтыг бий болгож байна.

2.2. Хөдөлмөр эрхлэлт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 199 дүгээр зүйлийн 199.1, мөн зүйлийн 199.3 дахь хэсэг, 200 дугаар зүйлийн 200.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлийн тусгай нэгжид ганцаарчилсан тасалгаанд хорьж ял эдлүүлдэг.

Ийнхүү бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 199 дүгээр зүйлийн 199.6 дахь хэсэг, 200 дугаар зүйлийн 200.3 дахь хэсгүүдээр зохицуулсан байдаг ба дурдан буй 200 дугаар зүйлийн 200.3-т “Хоригдлыг зөвхөн хорих ангийн байранд хөдөлмөрлүүлж болно.” хэмээн заасан байдаг. Хуулийн энэхүү заалт нь бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлыг хөдөлмөр эрхлэхийг хориглосон агуулгагүй бөгөөд зөвхөн тодорхой байршлыг заасан буюу хорих ангийн байранд хөдөлмөр эрхлэх хууль зүйн боломж нээлттэй байна. Гэвч өмнөх хэсэгт дурдсанчлан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 405 дугаар хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлууд нь хөдөлмөр огт эрхэлдэггүй байна. Тус нөхцөл байдал нь гэм хорын нөхөн төлбөр болон хоригдлыг нийгэмшүүлэхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтын зорилгод нийцэхгүй байх тул асуудал тус бүрийг судалгааны удаах хэсэгт тухайлан авч үзсэн болно.

А. Бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлуудад гэм хорын төлбөр төлөх боломж олгохгүй байгаа нь зөрчигдсөн эрхийг сэргээх Эрүүгийн хариуцлагын зорилгод нийцэхгүй байна.

“Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал”, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”, НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор батлагдсан “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал” зэрэг олон улсын эрх зүйн баримт бичгүүд болон “Монгол Улсын Үндсэн хууль” бусад хууль тогтоомжуудад хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээн эдлүүлэх үүргийг төр хүлээсэн байдаг. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... эрхтэй”, Арван есдүгээр зүйлд “төр хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах” хэмээн тус тус заасан байна.

Эрүүгийн эрх зүйн үүднээс эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ оногдуулахаас гадна гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан эд материалын болон сэтгэл санааны гэм хорыг арилгуулах, төлүүлэх замаар зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэгдсэн байдаг. Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй Эрүүгийн хууль нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхлыг хамгаалах нэн тэргүүний зорилготой бөгөөд эрүүгийн хариуцлагын зорилгыг тус хуульд “гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино” хэмээн заасан байдаг. Өмнөх Эрүүгийн хуулиас /2002 оны Эрүүгийн хууль/ үзэл баримтлалын хувьд ялгагдах буюу дэвшилтэд шинэчлэл нь гэмт хэргээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нь эрүүгийн хариуцлагын нэгэн зорилго хэмээн үзсэн явдал юм.

Мөн түүнчлэн, Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр болох Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.6-д “Ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах, **ялтныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлнэ.**” хэмээн тусгасан.

Гэтэл шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойшхи 6 жилийн хугацаанд бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлууд огт хөдөлмөр эрхлээгүй байх бөгөөд өдгөө ч хөдөлмөр эрхлэх боломжгүй нөхцөл байдалд байна. Ийнхүү хөдөлмөр эрхлэхгүй, боломжит нөхцөлөөр хангагдахгүй байгаа нь бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлуудын хөдөлмөр эрхлэх замаар өөрийн үйлдсэн гэмт хэргийн улмаас учирсан гэм хорын төлбөрийг төлөх боломжийг хязгаарлахын зэрэгцээ хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх боломж ч мөн хязгаарлагдаж байна. Энэ нь дээр дурдсан холбогдох бүх эрх зүйн баримт бичгүүд зөрчигдөөд зогсохгүй эрүүгийн хариуцлагын зорилго ч биелэгдэхгүй байгааг харуулж байна.

Нэгэнтээ зөрчигдсөн эрхийг сэргээх үүргийг төр олон улсын эрх зүйн баримт бичгүүд, Үндсэн хууль болоод түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль, тогтоомжоор хүлээсэн байх тул Үндсэн хуулиар хүлээсэн үүрэг болоод Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлуудыг хөдөлмөр эрхлэх боломжоор хангах зайлшгүй шаардлагатай.

Б. Бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлууд хөдөлмөр эрхлэхгүй, хөдөлмөр эрхлэх боломжоор хангагдахгүй байгаа нь тухайн хоригдлын нийгэмших боломжийг хязгаарлаж байна.

Гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх нь эрүүгийн хариуцлагын нэгэн үндсэн зорилго юм. Эрүүгийн эрх зүйн үүднээс нийгэмшүүлэх зорилго нь ялтныг гэмт хэргийн хортой үр дагаврыг бүрэн ухамсарлан ойлгож, нийгэмд тогтсон хууль ёс, дэг журмыг чанд сахидаг, бусдын эрх чөлөөг хүндэлдэг, иргэнийхээ үүрэгт хүндэтгэлтэй ханддаг, шударга, зарчимч, нийгмийн идэвхтэй гишүүн болгосноор хангагддаг.

Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын нэгэн чухал зорилго нь “... гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино” гэж заасан. Өөрөөр

хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүнийг сургалт, хөдөлмөр болон бусад боломжит арга, хэлбэрээр зөв зан үйл, дадал хэвшилд сургаж нийгэмшүүлэх нь эрүүгийн хариуцлагын бие даасан, үндсэн зорилго хэмээн авч үзэх болсоныг илтгэж байна.

Эрүүгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоосон холбогдох эрх зүйн харилцааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тусгайлан зохицуулсан байдаг. Тус хуулийн 218, 219 дүгээр зүйлд нийгэмшүүлэх ажлын тухай нарийвчлан заажээ. Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын хүрээнд хоригдолд нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхижуулах, хөгжүүлэх, хууль дээдлэх төлөвшлийг бий болгоход чиглэсэн нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх бөгөөд энэ нь хорих ангид ял эдлэх бүхий л хугацааг хамарсан байдаг. Нийгэмшүүлэх ажлын хэлбэрийн хувьд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 219 дүгээр зүйлийн 219.1-т “хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, ур чадвар, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх...” гэж хөдөлмөр эрхлэхийг дэмжихэд нийгэмшүүлэх ажлыг чиглүүлсэн байна. Нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалтын хувьд 219 дүгээр зүйлийн 219.4-т зааснаар “ял эдлүүлэх ажиллагааг хөдөлмөртэй хослуулах...” байдлаар зохион байгуулах ёстой байна.

ХЗДХ-ийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/183 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Хорих ангийн дотоод журмын 13.4-т зааснаар хөдөлмөр эрхлэх саналын хуудсын дагуу хоригдлоос хөдөлмөрлөх эсэх тухай саналыг ШШГТХ-ийн 219.3-т заасны дагуу нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий хорих ангийн нийгмийн ажилтан авдаг байна. Мөн түүнчлэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/129 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Нийгмийн ажлын аргачилсан зааврын Хорих байгууллагад явуулах нийгмийн ажлын тухай зохицуулсан гуравдугаар бүлгийн 3.3 дахь хэсгийн 3.3.5 дахь хэсэгт хоригдлын нас, эрүүл мэнд, ажлын дадлага туршлага, мэргэжил, хөдөлмөр эрхлэх хүсэл, сонирхлыг харгалзан ажлын байр санал болгох хуудсыг танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулах ажлыг хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажилд багтаасан байна.

Дээрх эрх зүйн баримт бичгүүдээс харвал хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэх нь хоригдлыг нийгэмшүүлэх ажлын нэг үндсэн хэлбэр мөн байна.

Ийнхүү бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлууд хөдөлмөр эрхлэхгүй, хөдөлмөр эрхлэх боломжоор хангагдахгүй байгаа нь нэг талаас дээр дурдсан эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтэд тухайлан анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна., Нөгөө талаас эрүүгийн хариуцлагын нийгэмшүүлэх зорилго бүрэн хангагдахгүй байх нөхцөл байдал бодитоор оршиж буйг илтгэж байна.

Иймд эрх бүхий байгууллагууд бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж холбогдох хууль болоод бусад эрх зүйн актын биелэлтийг бүрэн хангуулах шаардлагатай байна.

В.Хоригдлын хөдөлмөр эрхлэлт, суллагдах боломж

3. Харьцуулсан судалгаа

Бүх насаар хорих ялыг дэлхийн улс орнууд цаазаар авах ялаас татгалзаж эхэлсэн 18 дугаар зуунаас эхлэн ялын нэгэн төрөл болгон нэвтрүүлсэн гэж үздэг. Өдгөө дэлхийн дийлэнх улс орнуудад хэрэглэгддэг хорих ялын нэг төрөл болсон. Дэлхийн 216 улс орон, нутаг дэвсгэрийн 183 нь бүх насаар нь хорих ялыг оногдуулж хэрэглэж байна.⁴⁵ 2014 оны байдлаар дэлхийн хэмжээнд 479,000 орчим хүн бүх насаар хорих ял эдэлж байна.⁴⁶ Эдгээр хүмүүсийн дийлэнх нь АНУ-ын хорих ангид хоригдож байна.

АНУ нь тус ялыг хамгийн түгээмэл байдлаар оногдуулан хэрэглэдэг улс юм. АНУ-ын Аляскаас бусад бүх мужид бүх насаар хорих ял оноож болох бөгөөд 22 мужид нь тус ялыг хугацаанаас нь өмнө суллах боломжгүйгээр хуульчилжээ. 2021 оны 2-р сарын байдлаар АНУ-ын хорих ангид хоригдож буй долоон хүн тутмын нэг нь буюу нийт 203,865 хүн бүх насаар хорих ял эдэлж байгаа тухай холбогдох судалгааны тайланд дурджээ.⁴⁷

Бүх насаар хорих ялыг хорих ялын онцгой төрөл болгон авч үзэж хуульчилсан орнууд байдаг. Үүнд: Беларусь, Хятад, Гүрж, Румын, Молдав, Польш, Орос, Латви, Тунис, Украин, Мадагаскар, Гайти, Бруней, Азербайжан, Тажикстан, Казакстан зэрэг орнууд багтах бөгөөд эдгээрээс Беларусь, Казакстан, Тажикстан улс нь тус ялыг цаазаар авах ялтай хамт альтернатив байдлаар хуульчилжээ.⁴⁸

Дэлхийн улс орнуудын хувьд бүх насаар хорих ял оногдуулж буй гэмт хэргийн төрлийг илүү өргөжүүлэх чиг хандлагатай байна. Цаазаар авах ял оногдуулдаггүй байсан гэмт хэрэгт ч бүх насаар хорих ялыг оногдуулж буй улсууд олширсоор байна. Жишээ нь, Англи, Уэльс, Колумбад хүүхдүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд бүх насаар хорих ял ногдуулдаг болсон бол, Шинэ Зеландад А ангиллын хар тамхи (метамфетамин гэх мэт) нийлүүлсэн, борлуулсан тохиолдолд бүх насаар нь хорих ял оногдуулдаг бөгөөд Хонконг, Филиппин зэрэг Азийн хэд хэдэн улсад хар тамхины наймаа, хар тамхи үйлдвэрлэсэн тохиолдолд бүх насаар нь хорих ял оноодог болжээ.

Бүх насаар хорих ял эдэлж буй хүмүүсийн нөхцөл байдал хүнд хэвээр байна. Дэлхийг хамарсан ковид 19 цар тахлын улмаас тус нөхцөл байдал улам ч дордсоор байна. Жишээ нь, Украинд 2010-2018 оны хооронд нийт 256 бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн хорих ангид нас барсан нь бүх насаар хорих ялаар шийтгэгдсэн 6 хүн тутмын нэг нь гэсэн үг юм.⁴⁹ Энэ мэтчилэн бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлуудын хорих ангид нас барах тохиолдол улам өссөн дүнтэй байна.

Бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлууд нь хоригдох хугацаандаа хөдөлмөр эрхэлдэггүй, эрхлэх боломжоор хангагдахгүй байгааг улс орнууд хэрхэн үзэж буй тухай авч үзье.

⁴⁵ Penal Reform International, Global Prison Trends 2021, Pp 18. Холбоос: <https://cdn.penalreform.org/wp-content/uploads/2021/05/Global-prison-trends-2021.pdf>

⁴⁶ Мөн тэнд.

⁴⁷ Ashley Nellis, Ph.D, No End In Sight: America's Enduring Reliance on Life Sentences, 2021. Холбоос: <https://www.sentencingproject.org/reports/no-end-in-sight-americas-enduring-reliance-on-life-sentences/>

⁴⁸ Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, УБ 2022 он, 144 дэх тал.

⁴⁹ Penal Reform International, Global Prison Trends 2021, Pp 19. Холбоос: <https://cdn.penalreform.org/wp-content/uploads/2021/05/Global-prison-trends-2021.pdf>

Бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлуудад эхний 10 жил болон нас нэмэн хөгшрөх жилүүдэд сэтгэл зүйн хувьд хамгийн хүнд байдаг. Энэ үед хорих ангийн уур амьсгал ч мөн хүндэрдэг бөгөөд үүнийг зохицуулах нь хорих ангийн удирдлагад сорилт болоод бэрхшээл болдог байна.⁵⁰

Хорих ял эдлүүлэх дэглэм нь хүний зан төлөвийг харгалзан тэдэнд боловсрол, хөдөлмөр эрхлэхэд чиглэсэн байх ёстой. Түүнчлэн, гадаад ертөнцтэй, гэр бүлтэйгээ холбогдох боломжтой байх нь зүйтэй. Ингэснээр бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлууд нь хоригдож байх хугацаандаа “хүн чанараа” хадгалах, суллагдахад бэлтгэхэд тустай.

Европын олон оронд бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлууд бусад хоригдлуудтай хамт хоригдож, хөдөлмөрлөх, сурч боловсрох болон гадаад ертөнцтэй харилцах харилцааны хувьд бусад хоригдлуудтай адил эрх эдэлдэг байна.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Европын хорооны тайланд Армени, Азербайжан, Болгар, Гүрж, Латви, Молдав, Румын, ОХУ, Турк, Украин зэрэг хэд хэдэн оронд бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлуудыг ганцаарчилан бүрэн тусгаарлан хорьж байгааг шүүмжилсэн байна. Эдгээр улсуудад болон зарим улсуудад (хамгийн хүнд дэглэмд) бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлуудыг өрөөнд нь (дангаараа эсвэл хосоор нь) өдөрт 23 цагийн турш хорьж, хоригдлуудыг хорих өрөөнөөс гарах болгонд гарыг нь гавлаж, хувцасыг нь тайлж нэгжлэг хийдэг, хорих өрөөнөөс гаднах аливаа хөдөлгөөнд хоёр офицер, харуулын нохой дагалддаг, бусад камерын бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлуудтай харилцахыг (гадаа дасгал хийх, салхилах үед гэх мэт) хориглодог. Түүнчлэн тэдгээр хоригдлуудад өрөөнөөсөө гарч ажил хийх болон бусад үйл ажиллагаанд хамрагдахыг санал болгодоггүй зэрэг муу туршлага ч байна.⁵¹

Япон болон Солонгос улсад бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлууд нь хоригдох хугацаандаа хөдөлмөр эрхэлдэггүй, эрхлэх боломжоор хангагдахгүй байх явдлыг бүх насаар хорих ялын хамгийн хүнд хэлбэр хэмээн үздэг байна.⁵² Тиймдээ ч тус улсууд нь бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлыг хөдөлмөрлүүлэх нь зүйтэй гэдэгтэй санал нэгддэг ажээ.

Хөдөлмөр эрхлэлт, боловсрол, спорт, соёлын үйл ажиллагаа, хобби нь цагийг өнгөрөөхөд тусалдаг төдийгүй сэтгэцийн эрүүл мэндийг дэмжиж, хорих ял эдлэх хугацаанд болон суллагдсаны дараа хэрэг болохуйц дасан зохицож нийгэмших чадваруудыг олгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.⁵³ Иймд бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлуудын хоригдох нөхцөлийг

⁵⁰ European Committee for the Prevention of Torture and Inhuman or Degrading Treatment or Punishment (CPT), Extract from the 25th General Report of the CPT, 2016.

Холбоос: https://rm.coe.int/16806cc447?fbclid=IwAR1QCupNgVnDiqAc_ojl-JvmubpudAQOTApWJupiibG5XKe5MhiET4UW5AM

⁵¹ Мөн тэнд.

⁵² Youjeong Jeong and Osamu Niikura, Life Imprisonment in South Korea: Law and Practice in Recent Trends, 2021.

⁵³ European Committee for the Prevention of Torture and Inhuman or Degrading Treatment or Punishment (CPT), Extract from the 25th General Report of the CPT, 2016. Холбоос: https://rm.coe.int/16806cc447?fbclid=IwAR1QCupNgVnDiqAc_ojl-JvmubpudAQOTApWJupiibG5XKe5MhiET4UW5AM

хөнгөрүүлэн сайжруулах, ялангуяа хоригдлуудад хөдөлмөр эрхлэх болон бусад нийгэмтэй харилцаа холбоотой байхад чиглэсэн үйл ажиллагаа явуулахыг дэмжих нь зүйтэй. Мөн бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлууд бусад хоригдлуудтай хамтран аль болох үйл ажиллагаа явуулах боломжтой байх нь зүйтэй юм.

ДӨРӨВ. СУРГАЛТ-ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГАД ХҮМҮҮЖИЖ БАЙГАА НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮМҮҮСИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА

1. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн байдал

ШШГЕГ-ын харьяа Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь анх 1948 оны 7 дугаар сарын 31-ний өдөр Дотоод явдлын яамны сайдын 582 тоот тушаалаар байгуулагдсан бөгөөд 2016 оноос Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Хонхор тосгонд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус байгууллага нь Шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ялаар шийтгүүлсэн өсвөр насны хүний хорих ялыг биечлэн эдлүүлэх, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, нийгэмшүүлэх зэрэг хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь 2022 оны байдлаар нийт 32 албан хаагч, Нийслэлийн 110 дугаар сургуулийн үндсэн 6, цагийн 4, нийт 10 багштайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

2022 оны эрхийн хагас жилийн байдлаар 17 хоригдол шинээр ирж, 1 хоригдлын хорих ялын хугацаа дуусч суллагдсан бол 1 хоригдол хорих ялаас хугацаанаас өмнө суллагдаж, 5 хоригдол насанд хүрэгчдийн хорих ангид шилжжээ. Тус байгууллагад 2022 оны 10 дугаар сарын байдлаар өсвөр насны эрэгтэй 30 хоригдол ял эдэлж байна. Эмэгтэй хоригдол байхгүй. Тэдгээрийг үйлдсэн гэмт хэргийн зүйл анги болон эдэлж буй хорих ялын хэмжээгээр нь ангилан дараах графикаар харууллаа.

График 1. Хорих ял эдэлж буй өсвөр насны хоригдлын үйлдсэн гэмт хэргийн зүйл ангиар ангилсан байдал.





График 2. Хорих ял эдэлж буй хоригдлыг хорих ялын хэмжээгээр ангилан авч үзсэн байдал.



Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага нь хорих ялаар шийтгүүлсэн өсвөр насны хоригдлуудын сурч, боловсрох эрхээр хангах ажлын хүрээнд тус байгууллагын дэргэдэх Нийслэлийн ерөнхий боловсролын 110 дугаар сургуулиар дамжуулан ерөнхий эрдмийн сургалтад бүрэн хамруулан ажилладаг. 110 дугаар сургууль нь Нийслэлийн боловсролын газарт харъяалагддаг бөгөөд 10 багш, захирал, санхүүгийн ажилтан зэрэг 12 ажилтны орон тоотойгоор 17 төрлийн хичээлээр сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна. 2022 оны 6 дугаар сарын байдлаар үндсэн 6, цагийн 4, нийт 10 багштайгаар сургалтын үйл ажиллагаагаа зохион байгуулж байна.

2022 оны 06 дугаар сарын байдлаар дунд ангид 6, ахлах ангид 17, нийт 23 өсвөр насны хоригдол тус байгууллагад ерөнхий боловсролын сургалтад хамрагдаж байна. Үүнээс нэг хоригдол бүрэн бус дунд боловсрол, нэг хоригдол бүрэн дунд боловсрол эзэмшжээ.

Судалгааны баг 2022 оны 06 дугаар сарын 29 болон 10 дугаар сарын 13-ны өдрүүдэд Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ажиллан өсвөр насны хоригдлын ял эдэлж буй нөхцөл байдалтай танилцаж, хоригдлуудаас анкетын судалгаа, ганцаарчилсан ярилцлагыг, алба хаагчидтай ганцаарчилсан ярилцлагыг тус тус хийсэн болно.

10 дугаар сарын 13-ны өдрийн анкетын судалгаанд нийт 15-аас 18 насны 26 өсвөр насны хоригдол хамрагдсан. Судалгаанд хамрагдсан өсвөр насны хоригдлууд бүгд /100 хувь/ хөдөлмөр эрхэлдэг эсэхийг тодруулах асуултад “Хөдөлмөр эрхэлдэггүй” хэмээн хариулсан байна. Харин тухайн байгууллагын аж ахуй, үйлчилгээнд 7 насанд хүрсэн хоригдол хөдөлмөр эрхэлж байлаа. Анкетын судалгааны энэхүү үр дүн тус байгууллагад хийсэн ажиглалтын судалгаагаар батлагдсан болно.

Мөн Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад өсвөр насны хоригдлын ял эдэлж болон суралцаж буй, аж ахуйн үйлчилгээнд ажиллаж буй хоригдлуудын хөдөлмөр эрхэлж буй орчин, нөхцөлийн хувьд яаралтай анхаарах шаардлагатай зарим тулгамдсан асуудал буй нь судалгааны явцад тогтоогдлоо.

Тус байгууллагын өдгөө үйл ажиллагаа явуулж буй барилга нь 1970-аад онд ашиглалтад орсон 8 объектоос бүрддэг ба энэхүү барилгад явагдах аливаа үйл ажиллагааг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2012, 2018, 2020 оны актаар зогсоох шийдвэр гаргасан байна.

Судалгааны багийг ажиллах явцад тус барилгын хоригдлын халуун усны зориулалтаар ашиглаж буй 1 давхар 3 өрөө объектын хана голоороо 3-4 см цуурч, дам нуруунаас дээврийн банз зарим хэсгээр мултарч ил гарсан, багана нуруу гүйж хойшилсон

буюу дээвэр хэсэгчлэн нурсан байдалтай байв. Мөн аж ахуйн үйлчилгээний хоригдол, өсвөр насны эмэгтэй хоригдол, хоригдлын гал тогоо, хувцас хадгаламжийн өрөө байрладаг байрны хананд босоо, ташуу цууралтууд үүсэж, тааз цуурсан байдалтай байв.

Энэхүү нөхцөл байдал нь тус байгууллагад сурч, хүмүүжиж буй өсвөр насны хоригдлын болон хоригдож, хөдөлмөр эрхэлж буй аж ахуйн үйлчилгээний хоригдлуудын эрх ноцтой зөрчигдөж болзошгүйг илтгэж байна.

2. Эрх зүйн зохицуулалт

Монгол Улс өсвөр насны хүнд насанд хүрэгчдээс ялгаатай байдлаар эрүүгийн хариуцлагыг хүлээлгэдэг уламжлалтай. Тухайлбал, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, тусгай байгууллагад хорих ял эдлүүлэх, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэх хугацааг хойшлуулах зэргээр эрүүгийн хариуцлагыг хүлээлгэдэг ба эдгээр зохицуулалт өдгөө ч хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн “Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх” гэх наймдугаар бүлэгт тусгайлан зохицуулсан байдаг. Тус эрх зүйн зохицуулалтаар арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй хүнийг өсвөр насны хүн гэж тодорхойлдог. Мөн арван найман насанд хүрсэн ба хорин нэгэн насанд хүрээгүй хүнд шүүхээс тус журмаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой.

Арван дөрвөөс арван зургаа хүртэл насны хүн нь Эрүүгийн хуулийн 10.1-р зүйлд заасан Хүнийг алах, 11.1-р зүйлд заасан Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, 12.1-р зүйлд заасан Хүчиндэх, 17.1-р зүйлд заасан Хулгайлах, 17.2-р зүйлд заасан Дээрэмдэх, 17.8-р зүйлд заасан Эд хөрөнгө устгах, гэмтээх, 20.7-р зүйлд заасан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, 20.16-р зүйлд заасан Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах, 26.1-р зүйлд заасан Цахим мэдээлэлд хууль бусаар халдах, 26.2-р зүйлд заасан Кибер орчинд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах, 26.3-р зүйлд заасан Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах, 29.8-р зүйлд заасан Террор үйлдэх гэмт хэргийг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой. Харин Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад дийлэнх гэмт хэрэгт арван зургаан насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Оногдуулах эрүүгийн хариуцлагын хувьд нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ял, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулах боломжтой. Шүүх эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулахдаа эдлэх ялыг хоёр дахин бага хугацаагаар оногдуулдаг.

Өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нөхцөлийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулдаг. Тус хуулийн 195-р зүйлийн 195.1 дэх хэсэгт сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагыг хорих байгууллага мөн хэмээн заагаад хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнд ял эдлүүлэх тухай

201 дүгээр зүйлийн 201.1 дэх хэсэгт “Хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хоригдлын ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ.” хэмээн заасан.

Өсвөр насны хоригдол нь сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байхдаа арван найман насанд хүрсэн бол түүний эдлээгүй үлдсэн хорих ялыг хорин нэгэн нас хүртэл сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад үргэлжлүүлэн эдлүүлэх, эсвэл насанд хүрэгчдийн хорих байгууллагад шилжүүлэн эдлүүлэх эсэхийг прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэдэг.

Манай улсад хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаарах дараах олон улсын эрх зүйн эх сурвалжууд хэрэгжиж байна. Үүнд, Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмүүд, Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд, Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц, НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрэм (журам), Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг конвенц, Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм (Бээжингийн дүрэм) зэрэг болно.

Аливаа хэлбэрээр хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах хүний эрх, үндсэн эрх чөлөөний дагуу бүх төрлийн хорих ялын тааламжгүй үр дагаварыг багасгаж, нийгмийн амьдралын наад захын хэм хэмжээнүүдийг тогтоосон Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах тухай НҮБ-ын 1955 оны дүрэмд зааснаар насанд хүрээгүй хүмүүсийн нас, хүйс, үйлдсэн гэмт хэргийн болон сэтгэл зүйн байдлыг харгалзан эрүүл ахуйн нөхцөл хангасан орчинд ял эдлүүлэх ёстой. Мөн тийнхүү хоригдож байхдаа хоригдол нь сургалтын насны хүн бол нийгэмд эргэн орох боломжоор хангахад чиглэсэн сургалтад заавал хамрагдах эрхтэй.

Тус дүрмийн 45 дугаар зүйлд “Хэрэв боломжтой бол насанд хүрээгүй хүмүүсийг мэргэжлийн сургалттай нь холбоотой тухайн орон нутагт цалин хөлстэй ажил хийлгэх бололцоо олгож суллагдсаны дараах нийгмийн амьдралд хөдөлмөр эрхлэх боломж нөхцөлийг нь нэмэгдүүлэх ёстой”⁵⁴ хэмээн өсвөр насны хоригдлыг тодорхой төрлийн хөдөлмөр эрхлэх боломжтой байхаар заасан байна. Харин уг зөвшөөрөгдсөн хөдөлмөрийн төрөл нь хоригдолд тохирсон ажил олох боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн, мэргэжлийн сургалтын нэмэлт байдалтай, нийгэм дэх ижил төстэй ажлынхтай аль болох адилхан байх, заавал цалинтай байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, хоригдлыг мэргэжил эзэмших, ял эдэлж дууссаны дараа хөдөлмөрлөх боломжтой болгоход шууд чиглэсэн хөдөлмөр эрхлүүлэхийг зөвшөөрсөн ч бусад хэлбэрээр хөдөлмөр эрхлүүлэхийг зөвшөөрөөгүй байна.

Эрүүгийн хуулийн 8.5-р зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хорих ял эдэлж байгаа өсвөр насны хүнээр хөдөлмөр эрхлүүлэхийг хориглодог. Энэ нь манай улс нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ тодорхой хэмжээгээр биелүүлж буй хэрэг юм.

⁵⁴ United Nations Rules for the Protection of Juveniles Deprived of their Liberty, Холбоос: <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/united-nations-rules-protection-juveniles-deprived-their-liberty>

Түүнчлэн, Монгол Улс нь Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай ОУХБ-ын 182 дугаар конвенцод 2001 онд нэгдэн орж, насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг 2016 онд баталж, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг 2012-2016 онд батлан хэрэгжүүлсэн. Эндээс манай улс нь хүүхдээр хөдөлмөр эрхлүүлэх явдлыг хязгаарладаг, тийнхүү хязгаарлалтыг тууштай хэрэгжүүлдэг болох нь харагдаж байна.

Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хоригдож буй өсвөр насны хоригдлууд хөдөлмөр эрхлэхгүй байгаа нь олон улсын гэрээ болон Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль, тогтоомжид нийцэж байна. Ийнхүү өсвөр насны хоригдлуудаар хөдөлмөр эрхлүүлэхгүй, хөдөлмөр эрхлэх боломжоор хангахгүй байгаа нь олон улсын гэрээ болон Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль, тогтоомжид харшлах шалтгаан үгүй байна.

ТАВ. ДҮГНЭЛТ

Энэхүү нэмэлт судалгааны ажлын хүрээнд Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлт болон хорих ангийн дэглэм, зэрэглэлийн холбоо хамаарал, хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримталж буй бодлого, бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол болон сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлын талаар судалсан. Ингэхдээ баримт бичигт судалгаа хийх, харьцуулсан судалгаа хийх, практикт дүн шинжилгээ хийх зэргээр судалгаанд дэвшүүлсэн зорилгод хүрсэн бөгөөд дараах дүгнэлтэд хүрч байна.

1. Монгол Улсын хувьд эрх зүйн зохицуулалтаар хоригдлын хөдөлмөрлөх байршил болон нөхцөлийг хорих ангийн дэглэм, зэрэглэлээс хамааруулан ялгаатай байхаар зохицуулжээ. Гэсэн хэдий ч практик судалгааг хийж үзэхэд хорих ангийн дэглэм болон хоригдлын хөдөлмөр зохион байгуулалт нь хоорондоо хамаарал багатай байгаа нь тогтоогдож байна. Мөн түүнчлэн хорих ял эдэлсэн хугацаанаас ч хоригдлын хөдөлмөр эрхлэлт хамаарал багатай болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл хорих ял эдэлж буй хоригдлуудаас эрхэлж буй ажлын төрөл, ажилладаг газар, ажилладаг өдөр, цаг, ажлын нөхцөл, цалин болон бусад зүйлүүдийн талаар асуухад хорих ял эдэлж, буй дэглэм болон хорих ял эдэлсэн хугацаанаас хамаарал багатайгаар хариултуудыг өгсөн. Харьцуулсан судалгааны үр дүнгээс авч үзвэл сонгосон улсуудын хувьд хоригдлын хөдөлмөр зохион байгуулалтыг хорих байгууллагын дэглэм, зэрэглэлээс хамааруулан зохион байгуулсан улс байхгүй байна. Өөрөөр хэлбэл хоригдлын хөдөлмөрийн талаар ерөнхий зохицуулалтууд үйлчилдэг байна. Хоригдлыг гадуур ажиллуулах тохиолдолд зарим улсад хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдэхгүй гэж үзэх нөхцөл байдлыг чухалчилдаг байна.
2. Монгол Улсын хувьд хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар бодлогын баримт бичигт тусган, ХЗДХЯ болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тухайн чиглэлээр холбогдох журам, дүрмийг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гэхдээ хэрэгжүүлж буй зарим арга хэмжээ нь уялдаа холбоогүй, нэг удаагийн шинжтэй арга хэмжээнүүд байгааг дурдах нь зүйтэй. Харьцуулсан судалгааны тухайд Америкийн нэгдсэн улс хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар хэд хэдэн том бодлого хэрэгжүүлж байгаа нь тодорхойлогдсон. Тухайлбал Нийтийн ажил, нийгэмд үйлчлэх үйлчилгээний төслүүдийн талаарх бодлого нь нийтийн бүтээн байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлж буй сайн жишиг болохуйц бодлого байна. Тиймээс Монгол Улс хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар бодлого, арга хэмжээг цогц байдлаар төрийн бодлого болгон хэрэгжүүлэхдээ тухайн улсаас туршлага судалж болох юм. Өөрөөр хэлбэл нийтийн бүтээн байгуулалтын чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Зам тээвэр, хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамтран салбар дундын зохицуулалтаар дээрх шиг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж болох юм. Ингэхдээ хоригдлуудыг зам барих, засварлах, нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэх, арчилж тордох, ойжуулах, далан суваг барих, барилга байгууламж барих зэрэг нийтийн үйлчилгээний чиглэлээр ажиллуулах сайн жишиг гадаад улс, орнуудад байна.
3. Бүх насаар хорих ялыг хэрэгжүүлж буй манай улсын онцлог зохицуулалт нь бүх насаар хорих ялыг гагцхүү хаалттай хорих ангийн тусгай нэгжид эдлүүлнэ, хаалттай хорих ангийн тусгай нэгжид гагцхүү бүх насаар хорих ялтай хоригдлыг ял эдлүүлэх явдал мөн. Эрх зүйн зохицуулалтын хийдэл нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр бүх насаар хорих ял хүлээлгээгүй атал зөвхөн тус ялыг эдлүүлэх ёстой хаалттай

хорих ангийн тусгай нэгжид хоригдох нөхцөл байдлыг бий болгож практикт хүний эрхийн зөрчлийг бий болгосон байна. Эрүүгийн хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудаар бүх насаар хорих ялыг гагцхүү хаалттай хорих ангийн тусгай нэгжид эдлүүлэхээр зохицуулсан атал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 206 дугаар зүйлийн 206.5 дахь хэсэгт бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хаалттай хорих ангийн тусгай зэрэглэлд 10 жил ял эдэлсэн, сүүлийн 1 жилийн хугацаанд сахилгын зөрчил гаргаагүй тохиолдолд хаалттай хорих ангийн энгийн зэрэглэлд шилжүүлж болох тухай заасан нь эрх зүйн хэм хэмжээ хоорондын зөрчил бий болгож хийдэл үүсгэж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 405 дугаар хаалттай хорих ангийн тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлууд хөдөлмөр эрхлэх боломжоор хангагдахгүй байгаа нь анхаарал татаж байна. Ийнхүү бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлуудад гэм хорын төлбөр төлөх боломж олгохгүй байгаа нь зөрчигдсөн эрхийг сэргээх боломжийг хязгаарлахын сацуу хоригдлууд хөдөлмөр эрхлэхгүй, хөдөлмөр эрхлэх боломжоор хангагдахгүй байгаа нь тухайн хоригдлын нийгэмших боломжийг хязгаарлаж байна. Энэ нь манай улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дотоодын эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй, эрүүгийн хариуцлагын нийгэмшүүлэх зорилго бүрэн хангагдахгүй байгааг харуулж байна. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Европын хорооны тайланд дурдсанаар хоригдлуудад хөдөлмөр эрхлэх боломж олгохгүй байх нь хоригдлын хоригдож буй нөхцөл байдал болоод нийт хорих ангийн нөхцөл байдлыг дордуулж, хүний эрхийн зөрчил үүсгэдэг болохыг онцолж бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлыг хөдөлмөр эрхлэх нөхцөл, боломжоор хангах ёстой хэмээн зөвлөсөн байна. Харин Япон болон Солонгос улсад тус ялыг эдэлж буй хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэхгүй байхыг тус ялын хамгийн хүнд хэлбэр хэмээн үзэж хөдөлмөр эрхлүүлэх нь зүйтэй гэж санал нэгтгэйгээр үзэх болсон байна.

4. Сургалт–хүмүүжлийн тусгай байгууллагад хоригдож буй өсвөр насны хоригдлууд хөдөлмөр эрхлэхгүй байгаа нь олон улсын гэрээ болон Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль, тогтоомжид нийцэж байна. Ийнхүү өсвөр насны хоригдлуудаар хөдөлмөр эрхлүүлэхгүй, хөдөлмөр эрхлэх боломжоор хангахгүй байгаа нь олон улсын гэрээ болон Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль, тогтоомжид харшлах шалтгаан үгүй байна.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Монгол Улс дахь хоригдлын хөдөлмөр эрхлэлт болон хорих ангийн дэглэм, зэрэглэлийн холбоо хамаарал, хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс баримталж буй бодлого, бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол болон сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлын талаар дээрх дүгнэлтэд үндэслэж дараах зөвлөмжийг гаргаж байна.

1. Сургалт–хүмүүжлийн тусгай байгууллага болон хаалттай хорих байгууллагын тусгай нэгжийн хоригдлуудаас бусад хоригдлуудыг хөдөлмөр эрхлүүлэхдээ ялгамжгүй байдлаар хандах нь олон улсын жишиг болж байна. Гэхдээ хоригдлыг гадуур ажиллуулах тохиолдолд дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх нөхцлийг чухалчлах нь зүйтэй. Монгол Улсын хувьд практикт хоригдлыг хөдөлмөрлүүлэхдээ ял эдэлж буй дэглэм, зэрэглэл болон хорих ял эдэлсэн хугацаанаас нь хамааралгүйгээр

хөдөлмөрийн нөхцөлд ажиллуулдаг байна. Гэвч үүнийг хууль дээр хоригдлын ял эдэлж буй дэглэм, зэрэглэлээс хамааруулан зохицуулахаар хуульчилжээ. Иймд энэхүү зохицуулалтыг өөрчлөн гадуур ажиллаж буй хоригдлууд, Сургалт–хүмүүжлийн тусгай байгууллага болон хаалттай хорих байгууллагын тусгай нэгжийн хоригдлуудаас бусад хоригдлуудын хөдөлмөрийн нөхцлийг ялгамжгүй байдлаар зохицуулах нь зүйтэй.

2. Монгол Улсын хувьд хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар бодлогын баримт бичигт нарийвчлан зохицуулж, нийтийн ажил, үйлчилгээний талаар салбар дундын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хууль зүй, дотоод хэргийн яам, Зам тээвэр, хөгжлийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамтран салбар дундын зохицуулалтаар дээрх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж болох юм. Ингэхдээ хоригдлуудыг зам барих, засварлах, нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэх, арчилж тордох, ойжуулах, далан суваг барих, барилга байгууламж барих зэрэг нийтийн үйлчилгээний чиглэлээр ажиллуулах сайн жишигийг дагах нь зүйтэй.
3. Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 206 дугаар зүйлийн 206.2 дахь хэсэг, тус зүйлийн 206.5 дахь хэсэг нь хэм хэмжээ хоорондын зөрчил, хийдлийг бий болгож байх тул уг зүйл заалтуудыг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зөрчил, хийдлийг арилгах нь зүйтэй.
4. Хорих ялын дэглэмийг өөрчлөх эрх бүхий субъектыг тодорхой бус, ойлгомжгүй зохицуулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 206 дугаар зүйлийн 206.2 дахь хэсгийг өөрчлөн найруулах шаардлагатай байна.
5. Шүүхээс тогтоосон тусгаарлах заалтыг хорих ангийн дарга эсвэл прокурорын шийдвэрээр өөрчлөх боломжтой болгож заасан нь буруу жишиг бий болох үндсийг тавьсан заалт учраас тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлыг зэрэглэл бууруулах асуудлыг шүүх шийдвэрлэж байхаар хуульчлах шаардлагатай байна.
6. Цаазаар авах ялыг бүх насаар хорих ялаар сольсон нэг агуулга нь: тэднээр хөдөлмөр эрхлүүлж цалин орлоготой байлгаснаар хохирогчид учирсан гэм хорын төлбөрөөс бага боловч төлүүлэх, хохирогчийн ойрын төрөл садан гэр бүлээс нь уучлалт гуйлгах, хоригдол өөрийнхөө гэм буруугаа ухамсарлах, 25 жил ял эдэлсний дараа нийгэмд эргэн нэгдээд идэвхитэй амьдрах хуулийн энэрэнгүй бодлого юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгасан тусгай нэгж гэх нөхцөл нь хорих ангийн дэглэм эсвэл зэрэглэлд хамаарах эсэх нь эрх зүйн томъёоллын хувьд тодорхой бус байна.
7. Тусгай нэгжид ял эдэлж буй хоригдлын зэрэглэл бууруулах асуудлыг шүүн шийдвэрлэж байхаар хуульчлах шаардлагатай байна.
8. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүн хорин таван жил хоригдсоны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ялтны хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэнэ гэсэн байх бөгөөд хэрэв шүүх сулласан тохиолдолд тухайн этгээдэд хэрхэн хяналт тавих, ямар шаардлага тавих асуудал эрх зүйн зохицуулалтын гадна үлдсэн байна. Энэхүү хийдлийг журамлан нөхөх асуудлыг шийдвэрлэх шаардлага үүсч байна.
9. Эрх бүхий байгууллагууд бүх насаар хорих ял эдэлж буй хоригдлын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах, түүнчлэн эдгээр хоригдлын ял эдлүүлэх нөхцөлийг хаалттай дэглэмийн тусгай зэрэглэлийнхээс хатууруулахгүй, нэмж хязгаарлахгүй байхад анхаарах нь зүйтэй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиа хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байна.

10. Олон улсын гэрээ, конвенци болон үндэсний хууль тогтоомжоор хориглосон, хязгаарласнаас бусад, насанд хүрээгүй хүний нас, биеийн онцлогт тохирсон ажил, хөдөлмөр эрхлүүлэх замаар хөдөлмөрийн зөв дадалд сургах, суллагдсаны дараа нийгэмд бие даан амьдрах чадварт сургах зэргийг хөхүүлэн дэмжсэн уян хатан эрх зүйн орчин шаардлагатай байна.

ЭХ СУРВАЛЖ

1. ХУУЛЬ ТОГТООМЖ

Монгол хэлээр:

1. Үндсэн хууль, (1992)
2. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/, (2015)
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/, (2017)
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, (2002)
5. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр
6. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
7. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн А/167, А/233 хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Хоригдлыг суллахад бэлдэх хөтөлбөр”
8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 9-ний өдрийн А/46 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн сургалт зохион байгуулах журам”
9. Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт”
10. ХЗДХ-ийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/183 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Хорих ангийн дотоод журам.
11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/129 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Нийгмийн ажлын аргачилсан заавар.

Гадаад хэлээр:

1. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, (1948 он).
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, (1966 он).
3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протокол, (1989 он).
4. НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал,
5. НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрэм, (1990 он).
6. Prison Act of 16 March 1976 (Federal Law Gazette Part I p. 581, 2088), as last amended by Article 1 of the Act of 19 June 2019 (Federal Law Gazette I p. 840)
7. Imprisonment Act (Passed 14.06.2000, RT I 2000, 58, 376, Entry into force 01.12.2000), <https://www.riiqiteataja.ee/en/eli/504112013005/consolide>
8. Penal code (Act No.45 of 1907), <https://www.cas.go.jp/jp/seisaku/hourei/data/PC.pdf>

2. НОМ, СУРАХ БИЧИГ, СУДАЛГААНЫ ТАЙЛАН, ЭМХЭТГЭЛ

Монгол хэлээр:

1. 2019, 2021, 2022 оны холбогдох сарын хоригдлын хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, нэрийн дансны мэдээлэл
2. “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2020”, (УБ, 2021)
3. А.Лхагваа, “Монгол Улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй”, (УБ, 2004)
4. Д.Баярсайхан, “Эрх зүйн онол”, (УБ, 2020)
5. М.Алтан-Очир, “Хорих ял эдлүүлэх дэглэм”, (УБ, 2020)
6. Д.Баярсайхан, “Харьцуулсан эрүүгийн эрх зүй”, (УБ, 2022)
7. С.Нарангэрэл болон Ж.Эрдэнэбулган, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, (УБ, 2019)

Гадаад хэлээр:

1. Federal Statistical Office Germany, penal system - demographic and criminological characteristics of the prisoners on 31.03. - Subject series 10 row 4.1 – 2021
2. Schriften zum Strafvollzug, Jugendstrafrecht und zur Kriminologie, Johannes Hillebrand, “Organisation und Ausgestaltung der Gefangenenarbeit in Deutschland”, p. 182, https://rsf.uni-greifswald.de/storages/uni-greifswald/fakultaet/rsf/lehrstuehle/ls-harrendorf/Bd34_9783936999587.pdf
3. The Norwegian correctional service, 2020 Annual report
4. Correction bureau, Ministry of justice of Japan, Penal institution in Japan, <https://www.moj.go.jp/content/001314589.pdf>
5. Schriften zum Strafvollzug, Jugendstrafrecht und zur Kriminologie, Johannes Hillebrand, “Organisation und Ausgestaltung der Gefangenenarbeit in Deutschland”, https://rsf.uni-greifswald.de/storages/uni-greifswald/fakultaet/rsf/lehrstuehle/ls-harrendorf/Bd34_9783936999587.pdf
6. Operational strategy for the Norwegian Correctional Service 2021 - 2026, https://www.kriminalomsorgen.no/getfile.php/4888894.823.ijuubwissujnwu/KDI_strategibrosjyre_TRYKK_FINAL2_Engelsk.pdf
7. Youjeong Jeong and Osamu Niikura, Life Imprisonment in South Korea: Law and Practice in Recent Trends, 2021.

3. ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ

Монгол хэлээр:

1. “Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт эхэллээ”, <https://montsame.mn/mn/read/292070>, Сүүлд үзсэн: 2022.10.27

Гадаад хэлээр:

1. World prison brief: United States, <https://www.prisonstudies.org/country/united-states-america>
2. Organization, mission and functions manual: federal bureau of prisons, <https://www.justice.gov/doj/organization-mission-and-functions-manual-federal-bureau-prisons>
3. About Our Facilities, https://www.bop.gov/about/facilities/federal_prisons.jsp
4. Prison Security Levels | Inmate Classification Levels, <https://federalcriminaldefenseattorney.com/prison-life/prison-security-levels/#minimum-security-prisons>

5. Breaking Down the Different Types of Prisons in America, <https://www.rasmussen.edu/degrees/justice-studies/blog/different-types-of-prisons/>
6. Prison labor in the united states: an investor perspective, <https://missioninvestors.org/sites/default/files/resources/Prison%20Labor%20in%20the%20United%20States%20-%20An%20Investor%20Perspective.pdf>
7. World prison brief: Germany, <https://www.prisonstudies.org/country/germany>
8. Verzeichnis der Vollzugsanstalten in der Bundesrepublik Deutschland, https://justiz.de/online Dienste/vollstreckungsplaene/vollzugsanstalten_deutschland.pdf
9. Justizvollzugsanstalt Darmstadt. Arbeit der Gefangenen, <https://justizvollzug.hessen.de/justizvollzug/jva-darmstadt/ausgestaltung-des-vollzuges/arbeit-der-gefangenen>
10. Arbeit für Gefangene, https://www.justizvollzugsanstalt-hannover.niedersachsen.de/startseite/arbeit Produktion/arbeit_fur_gefangene/arbeit-fuer-gefangene-82259.html
11. World prison brief: Norway, <https://www.prisonstudies.org/country/norway>
12. Organisation of Norwegian correctional service, <https://www.kriminalomsorgen.no/informasjon-paa-engelsk.536003.en.html>
13. Type fengsel og soningsformer, <https://www.kriminalomsorgen.no/type-fengsel-og-sikkerhetsnivaa.516316.no.html>
14. Arbeids- og aktivitetstilbud, <https://www.kriminalomsorgen.no/arbeids-og-aktivitetstilbud.527951.no.html>
15. Norway prison, <https://www.prison-insider.com/countryprofile/prisons-norway2019?s=vie-quotidienne#vie-quotidienne>
16. World prison brief: Estonia, <https://www.prisonstudies.org/country/estonia>
17. Justiitsministeerium, institution, <https://www.vangla.ee/en/intitutions>
18. World prison brief: Japan, <https://www.prisonstudies.org/country/japan>
19. Penal Institutions (Prisons / Juvenile Prisons / Detention Houses), https://www.moj.go.jp/EN/kyousei1/kyousei_kyousei03.html
20. BOP Policies, <https://www.bop.gov/PublicInfo/execute/policysearch>
21. Social Welfare and Labour Services in Norwegian Prisons, https://www.academia.edu/30329809/Social_Welfare_and_Labour_Services_in_Norwegian_Prisons
22. European social fund, Helping prisoners get back into employment, <https://ec.europa.eu/esf/main.jsp?catId=46&langId=en&projectId=441>
23. JAPAN: Ministry of justice, Prison Work, https://www.moj.go.jp/EN/kyousei1/kyousei_kyousei10.html
24. Penal Reform International, Global Prison Trends 2021, 2021, <https://cdn.penalreform.org/wp-content/uploads/2021/05/Global-prison-trends-2021.pdf>
25. Ashley Nellis, Ph.D, No End In Sight: America's Enduring Reliance on Life Sentences, 2021. <https://www.sentencingproject.org/reports/no-end-in-sight-americas-enduring-reliance-on-life-sentences/>
26. European Committee for the Prevention of Torture and Inhuman or Degrading Treatment or Punishment (CPT), Extract from the 25th General Report of the CPT, 2016., https://rm.coe.int/16806cc447?fbclid=IwAR1QCupNgVnDqAc_ojI-JvmubpudAQOTApWJupiibG5XKe5MhiET4UW5AM